

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙГ ХҮЧИТГЭХ ЗАМААР
АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ УРТАСГАХ
ТУРШИЛТЫН ТӨСӨЛ**

(ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ)

ТӨГСГӨЛИЙН ТАЙЛАН

2021 ОН 4 САР

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА (ЖАЙКА)

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1
УДИРТГАЛ	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	16
ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААРХ СУДАЛГАА, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	16
ХОЁРДУГААР БҮЛЭГ	31
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОДОО МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ТОГТООМЖИНД ОРУУЛАХ САНАЛ	31
ГУРАВДУГААР БҮЛЭГ	39
ХҮЧИТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	39
ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ХҮЧИТГЭХ ЖУРАМ	41
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	48
ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТ ТЭСВЭРЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	48
ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙ БАРИЛГЫН ГАЗАР ХӨДЛӨЛТ ТЭСВЭРЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	48
“МОНГ-ЭМ” ХХК-ИЙН ЭМНЭЛГИЙН БАРИЛГЫН ГАЗАР ХӨДЛӨЛТ ТЭСВЭРЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	57
ТАВДУГААР БҮЛЭГ	75
МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТЫГ БОЛОВСРУУЛАХ БА ЭРЭМБЭЛЭХ	75
ШИНЭЭР ХАМГААЛАЛТАД АВАХ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ	89
ХҮЧИТГЭХ ШААРДЛАГАТАЙ ДУРСГАЛТ БАРИЛГА БАГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ	99
ЗУРГААДУГААР БҮЛЭГ	106
ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ҮНЭЛЭХ	106
ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР	110
ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	119
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	122

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЖАЙКА	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага
БХТ	Барилгын хөгжлийн төв
СӨҮТ	Соёлын өвийн үндэсний төв
НЗДХА	Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХБХГ	Хот байгуулалт, хөгжлийн газар
БЧАБХХ	Барилгын чанар аюулгүй байдлын хяналтын хэлтэс
МУШУТИС	Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
БАС	Барилга, Архитектурын сургууль
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ДБЭТ	Дуурь бүжгийн эрдмийн театр
ХУБТ	Хүүхдийн урлан бүтээх төв
ЧЛСМ	Чойжин ламын сүм музей

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Төсөл хэрэгжүүлэх улс, орон

Монгол Улс

2. Төслийн нэр

Монгол Улсын түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл

3. Төслийн үргэлжлэх хугацаа (төлөвлөсөн ба бодит)

Төлөвлөсөн: 2020 оны 12 сарын 24 – 2021 оны 3 сарын 17

Бодит: 2020 оны 12 сарын 24 – 2021 оны 4 сарын 17

4. Төслийн зорилт болон хүлээгдэж буй үр дүн

Туршилтын төслийн зорилго нь БХБЯ болон БХТ-ийн холбогдох мэргэжилтнүүдийн түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийн аюулгүй байдал, менежментийн талаарх мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэхэд оршино.

Монгол Улсын түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжтай холбоотой дараах үр дүн хүлээгдэж байна.

- 1) Барилга, байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэртэй байдал, аюулгүй байдалтай холбоотой одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийг судлах;
- 2) Аюулгүй, газар хөдлөлтөд тэсвэртэй барилга, байгууламжийг хүчитгэхэд шаардлагатай хууль эрх зүйн шинэчлэлийн санал боловсруулах;
- 3) Хүчитгэх, хадгалах, эсхүл буулгаж шинэчлэн барьж байгуулах үнэлгээний арга, сонгох шалгуурыг боловсруулах;
- 4) Хүчитгэх, хадгалах, эсхүл буулгаж шинэчлэн барьж байгуулах дүрэм, журам, стандарт, үйл ажиллагааны журмыг боловсруулах;
- 5) Хүчитгэх, хадгалах, эсхүл буулгаж шинэчлэн барьж байгуулах барилга, байгууламжийг эрэмбэлэх.
- 6) Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үнэлэх /1-3 барилга байгууламж/;

5. Төсөл хэрэгжүүлэх бүтэц

БХБЯ-ны удирдлага дор БХТ, НЗДХА-ХБХГ-аас холбогдох мэргэжилтнүүдийг томилж ЖАЙКА-гийн мэргэжлийн багтай нягт хамтран ажиллана.

ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар	
Албан тушаал	Овог нэр
Төслийн ахлагч	Цүёоши Хашимото /TSUYOSHI HASHIMOTO/
Монголын талын ахлагч	Ц.ТУНГАЛАГ

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

ЖАЙКА-гийн мэргэжлийн баг		
Албан тушаал	Мэргэжил	Овог нэр
Зөвлөх	Япон улсын Зөвлөх инженер	
Багийн ахлагч	Магистр, МУ-мэргэшсэн инженер	А.АРИУНБОЛД
Архитектор	Доктор (PhD) МУ-ын Зөвлөх архитектор	З.ОЮУНБИЛЭГ
Түүхч	Доктор (PhD) Соёл судлаач	Г.ЭНХБАТ
Инженер	Магистр, МУ-мэргэшсэн инженер	С.ПҮРЭВДОРЖ
Инженер	Магистр, МУ-мэргэшсэн инженер	Б.ГАНБАЯР
Хуульч	Магистр, хуульч	Д.МОНГОЛЖИНГОО
Хуульч	Магистр, хуульч	Д.ХҮДЭРЦЭЦЭГ
Орчуулагч	Магистр, орчуулагч	Г.БАТЗАЯА

Хамтран ажилласан		
Байгууллага	Албан тушаал	Овог нэр
БХБЯ	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Д.ГАНТУЛГА
БХБЯ	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	О.БАЯРБААТАР
БХТ	Норм нормативийн хэлтсийн мэргэжилтэн /Зөвлөх инженер/	С.АРИУНЖАРГАЛ
НЗДТГ-ХБХГ	Барилгын чанар аюулгүй байдлын хэлтсийн дарга	Ж.МӨНХ-ЭРДЭНЭ
НЗДТГ-ХБХГ	Барилгын чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Д.ӨЛЗИЙЖАРГАЛ
Чойжин ламын сүм музей	Захирал	Д.ОТГОНСҮРЭН
Дуурь бүжгийн эрдмийн театр	Үйлчилгээ, аж ахуй хариуцсан дэд захирал	Х.ОДГЭРЭЛ
Хүүхдийн урлан бүтээх төв	Захирал	Д.УРАНБИЛЭГ
Улаанбаатар хотын музей	Эрдэм шинжилгээний ажилтан	Г.ОЧБАЯР
Монголор барилга Монг-Эм ХХК	Захирал	З.МЭНДСАЙХАН

6. Үйл ажиллагаа

Төслийн багийн үйл ажиллагааны хэрэгжилт, төслийн багийн хурал, уулзалт, сургалт семинарыг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.


№	Хурал, уулзалт, сургалт семинар	Хэрэгжсэн огноо	Тойм
1	БХБЯ, Төсөл эхлүүлэх хурал	2020-12-28	Төслийн ажлыг эхлүүлэх, ажлын даалгаврын талаарх ойлголтыг нэгтгэх
2	Төслийн багийн хурал	2021-01-14	Судалгааны ажлын явцын мэдээлэл солилцох, хэлэлцэх
3	Эхлэлийн тайлан	2021-01-21	Төслийн эхлэлийн тайланг бэлтгэж БХБЯ-нд хүргүүлсэн.
4	НЗДХА-ХБХГ	2021-02-01	Барилгын чанар аюулгүй байдлын хэлтсийн дарга Ж.Мөнх-Эрдэнэтэй

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

			мэдээлэл солилцож хамтран ажиллахаар тохиролцов.
5	Чойжин ламын сүм музейн захирал Д.Отгонсүрэнтэй ажлын хэсэг уулзалт хийв.	2021-02-05	Хариуцаж буй музейн барилгын талаар мэдээлэл авч, төслийн талаар мөн боловсруулж буй журам, зааврыг танилцуулж санал солилцов.
6	Барилгын нөхцөл байдлын судалгаа	2021-02-05	Боловсруулсан Түүх, соёлын дурсгалт барилга байгуулалмж тодорхойлох зааврын дагуу Чойжин ламын сум музей, Улаанбаатрын музей, Гоожингийн өндөр барилгад үнэлгээ хийж туршив.
7	Төслийн багийн хурал	2021-02-05	Төслийн багийн ажлын явц төлөвлөгөөний хэрэгжилт, судалгааны ажлын талаар санал солилцов.
8	Явцын тайлан	2021-02-07	Явцын тайланг боловсруулж БХБЯ-нд хүргүүлэв.
9	Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын нөхцөл байдлын судалгаа хийж, удирдлагатай уулзалт хийв.	2021-02-10	Боловсруулсан Түүх, соёлын дурсгалт барилга байгуулалмж тодорхойлох зааврын дагуу барилга дээр туршилтын үнэлгээ хийв. Аж ахуй хариуцсан дэд захирал Х.Одгэрэлтэй уулзаж барилгын талаар мэдээлэл авч, төслийн ажлын талаар санал солилцсон.
10	Төслийн багийн хурал	2021-02-17	Төслийн багийн ажлын явц төлөвлөгөөний хэрэгжилт, судалгааны ажлын талаар санал солилцов.
11	Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга дээр нөхцөл байдлын судалгаа хийж, удирдлагатай уулзалт хийв.	2021-02-26	Боловсруулсан Түүх, соёлын дурсгалт барилга байгуулалмж тодорхойлох зааврыг барилга дээр туршилтын үнэлгээ хийв. Захирал Д.Уранбилэгтэй уулзаж барилгын талаар мэдээлэл авч, төслийн ажлын талаар санал солилцов.
12	Төслийн багийн хурал	2021-02-26	Төслийн багийн ажлын явц төлөвлөгөөний хэрэгжилт, судалгааны ажлын талаар санал солилцсон.
13	Төслийн багийн хурал	2021-03-12	Төслийн багийн төлөвлөгөөт хурлыг хийж ажлын хэрэгжилт, судалгааны, зохион байгуулах сургалтын талаар хэлэлцсэн.
14	Сургалт “Түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийг хамгаалах, хүчитгэх асуудалд”	2021-03-29	БХБЯ, СЯ, ШУА, МХЕГ, БХТ болон аймаг, нийслэлийн барилгын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдэд сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулж нийт 36 хүн хамрагдав. Хүсэлт гаргасан бүх байгууллагад хичээлийн линкийг явуулав.
15	Төслийн багийн хурал	2021-03-30	Боловсруулсан журам, заавар, хуульд тусгах нэмэлт санал зэргийн эцсийн найруулгыг гүйцэтгэж төгсгөлийн тайлан бэлтгэх талаар хэлэлцэж санал солилцсон .

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Төслийн үйл ажиллагааны зураг:




Зураг 1. Төслийн багийн хурал, 20/12/28



Зураг 2. Төслийн багийн хурал, 21/01/14



Зураг 3. Төслийн багийн хурал, 21/01/28



Зураг 4. Төслийн багийн хурал, 21/02/17




Зураг 5. Төслийн багийн хурал, 21/02/26



Зураг 6. Төслийн багийн хурал, 21/03/12

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Төслийн үйл ажиллагааны зураг:



Зураг 7. Төслийн багийн хурал, 21/03/27




Зураг 8. Улаанбаатар хотын музей




Зураг 9. ДБЭТ-ын барилга ар тал



Зураг 10. ДБЭТын барилгын суурь



Зураг 11. ХУБТ-ийн нүүр тал



*Зураг 12. ХУБТ-ийн барилгын ханын
цууралт*

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*



Зураг 13. Чойжин ламын сүм музей



Зураг 14. ЧЛСМ-н тоосгон ханын цууралт



Зураг 15. Монголор барилга




Зураг 16. Гooжингийн өндөр

Төслийн хүрээнд зохион байгуулсан “Түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийг хамгаалах, хүчитгэх асуудалд” сэдэвтэй сургалтанд хамрагдсан мэргэжилтнүүдийн жагсаалт:

№	Нэрс	Харъяалагдах байгууллага
1	Д. Гантулга	БХБЯ
2	О.Баярбаатар	БХБЯ
3	Т.Батцэнд	БХБЯ
4	О.Мэндсайхан	Соёлын яам
5	Ж.Мяндас	Соёлын яам
6	П.Алдармөнх	Соёлын яам
7	Т.Батбаяр	ШУА-ийн Археологийн хүрээлэн
8	Т.Билэгсайхан	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн
9	Б.Батцоож	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн
10	Б.Очир	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн
11	Ц.Цэрэнбадам	БХТ
12	Б.Ардабек	ХБХГ, БЧАБХ
13	Ц.Хулан	ХБХГ, БЧАБХ
14	Д.Өлзийжаргал	ХБХГ, БЧАБХ
15	М.Оюунтулга	Соёлын өвийн үндэсний төв
16	Б.Амгаланбат	Соёлын өвийн үндэсний төв
17	Дэлгэрдалай	Архангай аймаг, ГХБХБГ

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

18	Маахүү	Архангай аймаг, ГХБХБГ
19	Ө.Хандармаа	Баянхонгор аймаг, ГХБХБГ
20	Б.Мөнгөнтосос	Дархан-Уул аймаг, ГХБХБГ
21	П.Дэлгэрхүү	Дорноговь аймаг, ГХБХБГ
22	Мэргэжилтнүүд	Дундговь аймаг, ГХБХБГ
23	Б.Сумъяацэрэн	Өвөрхангай аймаг, ГХБХБГ
24	Ц.Идэрхүү	Өмнөговь аймаг, ГХБХБГ
25	Д.Алтансүх	Төв аймаг, ГХБХБГ
26	Б.Хангал	Сэлэнгэ аймаг, ГХБХБГ
27	Мэргэжилтнүүд	Газрын алба
28	А.Эрдэнэцэцэг	Архитектор
29	Т.Эрдэнэцогт	БНСУ Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн
30	Цэнд-Аюуш Бадмаев	
31	Ц.Тунгалаг	ЖАЙКА төсөл
32	А.Ариунболд	ЖАЙКА төсөл
33	З.Оюунбилэг	ЖАЙКА төсөл
34	Г.Энхбат	ЖАЙКА төсөл
35	С.Пүрэвдорж	ЖАЙКА төсөл
36	Б.Ганбаяр	ЖАЙКА төсөл
37	Д.Монголжингоо	ЖАЙКА төсөл
38	Д.Хүдэрцэцэг	ЖАЙКА төсөл
39	Г.Батзаяа	ЖАЙКА төсөл



Зураг 15. Сургалт

УДИРТГАЛ

Монгол ард түмний олон үеийн оюун ухаан, уран гараар бүтсэн түүх, соёлын өвийг манай үндэсний төдийгүй улс тивийн соёл, иргэншлийн нэгэн гэж үзэн төрийн хамгаалалтад байлгадаг бөгөөд соёлын өвөө хадгалж хамгаалан, судлан сурвалжилж, сурталчлан, сэргээн засварлаж хойч үедээ өвлүүлэн үлдээх нь өнө холын түүхийг эргэн харах, дэлхийн соёлын сан, шинжлэх ухаанд өөрийн хувь нэмрээ оруулах, өдгөө үеийнхнийг өвөг дээдсийн уламжлалаар хүмүүжүүлэх зэрэг танин мэдэхгүй, түүх, шинжлэх ухааны ач холбогдолтой билээ.

Монголын төр, засгийн үндэсний соёлын бодлогын нэгэн гол асуудал бол түүх, соёлын хосгүй үнэт өв дурсгал, эд өлгийн болон утга соёлын өвийг эрэн сурвалжилж, судлан шинжилж, бүртгэн баримтжуулж, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, өсвөр үеийнхэнд эх оронч үзэл, түүхэн ухамсар, үндэсний бахархлыг бий болгох улмаар улс орныхоо өнгөрсөн түүхийг баталгаажуулах, дэлхий дахинаа сурталчлан таниулах цогц бодлого, үйл ажиллагаа явуулахад оршино.

Анх 1924 онд “Хуучин зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг батлан гаргаж, Монгол Улсын хязгаар дотор буй хуучны дурсгал болох зүйл цөм Монгол улсын өөрийн хөрөнгө болох, хуучны дурсгал гэж эх түүхэнд холбогдох ямар зүйлийг хэлэхийг тодорхойлон, газрын дээр буюу доороос археологийн дурсгалт зүйлийг ухаж авах, судлан шинжлэх явдлыг Судар бичгийн хүрээлэнгээс удирдаж, харгалзан хянах, зөвшөөрөл олгох, энэ дүрмийг зөрчөгчид буй аваас шүүх цаазны зохих зүйлийн ёсоор яллан шийтгэж байх зэрэг тухайн үеийн соёлт олон улсын археологийн ухааны хууль ба ёс зүйн шинжтэй зарчмын заалтууд оржээ.

1941 онд дээрх дүрмийг шинэчлэн баталж эртний хот балгас, хэрмийн үлдэгдэл зэрэг 15 дурсгалыг улсын нэгдүгээр зэргийг хамгаалалтад, бичигт хөшөө, сүм хийд зэрэг 16 дурсгалыг улсын хамгаалалтад бүртгэн авсан байна. 1944 онд Эрдэнэ зуу, Амарбаясгалант зэрэг уран барилгын дурсгалуудыг улсын хамгаалалтад авч сэргээн засварлах ажлыг эхлүүлсэн юм.

1970 онд “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль” батлагдсан нь түүх, соёлын дурсгалт зүйлийг нэр төрлөөр нь ангилан тэдгээрийг хамгаалах, ашиглах, судлан шинжлэх, сурталчлах, өвлөн эзэмших зэрэг тодорхой харилцааг зохицуулсан анхны бие даасан эрх зүйн баримт бичиг байв. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, судалж шинжлэх, сурталчлахаар зогсохгүй, тэдгээрийг засаж сэлбэх, сэргээн засварлах ажил төрийн бодлогын түвшинд тавигдах болсон нь энэ талаар гарсан чухал ололт байлаа.

1973 онд Соёлын яамны харьяа Түүх, соёлын дурсгалт зүйлийн засварын газар байгуулагдсан бөгөөд СнЗ-ийн 1975 оны 47 дугаар тогтоолоор дээрх

байгууллагыг Түүхийн дурсгалт барилгын зургийн групптэй нэгтгэж Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлдвэр-шинжилгээний товчоо болгожээ. Уг товчоог СнЗ-ийн 1976 оны 94 дүгээр тогтоолоор Барилга-Архитектурын комиссын харьяа Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах газар болгон биеэ даасан аж ахуйн тооцоон дээр ажиллуулахаар байгуулсан байна. Ийнхүү манай улсын түүх, архитектурын дурсгалт барилгуудыг төлөвлөгөөтэйгээр сэргээн засварлах ажил эхэлсэн бөгөөд тус газар нь түүх, архитектурын дурсгалт барилгын сэргээн засварлах зураг төслийг боловсруулан Алтанбулаг хот дахь Сүхбаатарын штабын байшин, Булган аймаг дахь Баруун замын байлдааны штаб, Хатанбаатар Магсаржавын байшин, Хархорин дахь Эрдэнэ зуугийн цогцолбор, Архангай аймаг дахь Заяын хүрээний дурсгалт барилгууд, Сэлэнгэ аймаг дахь Амарбаясгалант хийдийн цогцолбор, Улаанбаатар хот дахь Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музей, Гандантэгчэнлин хийд зэрэг 40 гаруй түүх, архитектурын дурсгалт барилгыг сэргээн засварласан байна.

1980-аад оны сүүлч, 1990 оны эхээр улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үед хүмүүсийн амьжиргаа дордож үе дамжуулан хадгалж ирсэн түүх, соёлын дурсгалт зүйлээ худалдах, ашиг хонжооны эх сурвалж болгох, хууль бусаар хилээр гаргах, булш хиргисүүрийг дур мэдэн ухах зэрэг зөрчлүүд гарч эхэлсэн билээ. Иймээс түүх, соёлын дурсгалыг хамгаалах, эрэн сурвалжлах, судлах, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх, түүний эрх зүйн үндсийг боловсронгуй болгох талаар томоохон алхмуудыг хийсэн юм. Тухайлбал, “Монгол Улсын Үндсэн хууль” (1992), “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (1994), “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” (1994), “Монгол Улсын Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль” (1994), “Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого”(1996) тус тус батлагдсан билээ.

1994 онд батлагдсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-д соёлын биет бус өв буюу утга соёлын өвийг өвлүүлэн уламжлуулах, хөгжүүлэх, судлах, сурталчлах харилцааг зохицуулах асуудлыг шинээр нэмж 2001 онд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” нэртэй цогц хуультай болсон юм. Мөн Монгол Улсын Иргэний ба Эрүүгийн хууль, Гаалийн хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль зэрэг эрх зүйн бусад баримт бичгүүдэд түүх, соёлын дурсгалыг хамгаалах, ашиглах, тэдгээртэй холбоотой элдэв буруу үйлдэл, зөрчилтэй тэмцэх зэрэг урьд өмнө нь байгаагүй буюу бүрхэг байсан олон заалтыг шинээр тусгажээ.

2004 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан сумдын байгаль орчны байцаагч нарт түүх, соёлыг үл хөдлөх соёлын өвийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих эрх олгосон юм. 2014 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд дахин нэмэлт өөрчлөлт оруулж “Хуулийн нэр томьёоны

тодорхойлолт, Соёлын өвийн талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, Мерчантайзийн гэрээ” гэсэн шинэ зүйл, бүлгийг нэмсэн билээ.

Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 40 дүгээр тогтоолоор “Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах газар”-ыг хувьчлах тухай шийдвэр гарч “Уран барилга” ХХК болсон ба түүнээс хойш “Сүлд уул” ХХК, “Түүх, соёл” ХХК, “Зэндмэнэ суварга” ХХК зэрэг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай эрх авсан хувийн хэвшлийн байгууллага байгуулагдан “Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу тендерийн сонгон шалгаруулалтаар шалгарсан компани түүх, соёлын дурсгал барилгыг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэсээр ирлээ. Энэхүү шийдвэр нь түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах мэргэжлийн мэргэшсэн байгууллага, мэргэжилтэй боловсон хүчин, уламжлалт технологиор хөх тоосго, дээврийн ваар, чимэглэл хийдэг үйлдвэрлэлийн баазыг үгүй хийж, хамгийн хямд материалаар, хамгийн богино хугацаанд сэргээн засварлах ажлыг чанаргүй гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж өгсөн юм.

2014 онд баталсан Соёлын өвийг хамгаалах хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь заалтад “Монгол Улсын хэмжээнд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа Соёлын биет өвийг сэргээн засварлах газар гүйцэтгэнэ.” гэж улсын үйлдвэрийн газар байхаар заасан боловч өнөөдрийг хүртэл энэ заалт хэрэгжээгүй байна.

Соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажилд олон улсын хэмжээнд улам төвөгтэй олон асуудлууд тулгарч, мэдлэг, судалгааг нэмэгдүүлэх, хадгалах, сэргээн засварлах зарчмыг нарийвчлан судалж, түүнд хамруулах хүрээг өргөтгөх зорилгоор 1964 онд Олон улсын түүхэн хөшөө дурсгалын архитектор, мэргэжилтний II Конгрессийг Венец хотноо хуралдуулж “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах олон улсын дүрэм”-ийг хэлэлцэж баталсан бөгөөд энэхүү дүрмийг хэрэгжүүлэхийн тулд 1965 онд ЮНЕСКО-гийн дэргэд Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах Олон улсын зөвлөл (ICOMOS) байгуулагдсан юм.

ICOMOS нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа хөшөө дурсгал, дурсгалт газрын хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус олон улсын байгууллага бөгөөд түүний салбар хороо нь улс бүхэнд ажиллаж байна. Түүнээс гадна ICOMOS нь ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хороонд Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр санал болгож буй соёлын үнэт зүйлсийн шинж чанарыг үнэлэх, харьцуулсан судалгаа, техникийн судалгаа болон дурсгалт газрын хадгалалтын байдлын тайланг гаргаж өгдөг юм. ICOMOS-оос хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах, хадгалах, сэргээн засварлах талаар олон улсын

хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд мөрдөх дүрэм, журам, зарчим зэргийг боловсруулан мөрдүүлдэг.

Монгол Улс “Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах олон улсын конвенци”-д 1990 онд нэгдэн орсон орны хувьд ICOMOS-оос соёлын өв тухайлбал, хөшөө дурсгал, архитектурын болон археологийн өв, модон барилга, түүхэн хот зэргийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах талаар батлан гаргасан олон улсын дүрэм, зарчмыг үйл ажиллагаандаа даган мөрдөх үүрэгтэй билээ. Тиймээс бид эхний ээлжинд ICOMOS-ийн баталсан “Хөшөө дурсгал, дурсгалт газрын хадгалж хамгаалах, сэргээн засварлах дүрэм” (Венецийн Харти), “Түүхэн дурсгалт модон бүтээцийг хадгалах зарчим”, “Архитектурын өвийг хадгалж хамгаалах, сэргэн засварлах болон дүн шинжилгээ хийх зарчим”, соёлын өвийн менежментийн онол, практик ойлголтыг хөгжүүлэх зорилготой “Буррагийн дүрэм” зэргийг орчуулж, хөшөө дурсгал, архитектурын өв, түүхэн дурсгалт барилгыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах ажилдаа мөрдөж байна.

“Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах конвенци”-д “Соёлын өв” гэдэг ойлголтыг үл хөдлөх дурсгал гэсэн утгаар нь хөшөө дурсгал, архитектурын чуулга, дурсгалт газар гэж гурав ангилаад *Архитектурын чуулга* гэдэгт түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгын цогцолборыг оруулсан байдаг.

Дурсгалт барилга гэдэг нь биднийг гайхшруулах мэдрэмжийг төрүүлж, түүнийг бүтээсэн хүмүүс болон соёлын талаар илүү ихийг мэдэх боломжийг олгодог бөгөөд тэр нь архитектур, гоо зүй, түүх, баримтат, археологи, нийгэм, эдийн засаг, улс төрийн болон бэлгэдлийн үнэ цэнийг агуулсан байдаг. Гэхдээ хамгийн эхлээд “сэтгэл хөдлөлийн үнэ цэнэ”-ийг авч үзэх бөгөөд энэ нь соёлын өвийн онцлог, уламжлал, бэлгэдэл болон гайхшруулалтыг өөртөө багтаасан байна.

Аливаа дурсгалт барилга нь өнөөг хүртэл хэрхэн яаж хадгалагдан үлдэх нь тухайн нутгийн газар зүйн болон байгаль цаг уурын онцлог, улс орны аж амьдралын хэв заншил, ёс суртахуун, шашин шүтлэг, түүхэн хөгжлийн онцлог зэргээс хамаардаг. Сэргээн засварлагч-архитектор нь тухайн дурсгалт барилгын архитектур, түүний бүтээц хэсгүүдийн эвдрэл гэмтэл, хазайлт, гулзайлтын хэмжээ, одоогийн байдал, дурсгалын оршин байгаа байгалийн нөхцөл, хот дотор буюу хотын гадна орших эсэх, орчин үед сэргээн засварлах ажил ямар түвшинд явагдаж байгаа зэрэг нөхцлүүдээс шалтгаалан сэргээн засварлах аргыг сонгодог байна.

Дэлхийн улс орнууд түүхэн барилга, архитектурын дурсгалыг хадгалж хамгаалахдаа дараах аргуудыг хэрэглэж байна. Үүнд:

1. *Хадгалалт (Preservation)*. Тухайн дурсгалын одоогийн төлөв байдлыг хадгалах хэрэгтэй. Болзошгүй ялзралт муудалтаас сэргийлэхийн тулд засварыг тогтмол хийх, түүнээс хамгаалахын тулд ус, химийн хүчин зүйл, микро организмаас үүдэлтэй гэмтлийг зогсоох шаардлагатай байдаг.
2. *Сэргээн засварлалт (Restoration)*. Эх материал, археологийн нотолгоо, эх загвар, бодит баримт зэргийг үндэслэн анхны санаа, анхны төрх байдлаар сэргээн засварлана. Дурсгалт барилгын цэвэрлэгээ, алга болсон чимэглэлийн элементийг дахин байрлуулах зэрэг нь сэргээн засварлалтын ажлын нэг хэсэг бөгөөд аливаа нэмэлт сэргээн засварлалт нь “түүхийн баримт” болон хадгалагдаж үлдэнэ.
3. *Нөхөн сэргээлт буюу шинэчлэлт (Rehabilitation)*. Дурсгалт барилга, байгууламжийг хамгаалах хамгийн шилдэг арга бол тэдгээрийг одоо үеийн хэрэгцээнд тохируулан ашиглах явдал юм. Ингэхдээ жинхэнэ эх байдлаар нь ашиглах нь хамгаалах хамгийн сайн арга болдог.
4. *Сэргээн босголт (Reconstruction)*. Гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг болон дайн байлдаанаас болж устсан дурсгалт барилгыг сэргээн босгохдоо шинэ материалыг ашиглан гүйцэтгэнэ. Сэргээн босголт нь сэргээн засварлалттай адил баримт, гэрч нотолгоо дээр үндэслэгдэнэ. Сэргээн босголтын өөр нэг хэлбэр бол дурсгалт барилгуудыг бүхэлд нь шинэ газар нүүлгэн шилжүүлэх явдал юм.
5. *Консерваци буюу хадгалалт хамгаалалт (Conservation)* Дурсгалт барилгын дүрс хэлбэр, хийц бүтээц, дотоод засал, тавилга, өнгө будаг, гоёл чимэглэлийг бүрэн төгс мэдэх баримт судалгаагүйгээр дахин сэргээн босгож болохгүй юм. Харин эдгээр дурсгалт барилгын үлдсэн хана, суурийн хийцийн цаашдын эвдрэлийг зогсоож тэр хэвээр нь хадгалж үлдээх арга юм.

Улс бүхэн өөрсдийн дурсгалт барилгын нөхцөл байдлаас шалтгаалан хамгаалах аргыг сонгон хэрэглэдэг. Тухайлбал, Канад улс хадгалалт, сэргээн засварлалт, нөхөн сэргээлтийг, Австрали улс хадгалалт, сэргээн засварлалт, сэргээн босголтыг г.м.

Манай улсын түүх, соёлын дурсгалт барилга байгууламж, архитектурын өвийн хийц бүтээц, хэв загвар нь өөрийн онцлогтой учраас хэсэгчлэн болон иж бүрэн сэргээн засварлах ажлыг 1973 оноос хойш хийж байна. Харин хөшөө дурсгал буюу бичигт хөшөө, буган болон хүн чулуу зэргийг хадгалах, бэхжүүлж хамгаалах, хуулбар, дардасыг нь авах зэрэг ажлыг Соёлын өвийн Үндэсний төв гүйцэтгэдэг. Ер нь Соёлын өвийн Үндэсний төв нь Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, түүх, соёлын хөдлөх дурсгал буюу музей, номын санд хадгалагдаж буй үзмэрийг сэргээн засварлах, хөшөө дурсгалыг

хадгалж хамгаалах ажлыг гүйцэтгэх гэсэн үндсэн үйл ажил ажиллагааг хэрэгжүүлдэг төрийн байгууллага болно.

Тухайн дурсгалын хадгалалтын нөхцөл байдлаас шалтгаалж “соёлын ач холбогдол”¹ -ыг авч үлдэх зорилгоор арчлан тордох бүхий үйл явцыг консерваци буюу хадгалалт хамгаалалт гэдэг. Өөрөөр хэлбэл эвдэрч гэмтэх, нурж унах аюулд орсон түүх, соёлын дурсгалт барилга, эртний хотын үлдэгдэл зэргийг хадгалж хамгаалж, бэхжүүлэн хүчитгэж үлдээхэд хамгийн гол арга бол консервацийн арга гэдгийг дээр дурдсан Венецийн Хартид заасан байдаг. Консервацийн арга нь тухайн дурсгалын эвдрэл, гэмтэл, муудалтыг зогсоож, бидний үед ирсэн тэр байдлаар нь хадгалах, цаашдын элэгдэл муудалтаас урьдчилан сэргийлэх зэрэг шууд бус консервацийн арга; дурсгалт барилгын хийц бүтээцийг бэхжүүлэх, нурах аюулд орсон дурсгалд түшиг хана хийх замаар төрөл бүрийн инженерийн бэхэлгээ хийж хүчитгэх шууд консервацийн арга гэсэн үндсэн хоёр үе шаттай гүйцэтгэдэг.

Гэтэл өнөөдрийг хүртэл Хэрлэн барс хотын цамхагыг эс тооцвол дурсгалт барилга, эртний хотын үлдэгдэл хана хэрэм, цайзыг бэхжүүлэх, хүчитгэх ажил буюу консерваци хийгдээгүй байна. Төслийн хүрээнд улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад байх нийт 354, хамгаалалтын зэрэглэлд ороогүй, шинээр хамгаалалтад авах шаардлагатай 43 нийт 397 барилга архитектурын дурсгалын Урьдчилсан жагсаалтыг гаргалаа. Энэхүү жагсаалтаас “Хүчитгэх шаардлагатай түүх, соёлын дурсгалт барилга байгууламж”-ийн жагсаалтыг гаргаж, 69 эртний хот болон сүм хийдийн үлдэгдэл, түүхэн барилга болон архитектурын дурсгалыг хамруулсан болно. Түүнчлэн “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журам”-ын төслийн боловсруулснаар Барилга болон хот байгуулалтын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль”, “Орон сууцны тухай хууль”, “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д холбогдох нэмэлт өөрчлөлтийг хийх шаардлага гарч байна.

Дурсгалт барилгыг хамгаалах гэдэг нь түүний оршин тогтнох хугацааг уртасгах, тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх, бүх төрлийн болзошгүй аюул, гэмтлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагаа бөгөөд үүнд: Бүртгэх; Судалж шинжлэх; Сэргээн засварлах; Бэхжүүлж хамгаалах; Хяналт тавих, Тогтмол үзлэг хийх; Сурталчлах; Олон нийтийн санаачилгыг дэмжих зэрэг үйл ажиллагаа багтана. Өөрийн улсын нутаг дэвсгэр дээр оршиж байгаа түүх, соёлын дурсгалаа бүртгэж жагсаалт гаргах нь нэн тэргүүний ажил юм. 1986 онд ЮНЕСКО-гоос

¹ Буррагийн Хартид: “Өнгөрсөн, одоо, ирээдүйн хойч үед гоо зүйн, түүхийн, шинжлэх ухааны, нийгмийн болоод оюун санааны үнэ цэнэтэй байхыг “Соёлын ач холбогдол” гэнэ. Соёлын ач холбогдол нь тухайн газар, түүний бүтэц, орчин хэрэглээ, дурсамж, утга учир, бүртгэл, холбогдох газрууд болон обьектод тусгагдсан байна. Энэ нэршил нь соёлын өвийн ач холбогдол, соёлын өвийн үнэ цэнэтэй адил утгатай юм.” гэж тодорхойлжээ.

гаргасан “Дурсгалт зүйлийн бүртгэлийн тухай лавлах бичигт”: Өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн дурсгалт барилга, байгууламжийн жагсаалтыг боловсруулахдаа “уг дурсгалын агуулгыг илэрхийлж чадахуйц орон зайн талбайд авч үзэх нь чухал” гэдгийг онцлон заасан. Түүнчлэн 1996 онд баталсан “Хөшөө дурсгал, бүлэг барилга, дурсгалт газрыг бүртгэх ИКОМОС-ийн зарчим” -д “*Бүртгэл* гэдэг нь хөшөө дурсгал, барилга болон дурсгалт газруудын биет хэлбэр дүрс, нөхцөл байдал, ашиглалтын талаарх мэдээллийг цуглуулахыг хэлэх бөгөөд бүртгэлийн ажил нь хадгалалт хамгаалалтын нэгэн чухал хэсэг юм.” гэж тодорхойлсон байна.

Аливаа барилга байгууламжийг “архитектурын дурсгал, түүхэн дурсгалт барилга” хэмээн тодорхойлохдоо Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу “*түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг*” тогтоох ёстой учраас түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсын жишгийн дагуу улам боловсронгуй болгох, тэдгээрийг тодорхойлох шалгуур, үзүүлэлтийг нарийн тодорхой болгож, гарах үр дүнг үнэн зөв, бодит болгох шаардлага гарч байна. Бүртгэж жагсаалт гаргахын тулд эхлээд түүх, соёлын дурсгалаа тодорхойлох хэрэгтэй. Тодорхойлохын тулд холбогдох эрдэмтэн, мэргэжилтэн, урлаг судлаач, архитектор, археологич, түүхч зэргээс бүрдсэн “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний баг” тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх нь зүйн хэрэг.

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн төслийн баг ЮНЕСКО-гийн “Соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци” түүний Дэлхий өвийг тодорхойлох удирдамж, шалгуур, бусад улс орны архитектурын өвөө тодорхойлох шалгуур үзүүлэлт, “Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т тусгагдсан түүхэн дурсгалт газар, барилга байгууламжийг тодорхойлох шалгуур үзүүлэлт зэргийг судалж “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар”-ын төслийг боловсруулсан болно. Уг зааврыг хэрэгжүүлэхийн тулд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааг соёлын болон хот байгуулалт, барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан журмаар зохицуулах шаардлагатай учраас “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулсан юм.

Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох, хамгаалалтын түвшингээр зэрэглэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд дээрх журам, зааврыг мөрдөх ёстой.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

ЮНЕСКО-гийн гаргасан олон улсын конвенци, дүрэм, зарчмыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг боловсруулах, түүх, соёлын дурсгалт барилга байгууламж, археологийн дурсгалууд, угсаатны зүйн хэрэглэгдэхүүн, үндэсний хэл, бичиг үсэг, зан заншил, ардын урлаг, урлагийн бүтээл зэргийг эрэн сурвалжлах, бүртгэн баримтжуулах тэдгээрийн хадгалалт хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, уламжлан хөгжүүлэх, сэргээх засварлах бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх асуудлыг Монгол Улсын Соёлын яам хариуцан ажиллаж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААРХ СУДАЛГАА, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ерөнхий мэдээлэл

Аль ч улс орон түүх, соёлоо хадгалж авч үлдэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх эрхэм зорилготой бөгөөд энэхүү зорилгоо янз бүрээр тунхаглан бэхжүүлсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт “Монголын ард түмэн бид:

-улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

-хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,

-*төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,*

-хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,

-эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.” гэсэн нь бид бүхний субъектив зорилго билээ. Дэлхийн улс орнуудын төрийн субъектив зорилго нь Үндсэн хуулийнх нь оршил хэсэгт ийнхүү бичигдсэн байдаг.

Үндсэн хуульд заасан төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх эрхэм зорилгодоо хүрэхийн төлөө салбарын хууль тогтоомжийг батлан мөрдүүлэхийн зэрэгцээ урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд зорилт болгон дэвшүүлж хэрэгжүүлсээр ирсэн. Тухайлбал: Соёлын тухай хууль², Соёлын өвийг хамгаалах тухай хууль³-аас гадна Бодлогын дараах баримт бичгүүдэд дор дурдсан зорилтыг дэвшүүлж байсан. Үүнд:

1. “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”⁴ -т “-соёлын өвийг эрэн сурвалжлах, судлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан түгээх үндэсний чадавхийг нэмэгдүүлэх; соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэ шатанд гаргаж, улсын нэгдсэн бүртгэлийн цахим мэдээллийг хил, гааль, цагдаа, мэргэжлийн хяналтын дотоод сүлжээтэй холбох;” зорилтын хүрээнд соёлын өвийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх “Өв хамгаалагч”

2 “Төрийн мэдээлэл эмхэтгэл”-ийн 1996 оны дугаар 7-д нийтлэгдсэн.

3 “Төрийн мэдээлэл эмхэтгэл”-ийн 2014 оны дугаар 23-т нийтлэгдсэн.

4 УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан.

хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ, Мэргэжлийн соёл, урлагийн байгууллагын орчны стандартыг баталж мөрдүүлнэ, Соёлын барилга байгууламжийн стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулан баталж мөрдөнө, Байгалийн түүхийн музейн барилга, лабораторийг шинээр барьж байгуулна, Соёлын өвийн төвийг зориулалтын шинэ барилга, тоног төхөөрөмжөөр хангаж, бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн “Соёлын өвийн бүртгэл судалгааны үндэсний төв”, “Соёлын өвийг сэргээн засварлах байгууллага” байгуулна, Үндэсний соёлын өвийг бүртгэн баримтжуулах 2 дахь шатны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ гэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөж байсан.

2. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”⁵-т Монгол Улсын түүх, соёлын өв уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилт, хөгжил дэвшил, гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагааг дэлхий нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлнэ гэж зорилт дэвшүүлэн Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулна гэж төлөвлөж байжээ.

Гэвч дээрх хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд туссан зорилт арга хэмжээнүүдээс харахад түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг чухам яаж хадгалж, хамгаалах, сэргээн засварлах нь тодорхойгүй байна.

Энэ байдлыг засах сайжруулах, хууль тогтоомжид нарийвчилсан зохицуулалт тусгах, түүхийн дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах, хүчитгэх бэхжүүлэх чадавх бүхий хүний нөөцийг бэлтгэх, түүхийн дурсгалт барилга байгууламжаа тоолох, бүртгэх, хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлэх зорилгоор салбарын байгууллага, мэргэжилтнүүд багагүй санаачилга гарган ажиллаж байсныг дараах жишээ харуулж байна. Тухайлбал: Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам, Барилга, хот байгуулалтын яам болон Монголын Архитекторуудын Эвлэл хамтран “Дурсгалт барилгын хадгалалт хамгаалалт” зөвлөгөөнийг 2017 онд анх удаа зохион байгуулж, дурсгалт барилга байгууламж нь соёлын томоохон өв төдийгүй аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй хэмээн үзэж хөгжингүй орнууд тавиас дээш жил болсон барилгын хэлбэр загварыг алдагдуулалгүй, өнгө үзэмжийг сэргээж ашиглахад ач холбогдол өгдөг юм байна. Манай орны хувьд түүхийн дурсгалт 2820 барилга байгаагийн 596 нь сүм хийд бөгөөд цаашид сэргээн засварлах, ашиглахтай холбоотой асуудлаар төрийн эрх бүхий байгууллагууд болон мэргэжилтнүүд хамтран ажиллах нь зүйтэй гэж байжээ. Энд мөн түүхийн дурсгалт барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтын эрх зүйн орчин хангалтгүйгээс эзэнгүйдэж, устаж үгүй болж байгааг цохон тэмдэглэсэн.

⁵ УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан.

Түүнчлэн салбарын мэргэжилтнүүд ч өөрсдийн үзэл санаа, туршлага мэдлэгийг хуваалцаж мэдээллийн хэрэгсэлд энэ талаарх ярилцлагыг өгсөн нь байна.

Мөн 2019 онд Улаанбаатар хотод түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хамгаалахад болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар “Соёлын өв-архитектурын дурсгалыг гамшиг, эрсдэлээс хамгаалах нь” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж, түүнд БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Аюулгүй ажиллагаа гамшгаас сэргийлэх хэлтсийн гурван мэргэжилтэн өөрийн улсын туршлагыг танилцуулж байжээ. Энэхүү зөвлөгөөн нь манай улсын соёлын өвд, тэр дундаа архитектурын дурсгалд гамшгийн эрсдэл тохиосон үед хэрхэн ажиллах, бэлэн байх, урьдчилан хамгаалах талаар мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг бий болгоход чиглэсэн байна.

Байгалийн болон соёлын өвийг хамгаалах, таниулан сурталчлах, хойч үедээ үлдээх зорилгоор 1972 онд Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенцийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна. 2020 оны байдлаар 167 улсын нийт 1121 өв Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн бөгөөд үүнээс 869 нь соёлын, 213 нь байгалийн, 39 нь хосолмол өв аж.

Монгол улс Дэлхийн өвийн конвенцид 1990 онд нэгдэн орж 1996 онд анх Дэлхийн өвд бүртгүүлж болох монголын байгалийн болон соёлын өвийн Урьдчилсан жагсаалтыг боловсруулсан байна. 2004 онд Монголын байгалийн болон соёлын өвийг Дэлхийн өвд бүртгүүлэх, Урьдчилсан жагсаалтад оруулах, Дэлхийн өвд бүртгүүлсэн өвийн болон конвенцийн тайлан илтгэлийг бичих, конвенцийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Дэлхийн өвийн үндэсний хороог соёлын болон байгаль хамгааллын зүтгэлтэн, мэргэжилтэн, эрдэмтдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Монголын Засгийн газар Дэлхийн өвд бүртгүүлэх Урьдчилсан жагсаалтыг 2015 онд шинэчлэн баталсан бөгөөд үүнд дараах 12 дурсгалыг багтаасан байна.

Соёлын ангиллаар:

1. Амарбаясгалант хийд, түүнийг хүрээлсэн тахилгат, соёлын дурсгалт газар
2. Хөдөө арал дахь археологийн дурсгал, түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар
3. Балдан Бэрээвэн хийд, түүнтэй холбогдох тахилгат газар нутаг
4. Буган хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор
5. Хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор
6. Монголын говь дахь хадны зургийн цогцолбор
7. Тахилгат Биндэр уул, түүнтэй холбогдох соёлын дурсгалт газар
8. Монголын тахилгат уулс

Байгалийн ангиллаар:

9. Монголын говь дахь Цэрдийн галавын үлэг гүрвэлийн өлгий нутаг
10. Монголын Их говийн цөл нутаг
11. Дорнод Монголын тал нутаг.

Хосолмол ангиллаар:

12. Монгол Алтайн өндөр уулс

Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад 2020 оны байдлаар дараах таван өв бүртгэгдсэн. Үүнд:

Байгалийн ангиллаар:

- Увс нуурын ай сав газар (2003 он)
- Дагуурын ландшафт (2017 он)

Соёлын ангиллаар:

- Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (2004 он)
- Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (2011 он)
- Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг (2015 он)

ЮНЕСКО-ийн 2010-2011 оны Оролцох хөтөлбөрийн хүрээнд “Монголын Дархан цаазат Бурхан Халдун, Отгонтэнгэр, Богд хан уулын байгаль, соёлын өвийг хамгаалах хэрэгцээ шаардлагын талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх нь” төслийг хэрэгжүүлж, гурван аймгийн 13 суманд судалгаа явуулж, фото зураг, соронзон ба дүрс бичлэг хийж, ном, фото цомог бэлтгэж, олон нийтэд түгээн сурталчилсан.

2008 онд Дэлхийн өвийн хорооны зөвлөх байгууллагуудын нэг болох Хөшөө дурсгал, дурсгалт газрын олон улсын зөвлөл (ICOMOS)-ийн Монголын үндэсний хороог байгуулжээ. Монголын үндэсний хорооны тэргүүнээр Н.Уртнасан ажиллаж байна. Хөшөө дурсгал, дурсгалт газрын олон улсын зөвлөл нь 1965 онд байгуулагдсан, Парис хотод төвтэй, олон улсын, төрийн бус байгууллага юм.

Манай улс 2003 онд Засгийн газар хоорондын байгууллага болох Соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах олон улсын судалгааны төв (ICCROM)-д гишүүнээр элсэн орсон бөгөөд энэхүү төвд элсэн орсноор соёлын эд зүйлс болон соёл, археологийн дурсгалт газар, хөшөө дурсгалуудыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах талаар олон улсын хамтын нийгэмлэгтэй өргөн хүрээнд хамтран ажиллах боломж нээгдсэн юм.

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хадгалж авч үлдэх нь зөвхөн барилгын салбарын дангаараа мэдэн шийдчих асуудал биш бөгөөд Соёлын яам, мэргэжлийн хяналтын, хууль зүйн, боловсролын, онцгой байдлын зэрэг байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа нэн чухал юм.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Олон улсын туршлагаас үзэхэд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах, хүчитгэх бэхжүүлэх асуудлыг ач холбогдлыг нь харгалзан чухлаар авч үзэж байгаа бөгөөд хууль зүйн нарийн зохицуулалтын хүрээнд тодорхой тооцоо судалгаанд үндэслэж, мэргэжлийн багийн оролцоотойгоор хийж гүйцэтгэдэг байна. Иймээс бид бусад улс орны сайн туршлагаас суралцан юуны түрүүнд бүх ажлын эхлэл болсон хууль эрх зүйн орчныг сайжруулах явдал нэн тулгамдсан практик хэрэгцээтэй байна.

Манай улсын түүхийн дурсгалт барилга байгууламжийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл тооллого, хяналт хариуцлага хангалтгүй байгаагаас олон дурсгалт барилга байгууламжийг нураалгаж бидний түүх, нийслэл хотын маань түүхийн гэрч устаж үгүй болоход хүрээд байна. Бид хөгшин европын хотуудтай энэ зэрэгцэхүйц дурсгалт барилга олон биш боловч архитектурын гайхамшгийг илтгэн харуулсан цөөн хэдхэн барилга байгууламжаа орчин үеийн шинэ шилдэг технологи ашиглан хүчитгэж ашиглалтын хугацааг уртасган хойч үедээ түүхийн дурсгал болгон үлдээх боломжтой байна.

Хууль эрх зүйн орчны өнөөгийн байдлыг судалж дараах хүснэгтээр харуулав.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ,
АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОДОО МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ
ТОГТООМЖ, ҮҮНЭЭС ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ТУСГАСАН ЭСЭХ ТАЛААРХ
СУДАЛГАА**

д/ д	Хуулийн нэр	Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэртэй байдал, аюулгүй байдалтай холбоотой заалтууд	Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн талаарх зохицуулалт	Нэмэлт мэдээлэл
Хууль				
1	Барилгын тухай хууль	1.34. “инженер хайгуулын судалгаа” гэж барилгын ажил гүйцэтгэхээс өмнө тухайн газрын газар хөдлөлт, байгаль, ус цаг уурын нөхцөл, газрын төлөв байдал...тогтоох мэргэжлийн үйл ажиллагааг хэлэх бөгөөд үүнд үндэслэн зураг төсөл гаргана		
		- 25.1. Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг		10.1.4 гэдэг бол өндөр төвөгшилтэй барилга бөгөөд БХБ-ын Сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

		/эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ. - 25.2.Магадлалыг дараахь зураг төсөлд хийнэ: - 25.2.1. газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт; - 25.2.2. газар хөдлөлтийн долоогоос доош баллын бүсэд баригдах энэ хуулийн онцгой болон өндөр төвөгшилтэй барилга байгууламж ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт;		“Барилга байгууламжийн төвөгшилийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-д “түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах” гэж орсон. Жишээ: Худалдаа хөгжлийн банк нь 60,0м*51,5м хэмжээтэй хасах 3 давхар бүхий зоорийн давхартай 28 давхар контор, үйлчилгээний барилга барих зөвшөөрлийг Нийслэлийн Засаг даргаас авсан.Тус банк хуучин барилгаа нурааж шинэ барилгын ажлыг 2015 оноос эхлүүлсэн бөгөөд хуучин барилгын суурийг нурааж шинэ суурь /2018 оноос эхэлсэн/ тавьж эхэлснээс хойш Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейн сууринд нөлөө үзүүлсэн. Гэвч барилга баригдах талбайн хөрсний хүчитгэл бэхэлгээний ажилд барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай зохицуулалт байхгүй байгаа юм.
2	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай		21.5. Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна./хотын захирагч/	Хэрэгжилт хангалтгүй байгаа. Бодит жишээ: Европ анхны 2 давхар барилга нураасан үйл явдал. Энэ барилгыг ЗГ-ын 1994 оны 233-р тогтоолоор, ЗГ-ын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-аар УБ хотын соёлын үл хөдлөх дурсгалд бүртгэсэн байжээ. БЗД-ийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрлах энэхүү барилгыг 2019.12.15-ны өдөр буулгасан.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

3	Хот байгуулалтын тухай хууль		23.1. Дараахь бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтооно: 23.1.1. түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын бүсийн тухай заалттай уялдуулаагүй учраас хамгаалалтын бүсэд шинээр барилга барьсныг Чойжин ламын сүм, Богд хааны Ногоон ордны одоогийн байдлаас харж болно.
			12.4.1... түүх, соёлын дурсгалт байгууламж, архитектур-хот байгуулалтын шаардлага, экологийн болон эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байх;	
4	Соёлын өвийг хамгаалах тухай хууль. /1996.04.11		13.1.7. улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах 47.2. Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 13.1.12. түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох;	БСШУ-ны сайд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 183/111 дүгээр хамтарсан тушаалаар “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам” батлагдсан. Гэвч 2016 онд Барилгын тухай хууль шинээр батлагдсанаар холбогдох норм, дүрмүүд шинэчлэгдсэн.
5	Соёлын тухай хууль		2. Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар	

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

			бүхэлд ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.	нь	
6	Гамшгаас хамгаалах тухай хууль	8.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна. 9 дүгээр зүйл. Гамшгийн эрсдэлийг бууруулах 9.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хуулийн 8.1-д заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд дараахь арга хэмжээг авна: <u>/Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u> 9.1.3. гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх; 9.2. “Бүтцийн арга хэмжээ” гэж барилга байгууламж, объект, зам, гүүр, далан болон бусад дэд бүтцийн аюулгүй, гамшигт тэсвэртэй байдлыг хангах арга хэмжээг ойлгоно.			
7	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль /2015.06.26/	15.1. Хот, суурин газарт экологи, эдийн засаг, нийгмийн хөгжил, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгох, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэх зорилгоор хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулж,			Зөвхөн мэргэжлийн хяналтын дүгнэлтийг үндэслэхээр заасан.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

		нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулна 4.1.1. “ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламж” гэж барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтээр ашиглахыг хориглосон		
Бусад баримт бичиг				
8	“Хөтөлбөр батлах тухай” ЗГ-ын 2007 оны 303 дугаар тогтоолоор /Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах шаардлага нийт хөрөнгө 13198.0 сая төгрөг		Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлахад шаардлага нийт хөрөнгө 13198.0 сая төгрөг	Улсын төсөв 9838.0 сая төгрөг Орон нутгийн төсөв 1430.0 сая төгрөг Гадаад орон, олон улсын Байгууллагын хөрөнгө, хандив 1700.0 сая төгрөг Хувийн хөрөнгө оруулалт 230.0 сая төгрөг Жагсаалт бүрээр нь хөрөнгө төсөвлөгдсөн уг хөтөлбөрийн биелэлтийн ХШҮТ-г холбогдох газраас гаргуулан авч үзэж болно. Хөтөлбөрийн заалтаас үзэхэд Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах, бэхжүүлэх хамгаалах, хэв дардас, хуулбар хийх, унаган газраас нь зөөж хадгалах, сургалт сурталчилгааны ажил гэх мэт арга хэмжээ тус бүрийг зарцуулах хөрөнгийн хамт төлөвлөсөн. Үүнээс: Бэхжүүлж хамгаалах дурсгалын жагсаалтад буган чулуу, хөшөө, балгас, тууриуд орсон байсан. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссан ч зарцуулсан хөрөнгө, бий болсон үр дүнг харьцуулж үр нөлөөг нь өнөөдөр үнэлэх боломжтой. Үндэсний хөтөлбөрийн үр дүн, тайлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна. Соёлын өвийг судлах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтнийг 2008-2010 оны хооронд 13 хүнийг 400 сая төгрөгөөр бэлтгэхээр тусгасан.
9	Барилга хот байгуулалтын	- Газар хөдлөлтийн 7, 8 ба 9 баллын		- Барилга байгууламжийг сэргээн

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

	сайдын 2013 оны 106 дугаар тушаал /Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01*/2006/ 2013/	талбайд шинээр барих болон баригдсан барилга байгууламжийг сэргээн босгох, засварлах ажлын зураг төсөл зохиоход мөрдөнө - 3.29. Каракасын дүүргэгч болон өөрийн даацтай ба даацын ханын өрөгт хэрэглэх материал нь доорх шаардлагуудыг хангасан байна.в/ 35-аас багагүй маркийн чулуу буюу тунамал чулуу, шохойн чулуун ба 50-иас дээш маркийн хүрмэн чулуун гулдмай,		босгох, засварлах ажлын зураг төсөл зохиоход мөрдөгдөхөөр заасан байх тул хүчитгэх гэж нэмэх
10	Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 198 дугаар тушаалын хавсралт “газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм” БНБД 22-04-16	1.1. барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах барилгын ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулахад шаардагдах газар хөдлөлийн эрчмийн тоон үнэлгээ (цаашид балл гэх), хөрсний оргил хурдатгал, хөрсний зонхилох давтамж болон түүний мужлалын хилийн солбилцол зэрэг техник үзүүлэлтүүдийг газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглан тодорхойлох аргачлалыг тогтооно.		Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн газар хөдлөлтийн үйлчлэлд тэсвэрлэх чадварыг үнэлж, паспортжуулах талаар заасан байна
11	Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал 2000 оны 94 дүгээр тушаалаар 3 БД баталсан. 1.“Орон сууц, иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн газар	1.2. хуучин барилгын шинэчлэлт, өөрчлөлт, их засвар хийх, хүчитгэх ажлын зураг төсөл, техникийн шийдлийг зураг төслийн мэргэшсэн байгууллага боловсруулна. Илүү нарийн төвөгтэй болон хариуцлагатай нөхцөлд эрдэм шинжилгээний байгууллагуудыг татан оролцуулна	2.5. Түүхийн хөшөө дурсгалд тооцогддог барилга байгууламжийг задлах болон судлахдаа хөшөө дурсгалыг хамгаалах улсын холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай.	Модон хучилт, дээвэртэй барилгын даацын бүтээцийг судлах талаар заасан боловч түүхий тоосготой түүх, соёлын дурсгалт барилгуудын талаар дурдагдаагүй

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

	хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх, судалгаа явуулах, даацын үндсэн бүтээцийг хүчитгэх, паспортжуулах заавар” /БД-31-103-00/	- 9 балл хүртэл газар хөдлөлтийг тэсвэрлэх тооцооны үзүүлэлтэй барилгууд - 9 баллаас дээш газар хөдлөлтийг тэсвэрлэх тооцооны үзүүлэлттэй барилгууд Энэхүү заалт нь бүтээц эвдрэлд орсон, ослын аюултай, ашиглах боломжгүй нөхцөлд байгаа барилга байгууламжид үл хамаарна. Энэ заалтад хамаарагдахгүй барилга байгууламжид нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.		
	2. Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар /БД-31-102-00/	Барилга, түүний хийцийг хүчитгэх аргууд. 1.Том хавтгаалжин барилга. 2.Араг бүтээцтэй барилга. 3.Тоосгон хана 4.Модон барилга 5.Бүтээцийг зэврэлтээс хамгаалах аргууд		БХБ-ын Сайдын 2018 оны 185 дугаар тушаал Барилгын дүрэм 1,2,3-р хавсралт “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” / БД 22-105-18/ “Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт, тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-106-18/ “Том хавтгаалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-107-18/
	3. Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжинд инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар /БД-31-101-00/			
12	Барилга, хот байгуулалтын сайдын 2018	2.1.Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал	2 дахь хэсэгт <i>Төрөл бүрийн зориулалттай олон</i>	- Сэргээн засварлах гэсний

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

	оны 12 дугаар сарын 31-ний өдөр 218 дугаар тушаал "Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм"-	нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилга байгууламжийг эхлүүлэх, үргэжлүүлэх, ашиглалтад оруулах, барилгын салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, сунгах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, барилгын ажилд захиалагчийн хяналт тавих зэрэг үйл ажиллагааг зохицуулах үндэслэл болно.	нийтийн барилга төрөлд оруулан Өндөр төвөгшилтэй барилга байгууламж ангилалд Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлах; - Музей, үзэсгэлэнгийн барилга байгууламж; - Сүм, хийдийн барилга байгууламж;	дараа хүчитгэх гэж оруулах
13	Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 217 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"	1.7.Барилга байгууламжид паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ЗТ-4.1 ажлын төрөлтэй, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ. 1.8. Барилга байгууламжийн буулгалтын ажлыг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх БА-4.1 ажлын төрөлтэй, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.		Барилгын тухай хуулийн 19.1.1.,19.1.2 хэсэгт Өндөр төвөгшилтэй барилга байгууламжинд зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэхэд Тусгай зөвшөөрөл авахаар тусгасан
14	БХБ-ын Сайдын 2018 оны 185 дугаар тушаал	Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт, тэсвэрлэлтийг үнэлэх		


*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

	Барилгын дүрэм 2-р хавсралт БД 22-106-18	болон хүчитгэх аргачлал		
15	БХБ-ын Сайдын 2018 оны 185 дугаар тушаалын 1-р хавсралт, Барилгын дүрэм БД 22-105-18	Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал		
16	БХБ-ын Сайдын 2018 оны 185 дугаар тушаал 3-р хавсралт Барилгын дүрэм БД 22-107-18	Том хавтгаалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал		
17	БСШУ-ын сайд, ДБ-ийн сайдын 2004.05.24-ий 183/111 дүгээр хамтарсан тушаал			Уг тушаалаар “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам” батлагдсан талаар №4-дурдсан.
18	Журам батлах тухай Засгийн газрын 2018.06.18-ны 184 дүгээр тогтоолын 2-р хавсралтаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-			
19	Шадар сайдын 2017.08.17-ны 78-р тушаалын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”	1.1 Монгол улсын нутаг дэвсгэрт ашиглаж байгаа болон шинээр барьсан, өргөтгөл шинэчлэлт хийсэн барилга байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах үйл ажиллагааны харилцааг энэхүү журмаар зохицуулна.	Зохицуулалт хамаарна	.. барилга паспортжуулсанаас ... нь түүх, соёлын дурсгалт барилгаар хамгаалалтад авагдсан барилга байгууламж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байгаа байгууллагуудын бүтцийн шинжилгээг хийсэн. Засгийн газрын бүтэц тогтвортой биш байх, төрийн захиргааны төв байгууллагыг үе үе өөрчлөхөд салбар дундын байтугай тухайн салбарын өөрийнх нь үндсэн асуудлаарх бодлого, зохицуулалт, хяналт алдагдахад хүрдэг олон жишээг бид мэднэ. Түүх, соёлын дурсгалт барилга

байгууламжийн асуудлыг хариуцах яамдын бүтцийн өөрчлөлтийг (Хүснэгт 2) харууллаа.

Төрийн захиргааны 13 төв байгууллагын хувьд Ерөнхий чиг үүргийн тоо-38, үндсэн чиг үүргийн тоо-152, дэд чиг үүргийн тоо 800 байгаа бөгөөд 800 дэд чиг үүргийг хэрэгжүүлэхэд Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, төрийн захиргааны байгууллагууд, хувийн хэвшил, Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон бусад төрийн байгууллагууд дараах байдлаар дангаараа болон хамтран оролцдог байна.



Зураг 1. Төрийн захиргааны төв байгууллагын дэд чиг үүргийг тоон үзүүлэлт

Дээрх зургаас харахад:

1. Төрийн захиргааны төв байгууллагууд нь нийт 661 дэд чиг үүргийг дангаараа болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг;
2. Төрийн захиргааны байгууллага буюу тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа /босоо удирдлагад хамаарах/ агентлаг, байгууллага нь нийт 404 дэд чиг үүргийг дангаараа болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, түүнчлэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг;
3. Аймаг, нийслэлийн хэмжээнд 311 дэд чиг үүргийг, сум, дүүргийн хэмжээнд 287 дэд чиг үүргийг, баг, хороонд 152 дэд чиг үүргийг тус тус хэрэгжүүлэхэд орон нутгийн хяналт, оролцоог хангаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж оролцдог;
4. Төрийн захиргааны төв байгууллагууд нь нийт 385 дэд чиг үүргийн хүрээнд бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг байна.
5. Төрийн захиргааны төв байгууллагуудын 95 чиг үүргийг хууль, тусгай зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод гүйцэтгэж байна.

**Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн асуудлыг хариуцах
яамдын бүтцийн өөрчлөлт**

1992-1996 /16 яам/	1996-2000 /9 яам/	2000-2004 /11 яам/	2004-2008 /13 яам/	2008-2012 /11 яам/	2012-2016 /15 яам/	2016-2020 /13 яам/
Шинжлэх ухаан, боловсролын яам	Гэгээрлийн яам	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Боловсрол, шинжлэх ухааны яам	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам
Соёлын яам					Соёл, спорт, аялал жуулчлалын яам	-
Барилга, хот байгуулалтын яам	Дэд бүтцийн хөгжлийн яам	Дэд бүтцийн яам	Барилга, хот байгуулалтын яам	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам	Барилга, хот байгуулалтын яам	Барилга хот байгуулалтын яам
Зам, тээвэр, холбооны яам			Зам, тээвэр, аялал жуулчлалын яам		Зам, тээврийн яам	Зам тээврийн хөгжлийн яам

Дүгнэлт, санал

Хууль эрх зүйн орчны судалгааг хийхэд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх, бэхжүүлэх тухай ойлголт хууль тогтоомжийн хүрээнд хангалттай бүрэн дүүрэн зохицуулагдаагүй гэж дүгнэсэн.

1. Нэр томьёо тодорхойгүй. */Барилга байгууламжийг хүчитгэх, бэхжүүлэх, Түүх, соёлын дурсгалт барилга байгууламж/*

2. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хадгалах, хамгаалах, сэргээн завсарлах, хүчитгэх бэхжүүлэх зэрэг асуудлыг зохицуулах хууль тогтоомжуудын хувьд хоорондоо харилцан уялдаагүй, хийдэлтэй байгааг барилгын болон соёлын асуудал хариуцсан салбар дундын зохицуулалт шаардагдах энэ асуудлыг хамаарах салбарын яамдын бүтцийн оновчгүй, байнга өөрчлөлтөд өртөж байсан явдалтай шууд холбоотой гэж дүгнэсэн.

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх бэхжүүлэх асуудал барилгын болон соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг нь Шадар сайдын эрхлэх асуудалд /гамшгаас хамгаалах болон хяналт шалгалтын чиг үүрэг/хамаарахыг харгалзан хууль тогтоомжийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсэнд тулгуурлан холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулах саналын хувилбар боловсруулав. Ингэхдээ гадаадын зарим улс орны хууль тогтоомжоос үндэсний онцлогт тохируулан нутагшуулж болох заалтыг зээлдэн найруулав.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОДОО МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ТОГТООМЖИНД ОРУУЛАХ САНАЛ

№	Зүйл заалт	Оруулах өөрчлөлт ба зохицуулалт	Нэмж найруулах санал	Тайлбар
Барилгын тухай хууль				
1	4.1.1 дүгээр зүйл	“барилга байгууламж” гэж	Бүх төрлийн барилга байгууламжийг энэ нэр томъёонд нэмж тусгах	Уг хуулинд бүх төрлийн барилга байгууламж гэсэн нэр томъёо байгаа мөртлөө тус заалтад бүх төрлийн барилга байгууламж гэж заагаагүйгээс төрийн өмчийн бүх барилга объект тусгагдаагүй орхигдсон байна. Жишээ нь түүх, соёлын зориулалт бүхий музей, театр зэрэг
2	4.1.3	“барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа” гэж		барилга байгууламжийг ашиглалтад оруулж, гэрчилгээ олгосноос хойш захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд барилгын хийц, бүтээц, эдлэхүүн, тоног төхөөрөмж, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны ашиглалтын хэвийн нөхцөлийг хариуцан хангах хугацаа
3	4.1.11	“барилгын ажил” гэж	“барилгын ажил” гэж бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, хүчитгэх , буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;	Хүчитгэх гэдгийг энэ нэр томъёонд нэмэх

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

4	4.1.44	“Хүчитгэх үйл ажиллагаа”	“Хүчитгэх үйл ажиллагаа” гэж тухайн түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн чанар аюулгүй байдалд инженерийн биет судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, хүчитгэх зураг төсөл, баримт бичиг боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, чанар аюулгүй байдлын дахин шинжилгээ хийж паспортжуулан ашиглалтанд оруулж гэрчилгээжүүлэхийг хэлнэ.	
5	4.1.45	“Барилгыг хадгалах”	“Барилгыг хадгалах” гэж тухайн түүх соёлын дурсгалт барилга байгууламжийн аливаа нөхцөл байдлыг өөрчлөхгүйгээр хэвээр нь хадгалахыг хэлнэ.	
6	4.1.46	“Барилга байгууламжийг чөлөөлөх”	“Барилга байгууламжийг чөлөөлөх” гэж түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг өмчлөгчийн эд хогшил эсхүл өмчлөгчийг түр байраар хангаж тухайн барилга байгууламжийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн суллаж цэвэрлэх үйл ажиллагааг хэлнэ.	
7	9 дүгээр зүйл	Барилгын ажлын төрөл	9.1.6 дахь заалт нэмж “Барилга байгууламжийг хүчитгэх” гэж	Барилга байгууламжийг хүчитгэх гэж нэмэх
8	14.6 дугаар зүйл	Барилга байгууламжид тавигдах шаардлага	14.6-д “тоноглолын” гэсний дараа “түүнчлэн хүчитгэх ажлын” гэж нэмэх	хүчитгэх
9	16 дугаар зүйл.	Барилгын ажлын талбайд тавих шаардлага	Угсралт, буулгалтын гэсний дараа хүчитгэх гэж нэмж оруулах 16.3-д “угсралт, буулгалтын” гэсний дараа “болон хүчитгэх” гэж нэмэх	хүчитгэх
10	26 дугаар зүйл	Барилгын ажлын зөвшөөрөл	“26.1.4.барилга байгууламжийг хүчитгэх” гэж нэмэх	Мөн барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

				төслийн үр нөлөөг үнэлсэн ажлын тайланд “барилга байгууламж барих талбайн хөрсний хүчитгэл, бэхэлгээний барилгын ажилд” гэж 26.1.4-д нэмэхээр тусгасан байна.
11	29 дүгээр зүйл	Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл	29.1.6-ийн дараа Түүх, соёлын дурсгалт барилга байгууламж гэж бие даасан ойлголт оруулах	Барилга байгууламжийн зориулалт гэдэг нь Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжуудад хамаарахгүй.
12	33 дугаар зүйлийн 33.1.23 дахь хэсэг	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	энэ хуулийн 10.1.4, 10.1.5 дахь заалтад заасан барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах	Өндөр болон онцгой төвөгшилтэй байгууллагын хувьд мэргэжлийн төв байгууллагын бүрэн эрхэд оруулах шаардлагатай
13	35 дугаар зүйл	Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх	35.1.6-д Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувьд 32.1.10-д барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл олгох дүрмэнд Соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний зөвшөөрлийг авах талаар нэмж тусгах	Соёлын өв хамгаалах тухай хуульд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн бүртгэл, хамгаалалт нь соёлын яаманд байх тул асуудал эрхэлсэн сайдын зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Өндөр болон онцгой төвөгшилтэй барилгын хувьд зөвшөөрөл олгох эрх аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарч байгаа нь амьдралд нийцэхгүй байгаа талаар барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн ажлын тайланд тусгасан байна.
Соёлын өвийг хамгаалах тухай хууль				
14	47.2.	Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	“Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам”, “Түүх, соёлын дурсгалт барига байгууламжийг хүчитгэх журам”-ыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж нэмэх	Барилгын тухай хуультай уялдуулсан

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

15	3 дугаар зүйл	3.1.7. ¹ “дурсгалт барилга байгууламж гэж” <i>Тайлбар: Дурсгалт барилга байгууламжийг архитектурын дурсгал, түүхэн барилга гэж ангилна.</i>	- уран барилгын цогцолбор, суварга, дуган, сүм хийд, байшин барилга зэрэг архитектурын дурсгал - түүхэн бие хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой байшин барилга зэрэг түүхэн барилга гэдгийг дурсгалт барилга байгууламж гэсэн ойлголтод хамааруулж томъёолно.	Хуулийн 3.1.3, 3.1.7-р зүйлд зааснаар Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн тухай ойлголтыг хамааруулахад зохицуулалт хоорондын зөрчилтэй байдлаас болж ойлгомжгүй байгаа тул шинээр томъёолох шаардлагатай. Энэ өөрчлөлттэй холбоотойгоор хуулийн 5 дугаар зүйлд “5.1.10 ¹ түүх, соёлын дурсгалт барилга байгууламж” гэж нэмэх.
	5 дугаар зүйл.	5.1.6 -аас “архитектурын дурсгал” гэдгийг хасах	5.2.Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлохдоо барилгын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан журмыг баримтална.	Тодорхойлох журмын эрх шилжүүлсэн зохицуулалтыг тусгасан.
16	8 дугаар зүйлийн 8.1	8.1 ¹ . Энэ хуулийн 5.1.10 ¹ -д заасан үл хөдлөх дурсгалын хамгаалалтын зэрэглэл тогтоох мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 8.1 ² . Энэ хуулийн 5.1.10 ¹ -д зааснаас бусад үл хөдлөх дурсгалын хамгаалалтын зэрэглэл тогтоох мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.		Энэ зүйлд үл хөдлөх дурсгалыг хамгаалалтад авах зэрэглэл тогтоох шалгуур, аргачлал, мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хуульчлах шаардлагатай. Мөн зэрэглэл тогтоох ач холбогдол харагдахгүй байгааг тодорхой болгох. Зэрэглэл хэн тогтоох ямар шалгуураар тогтоох гэдэг нь байхгүй.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

17	ЕСДҮГЭЭР БҮЛЭГ	СОЁЛЫН ӨВИЙГ ТОДОРХОЙЛОХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ, ХҮЧИТГЭХ ГЭЖ ӨӨРЧЛӨХ	Энэ бүлэгт 47 дугаар зүйл. Соёлын биет өвийг тодорхойлох, сэргээн засварлах, хүчитгэх үйл ажиллагаа “47.1.Соёлын биет өвийг тодорхойлох, сэргээн засварлах, хүчитгэхэд дараах зарчмыг баримтална.” гэж, “47.2-д “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам”, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална.” гэж өөрчлөн найруулж нэмэх; 47.3-ыг “Соёлын биет өвийг сэргээн засварласан, хүчитгэсэн ажлын дэлгэрэнгүй тайланг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан, архивт шилжүүлнэ.” гэж найруулах 47.4. 5.1.10¹-д заасан соёлын биет өвийн хийц бүтээцэд гарсан эвдрэл, гэмтэл болон ашиглалтын шаардлага хангах эсэхэд соёлын болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтарсан экспертиз томилж үнэлгээ хийлгэнэ. 47.5. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах, хүчитгэхэд шаардагдах зардлыг хамгаалалтын зэрэглэлээс нь шалтгаалан дараах эх үүсвэрээр санхүүжүүлж болно: 47.4.1. улсын төсвөөс; 47.4.2.орон нутгийн төсвөөс;	Энэ хуулийн 5.1.10¹-д заасан үл хөдлөх дурсгалыг хүчитгэх гэж ашиглалтын хэвийн нөхцөлийг /хангах/дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн тухайлсан зураг төслийн шийдлийн аргаар гүйцэтгэх барилгын ажлыг 47 дугаар зүйлд хүчитгэх гэж нэмж найруулсан. Журмын төсөл боловсруулагдсан. Санал өгнө. /“47.1.Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг газар хөдлөлт болон бусад байгалийн үзэгдэл, цаг хугацааны элэгдэлд тэсвэрлэх байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хүчитгэх барилгын ажлыг гүйцэтгэнэ./
----	-------------------	---	--	--

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

			47.4.3.хандив, тусламжийн хөрөнгө.	
18	33 дугаар зүйл.Соёлын биет өвийг өмчлөгчийн эрх, үүрэг	33. Энэ хуулийн 5.1.10¹ заасан үл хөдлөх дурсгалыг өмчлөгч, эзэмшигч нь Барилгын тухай хуулийн 46.1.1, 46.1.2, 46.1.3, 46.1.4, 46.1.5, 46.1.6, 46.1.7, 46.1.8, 46.1.9, 46.1.11, 46.1.12-д зааснаас гадна дараах үүрэгтэй: 1.соёлын өвөөр тогтоогдсон объектын төрх байдлын хадгалагдах болон өөрчлөгдөхгүй байх нөхцөлийг хангах; 2. объектыг өөрчлөх эсвэл түүнийг соёлын объектын хувьд хадгалахад шаардлагатай нөхцөл байдлыг дордуулах ажил хийхгүй байх; 3. барилгад мэдэгдэж байгаа бүх эвдрэл, осол, барилгад хохирол учруулах бусад нөхцөл байдлын талаар соёлын өвийн объектыг хамгаалахтай холбоотой байгууллагад нэн даруй мэдэгдэж, цаашид эвдэрч устахаас урьдчилан сэргийлж аваарын ажил явуулах зэрэг арга хэмжээ авах; 4. Тухайн дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлтийн ямар эрсдэлтэй бүст байрлаж байгаагаас шалтгаалан экспертизийн үнэлгээг өндөр эрсдэлтэй газар байрлаж байгаа бол 7-15 жил, дунд зэргийн эрсдэлтэй газар байрлаж байгаа бол 12-25 жил, бага эрсдэлтэй газар байрлаж байгаа бол 35 жил тутамд хийлгэх	Оросын Холбооны Улсын соёлын өвийн тухай” 2002 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн Холбооны хууль № 73-ФЗ-д заасан өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүргээс авч нэмж найруулсан. Газар хөдлөлийн бүсчлэлээс хамааран экспертизийн үнэлгээ хийлгэх үүргийг Шинэ Зеландын 2004 оны барилгын тухай хуулиас иш татаж найруулсан. Уг улсад энэ үнэлгээг хийлгээгүй бол 200,000 доллараар торгодог юм байна. Үүрэг зөрчсөн тохиолдолд хамгаалах зохицуулалтыг Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд оруулах шаардлагатай.	
Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль				
19	4.1.1	15.1. Хот, суурин газарт экологи, эдийн засаг, нийгмийн хөгжил, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгох, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэх зорилгоор хот	Ашиглах боломжгүй болсон түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувьд Соёлын яамнаас тусгайлан зөвшөөрөл авах талаар тусгах	Түүх, соёлын ашиглах боломжгүй болсон барилгын талаар тусгайлан заагаагүй.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

		төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулж, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулна 4.1.1. “ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламж” гэж барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтээр ашиглахыг хориглосон барилга байгууламжийг;		
	5.1.3.	5.1.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д заасан хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:	5.1.3. соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр тухайн орон нутагт нь хадгалах	Гэж 5.1.3 дахь заалт нэмж тусгах
	12.1.6		12.1.6.Түүх соёлын дурсгалт барилга, байгууламжийг хүчитгэн хэвээр хадгалах	Шинээр нэмэх
	18 ¹		18¹ дүгээр зүйл. Түүх соёлын дурсгалт барилга, байгууламжийг хүчитгэн хэвээр хадгалах 18 ¹ .1.Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэхэд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47.2-т заасан журам болон энэ хуулийн 14.7-д заасан төсөл хэрэгжүүлэх үе шатыг баримтална. 18 ¹ .2.	Шинээр нэмэх
20	16.6.	Ашиглалтын шаардлага хангахгүй түүх, соёлын дурсгалт, барилга байгууламжийг буулгах, шинээр барихад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47.4-т заасан экспертизийн дүгнэлтийг үндэслэнэ.		

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

21	15.14.6.	15.14.6. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл авна. 15.22. Соёлын чиглэлээр: 15.22.2. соёлын өвийг сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх.	Хүчитгэх гэж нэмэх	Хүчитгэх асуудлыг орхигдсон.
----	----------	---	--------------------	------------------------------

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ХҮЧИТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Ерөнхий ойлголт

Манай улс газар хөдлөлтийн бүсэд барилга төлөвлөх норм, дүрэмтэй болохоос өмнө баригдсан барилга байгууламж нь ерөнхийдөө соёлын өвийн хамгаалтад байдаг учраас тэдгээр барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлж, болзошгүй эрсдлийг тооцож, хүчитгэх шаардлагатай юм. Гэтэл өнөөг хүртэл Монгол улсад түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг үнэлэх, хүчитгэх тухай дүрэм, журам байхгүй, холбогдох хуулиудад барилга хүчитгэхтэй холбоотой зүйл заалт, тодорхойлолт байхгүй байсаар ирсэн байна.

Монгол улсад баригдсан 50 жилээс дээш насжилттай барилгууд ихэвчлэн үндсэн дөрвөн төрлийн хийцлэлийг хослуулж барьсан байна. Үүнд модон бүтээцтэй, чулуун болон тоосгон өрөгт бүтээцтэй, цутгамал багана дам нуруу, металл болон модон хучилт хосолсон хийцлэлтэй байна. Япон, Европ болон бусад гадаад улсууд нь Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх, сэргээн засварлах, шинэчлэн сайжруулах олон төрлийн аргыг өргөн ашиглаж байна. Манай оронд түгээмэл тохиолдох өрөгт бүтээцтэй барилгыг газар хөдлөлтөд тэсвэрлэлтийг нэмэгдүүлэх мөн эвдрэл гэмтлийг хүчитгэх зорилгоор ихэвчлэн нэмэлт металл хийцээр хүчитгэж байгаа нь судалгааны явцад ажиглагдав.

Төслийн багийн зүгээс Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг судалж боловсруулсан. Мөн холбогдох зарим эрх зүйн баримт бичиг, дүрэм журам, норм, нормативын баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журмын төслийг боловсрууллаа. Журмыг боловсруулахдаа дээр дурьдсан хуулиудад холбогдох зохицуулалтыг нэмэлтээр болон шинээр тусгах саналыг боловсруулсан бөгөөд энэхүү журмыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт заасны адил Барилга хот байгуулалтын сайд болон Соёлын сайд хамтран батлана.

Төслийн баг улс, нийслэл, дүүргийн хамгаалтад буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас Чойжин ламын сүм музей, Дуурь бүжгийн эрдмийн театрын барилга, Улаанбаатар хотын музей, Гоожингийн өндөр, Хүүхдийн урлан бүтээх төв болон Монголор барилгуудад урьдчилсан үзлэг хийж, үнэлсэн юм. Түүнчлэн эдгээр барилгуудаас Чойжин сүм музей (1904-1908 он) болон Монголын анхны хоёр давхар тоосгон барилга болох 1903-1905 онд баригдсан Монголорын

барилгад өмнө хийгдсэн нөхцөл байдлын судалгаанд үндэслэн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээг загвар болгон хийж гүйцэтгэсэн болно.

Одоогийн байдлаар газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэхэд модон бүтээцтэй, чулуун өрөгт болон инженерийн бус бүтээцтэй барилгад газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх аргачлал байхгүй байна. Мөн одоо байгаа барилгын нөхцөл байдлын судалгаа хийхэд 2000, 2001 онд батлагдсан БД 31-101-00, БД 31-102-00, БД 31-103-00, БД 31-104-01 барилгын дүрмүүд ажлын шаардлага хангахгүй тул шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Түүнээс гадна газар хөдлөлтийг үнэлэх ба хүчитгэх дүрмүүд нь нийтэд хэрэглэхийн тулд хялбарчилгаа хэрэглэсэн байдаг тул онцгой хариуцлагатай барилгад газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын утгыг өндрөөр тогтоож байгаа бөгөөд үүнтэй уялдуулж холбогдох норм нормативын баримт бичгийг сайжруулах нь зүйтэй.

ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ХҮЧИТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах ашиглалтын хугацааг нь уртасгах зорилгоор барилга байгууламжийг хүчитгэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Хүчитгэх үйл ажиллагаа

2.1. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх үйл ажиллагаа нь дараах ерөнхий дараалалтай байна.

2.1.1. хүчитгэх шаардлагатай эсэхэд үнэлгээ хийж дүгнэлт гаргах;

2.1.2. хүчитгэх төсөл (цаашид “төсөл” гэх) хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах;

2.1.3. төсөл хэрэгжүүлэгч нь барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулах, түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, хүчитгэх тухай сургалтанд хамрагдах;

2.1.4. хүчитгэлийн ажлын зураг төсөл боловсруулах;

2.1.5. хүчитгэлийн зураг төсөлд магадлал хийлгэх;

2.1.6. хүчитгэлийн зураг төслийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46-р зүйлийн 46.2 дахь заалтад заасан Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх;

2.1.7. хүчитгэх барилга байгууламжийг чөлөөлөх;

2.1.8. Барилгын тухай хуулийн 4.1.11-т заасан барилгын ажлыг гүйцэтгэх;

2.1.9. хүчитгэлийн ажлыг хүлээж авах, төслийг дуусгах.

2.2. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хуулийн 14 дүгээр зүйлд заасан төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шатыг баримтална.

2.3. Энэ журмыг төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

Гурав. Хүчитгэх шаардлагатай эсэхийг тогтоох

3.1. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд тухайн барилгыг хүчитгэх шаардлагатай эсэхэд үнэлгээ хийлгэх хүсэлтээ аймаг, нийслэлийн Засаг даргад гаргана.

3.2. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн барилга байгууламж нь ашиглалтын шаардлага хангаж буй болон хүчитгэх шаардлагатай эсэхийг газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд үндэслэж тогтооно.

3.3. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх шаардлагатай эсэхийг тогтоохдоо барилга байгууламжийн бүтээцийн төрлөөс нь хамааруулж дараах норм, нормативийн баримт бичгийг баримтална. Үүнд:

3.3.1. Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар, БД 31-103-00 {Тухайн барилгын паспортыг харгалзан үзнэ. Паспорт байхгүй тохиолдолд, эхлээд байгаа төлвөөр нь паспортжуулах шаардлагатай. Төсөл дууссаны дараа дахин шинээр паспортжуулан хүлээлгэн өгнө};

3.3.2. Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар, БД 31-101-00;

3.3.3. Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар, БД 31-102-00;

3.3.4. Орон сууцны барилгын физик элэгдлийг үнэлэх заавар, БД 31-104-01;

3.3.5. Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал, БД 22-105-18;

3.3.6. Цутгамал төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал, БД 22-106-18;

3.3.7. Угсармал хавтаалжин барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал, БД 22-107-18

3.4. Газар хөдлөлийн эрсдэлтэй бүсэд баригдсан барилгын төлөв байдалд, тухайн барилга байгууламжийн өмчлөгч нь аймаг, нийслэлийн барилга хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий газартай хамтран 1 жил тутамд инженерийн нөхцөл байдлын судалгаа хийлгэнэ. Хэмжилт, тооцоо, судалгаа, шинжилгээний тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

3.5. Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын алба энэхүү журмын 4.1-т заасан өргөдлийн дагуу тухайн барилгад хийсэн, 4.4-т заасан хэмжилт, тооцоо, судалгаа, шинжилгээний тайланг аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

3.6. Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь энэхүү журмын 4.4-д заасан хэмжилт, тооцоо, судалгаа, шинжилгээний тайланг хянан үзэж, Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан норм, нормативийн баримт бичгийг баримталж тухайн барилгыг хүчитгэх шийдвэрийг 21 хоногт багтаан гаргана.

3.7. Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь журмын 4.6-д заасан шийдвэрийг тухайн барилгын өмчлөгчид болон тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

Дөрөв. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

4.1. Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын алба нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 16-р дугаар зүйлийн 16.6-д заасан хүчитгэх шийдвэрийг хүлээн авмагц үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчдөд мэдэгдэж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 14 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.

4.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга хангахгүй, хүчитгэх шаардлагатай Түүх, соёлын дурсгалт барилгад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг, барилга хүчитгэгдэж ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд түр түдгэлзүүлсэн шийдвэр гаргаж аймаг, нийслэл, сум, дүүргийн барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад 3 хоногт багтаан хүргүүлнэ.

4.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь энэ журмын 4.2-т заасан шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллана.

4.4. Түүх, соёлын дурсгалд хамаарах, ашиглалтыг шаардлага хангахгүй, хүчитгэх шаардлагатай нь тогтоогдсон барилга байгууламжийг өмчлөгч нь Орон сууцны тухай хуульд ("Түүх, соёлын дурсгалд хамаарах нийтийн зориулалттай орон сууц" гэсэн шинээр нэмэх хэсэг) болон, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 181-р зүйлд заасны дагуу орон сууцны барилгад хүчитгэл хийлгэх тухай хүсэлтээ 14 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

4.5. Журмын 4.4-т заасан хүсэлтийг тухайн барилга байгууламжийг өмчлөгчдийн 80-аас доошгүй хувь дэмжсэн байна.

4.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь холбогдох журмын дагуу төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны дээд шатны байгууллагатай зөвшилцөн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж шийдвэрлүүлнэ.

4.7. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг өмчлөгчийн хүсэлт болон барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга Орон сууцны тухай хуульд заасны дагуу орон сууцыг хүчитгэх шийдвэрийг гаргана.

4.8. Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын алба нь тухайн барилгад хүчитгэх төсөл хэрэгжүүлэх ажлын даалгаврыг 14 хоногт боловсруулж, тухайн шатны Засаг дарга ажлын 3 өдрийн дотор батална.

Тав. Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах

5.1. Журмын 4.7-д заасан шийдвэр, 5.8-д заасан ажлын даалгаврыг үндэслэн аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын алба нь төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах урилгыг 14 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж, төсөл хүлээн авах ажлыг зохион байгуулна.

5.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хүчитгэх төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах шийдвэр гаргаж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог байгуулж, үйл ажиллагааны удирдамжийг батална.

5.3. Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

5.4. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хүчитгэх барилга байгууламжийн өмчлөгчийн төлөөлөл багтана.

5.5. Үнэлгээний хороо нь ирүүлсэн төсөл хэрэгжүүлэх санал тус бүрд үнэлэлт өгч, 30 хоногийн дотор дүгнэлт гаргана.

5.6. Үнэлгээний хорооны дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

5.6.1. Төслийн санал ирүүлсэн хуулийн этгээдийн ерөнхий ба туршлагын чадавхийн шалгуур үзүүлэлт бүрийн үнэлгээ;

5.6.2. Төслийн санал тус бүрийг үнэлсэн нийлбэр оноо;

5.6.3. Үнэлгээний хорооны гишүүн тус бүрийн болон нэгдсэн үнэлгээ;

5.6.4. Үнэлгээний хорооны нэмэлт санал.

5.7. Үнэлгээний хорооны дүгнэлтийг бичгээр үйлдэх бөгөөд гишүүн тус бүр албан тушаалаа тэмдэглэн, гарын үсэг зурж баталгаажуулж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

5.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсныг батламжилсан захирамж гарган, хоёр талт гэрээ байгуулах албан ёсны эрхийг шалгарсан этгээдэд олгоно.

5.9. Шалгарсан төсөл хэрэгжүүлэгч нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан төслийг боловсруулж батлуулна.

5.10. Шалгарсан гэрээ байгуулах эрх бүхий хуулийн этгээд нь тухайн барилгын үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчидтэй хоёр талт гэрээ байгуулна. Хоёр талт гэрээ нь гурван талт гэрээний хавсралт баримт байна.

5.11. Хоёр талт гэрээнд дараах зүйлсийг заавал тусгасан байна:

- 5.11.1. Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийн үндсэн мэдээлэл;
- 5.11.2. Үл хөдлөх хөрөнгийн үндсэн мэдээлэл;
- 5.11.3. Өмчлөлөөс татгалзаж, худалдах, худалдан авах тохиролцоо хийсэн тохиолдолд төлбөр төлөх хугацаа;
- 5.11.4. Барилгыг хүчитгэхтэй холбогдох зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай
- 5.11.5. Барилга чөлөөлөхтэй холбогдох зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай;
- 5.11.6. Төсөл хэрэгжих явцад үүсч болох эрсдэл, түүнийг шийдвэрлэх арга хэмжээ;
- 5.11.7. Талуудын гарын үсэг, тамга тэмдэг, огноо;
- 5.11.8. Бусад.

5.12. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг өмчлөгчид нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн

5.13. 22.2-т заасны дагуу иргэдийн төлөөллийн байгууллагыг байгуулна.

5.14. Төсөл хэрэгжүүлэгч нь аймаг, нийслэлийн Засаг даргаас олгогдсон төсөл хэрэгжүүлэх эрхээ бусдад шилжүүлэх эрхгүй.

Зургаа. Төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргуулах, гэрээ байгуулах

6.1. Журмын 6.10-т заасан гэрээ байгуулсан төсөл хэрэгжүүлэгч нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.2.а, 14.7.2.б-д заасан төлөвлөгөөг боловсруулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад 30 хоногийн дотор танилцуулна.

6.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь хуулийн этгээдээс ирүүлсэн төлөвлөгөөг хянаж, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.2.в-д заасны дагуу төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргана.

6.3. Тухайн шатны Засаг дарга нь аймаг, нийслэл, сум, дүүргийн улсын бүртгэл, статистикийн газар, хэлтэс болон газрын харилцааны асуудал эрхэлсэн байгууллагад төсөл хэрэгжиж дуусах хүртэл хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох талаар хүсэлт гаргана.

6.4. Төсөл хэрэгжүүлэгч нь хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан гурван талт гэрээний үлгэрчилсэн загварын дагуу өмчлөгч болон аймаг, нийслэлийн Засаг даргатай гурван талт гэрээ байгуулна.

6.5. Төсөл хэрэгжүүлэгч нь өмчлөгчтэй тохиролцон тухайн барилга байгууламжийг худалдах, худалдан авах гэрээ байгуулж болох бөгөөд худалдан авсан тохиолдолд гурван талт гэрээг байгуулахгүй.

6.6. Төсөл хэрэгжүүлэгч нь гурван талт гэрээ байгуулаагүй үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчтэй төслийн аль ч үе шатанд тохиролцох, ойлголцолд хүрэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7. Өмчлөгч, төсөл хэрэгжүүлэгч, аймаг, нийслэлийн Засаг дарга гурван талт гэрээ байгуулсны дараа Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан Хяналтын хороог байгуулна.

6.8. Хяналтын хорооны гишүүд нь барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулах түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хадгалах, хамгаалах сэргээн завсарлах, хүчитгэх үйл ажиллагаа явуулах тухай сургалтанд хамрагдна.

6.9. Төсөл хэрэгжүүлэгч нь барилга байгууламжийн хүчитгэлийн зураг төслийг Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8-д заасан Засгийн газраас баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн дагуу боловсруулж, батлуулна.

Долоо. Түүх, соёлын дурсгалт барилгыг чөлөөлөх

7.1. Төсөл хэрэгжүүлэгч нь барилгыг чөлөөлөх ажлыг зохион байгуулна.

7.2. Өмчлөгчийн амь нас, эд хөрөнгө, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй тохиолдолд Хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Эрчим хүчний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн тухайн барилга байгууламжийн цэвэр, бохир ус, дулаан, эрчим хүчний хэрэглээ, үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох хүртэл арга хэмжээг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлнэ.

7.3. Өмчлөгчийн эд хогшил эсхүл өмчлөгчийг түр байраар хангах үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

7.4. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан Засгийн газраас баталсан “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ыг баримтлан төсөл хэрэгжүүлэгч нь сууц өмчлөгчид нөхөх олговор олгоно.

Найм. Төсөл хэрэгжүүлж дуусгах

8.1. Төсөл хэрэгжүүлэгч нь барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад хүлээлгэн өгөх үйл ажиллагааг Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6, 32.1.10-т заасан Засгийн газраас баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”, “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу зохион байгуулна.

8.2. Төсөл хэрэгжүүлэгч нь өмчлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг гурван талт гэрээнд заасан хугацаанд тухайн барилга байгууламжийг хүчитгэж, шинэчлэн паспортжуулж, гэрээг эцэслэн дүгнэнэ.

Ес. Хариуцлага

9.1. Энэхүү журмын холбогдох заалтыг зөрчсөн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТ ТЭСВЭРЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэр дээр орших Чойжин ламын сүм музейн барилга, Баянзүрх дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэр дээр орших “Монг-Эм” ХХК-ийн эмнэлэгийн барилга дээр “Тоосгон барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн эксел хуудас” тооцооны програм ашиглан газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээг гүйцэтгэлээ.

Чойжн ламын сүм музейн барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ

1.1. Ерөнхий зүйл

Барилгын бүтээцийн тооцоонд дараах нормотив баримт бичгүүд болон судалгааны тайланд үндэслэн тооцов. Үүнд:

- Барилгын бүтээц ба буурийн ерөнхий найдваршил еөрөнхий шаардлага БНБД 20-01-11;
- Ачаалал ба үйлчлэл БНБД 20-04-17;
- Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23-01-09;
- Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01*/2006;
- Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм (нэмэлт өөрчлөлт) БНБД 22.01.01*/2006/2013;
- БД 22-105-18 “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал”
- 2019 оны КОНАР ХХК-ийн зөвлөх, зөвлөх инженер Л. Түмэндэмрэрэлийн биет судалгаа.
- Үнэлгээ хийж буй барилгын “СҮЛД ПРОЕКТ” ХХК-ийн 2019 онд дээврийн ажлын зураг.

1.2. Барилгын үндсэн мэдээлэл

Барилгын нэр : Чойжин ламын сүм музей барилга

Барилгын бүтээц : Модон баганатай, Тоосгон өрөгт бүтээцтэй барилга (1-2 давхар)

Барилгын урт × өргөн : 23.9 м × 15.88 м

Барилгын өндөр: 12.7 м (Давхрын өндөр: 3.75 м)

Барилга ашиглалтад орсон он: 1904-1908

Газар хөдлөлтийн балл: 8 балл

Хөрсний зэрэг: II

Өрөгт ханын шахалтын бат бэх: 35-40 кг/см²

Өрөгт ханын суналтын бат бэх: 0.03 МПа



Зураг 1. Чойжин ламын сүм музейн байршил

1.3. Биет судалгаа

Уг барилгад 2019 оны Л.Түмэндэмбэрэл биет судалгаа хийсэн. Биет судалгааны үр дүнгээр тоосгоны марк 35-40, зуурмагын марк тодорхойгүй. “Сүлд проект” ХХК гүйцэтгэсэн хэмжилтийн зургийг үндэслэв.


БД-н төслөөр биет судалгаагаар тодруулах шаардлагатай.

- Зуурмагийн үеийн зузаан болон босоо хэвтээ заадасны зуурмаг дүүргэлт;
- Өргийн гадаргуун хагарал, ан цав болон элэгдэл;
- Төмөр бетон бүсний бетоны шахалтын бат бэх, карбонизацийн гүн болон арматурлагдсан эсэх;


1.4. Барилгын зураг төсөл

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан

Байгуулалт 0,00




Зураг 2. Давхрын байгуулалт



Зураг 3. Нүүр тал

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*



Зураг 4. Ханын хэмжээс

Хүснэгт 1.

БНБД 22.01.01*/2006-н шаардлага хангасан эсэх

№	Шаардлага	Бодит хэмжээс	БНБД-н хязгаарын утга	Нормын шаардлага хангасан эсэх	Тайлбар
1	Дөр ханын хамгийн бага өргөн	1,22	1.16	Хангана	БНБД 22.01.01*/2006 9-р хүснэгт
2	Булангийн дөр ханын хамгийн бага өргөн	1.12	1.42	Хангахгүй	
3	Нүхний өргөний хамгийн их хэмжээ	5,58	3.0	Хангахгүй	
4	Дөр ханын өргөнийг нүхний хэмжээнд харьцуулсан харьцааны доод хэмжээ	1	0,50	Хангана	
5	Давхрын өндөр, м	3,5	4,0 (5.0)	Хангана	
6	Давхрын өндрийг ханын зузаанд харьцуулсан харьцаа	8,5	12	Хангана	
7	Тоосгоны шахалтын бат бэх	M30-40	M75	Хангахгүй	БНБД 22.01.01*/2006 3.29
8	Зуурмагийн шахалтын бат бэх	0,6 МПа	M25	Хангахгүй	

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

2. Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ

2.1. Х тэнхлэгийн чиглэл дэх 1-р давхрын газар хөдлөлтийн үнэлгээ

■ Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс I_{s0}


Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн балл
Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн баллаас хамаарах

	8
A=	0.2
I_{s0} =	0.200

■ Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_s

Барилгын давхрын тоо	n	=	1
Барилгын урт (м)		=	16.44
Барилгын өргөн (м)		=	16.74
Барилгын буурь хөрсийг газар хөдлөлтийн шинж чанараар ангилсан зэрэг		=	II
Барилгын хувийн хэлбэлзлийн нэгдүгээр хэлбэрт харгалзах динамик илтгэлцүүр	β	=	2.50
Үнэлгээ хийж буй давхрын дугаар	i	=	1
Үнэлгээ хийж буй болон түүнээс дээш давруудын нийт талбай	A_i	=	275.21
Барилгын нэгж талбайд ногдох босоо ачаа	w	=	25
Тухайн давхраас дээш давхруудаас ирэх нийт босоо ачаа	ΣW	=	6880.14
Давхрын өндөр	H	=	3.60

Тайлбар:		
		Өгөгдөл оруулах хэсэг
		Үр дүн гарах хэсэг



Барилгын хувийн хэлбэрийн нэгдүгээр хэлбэрт харгалзах динамик илтгэлцүүр										н		у		EW						
Барилгын хувийн хэлбэрийн нэгдүгээр хэлбэрт										2		1.8		SW						
Барилгын хувийн хэлбэрийн нэгдүгээр хэлбэрт										у		1.8								
Давхар	Ханын тэмдэглэгээ	Ханын зузаан	Ханын урт	Ханын өндөр	Ханын жин	(n+1)/(n+1)	Өргийн шахалтын бат бэх	Өргийн сунгалтын бат бэх	Үндсэн хослол өргийн босоо хүчдэл	Датуу хүч	Ханын хөндлөн огтлолын талбай	Ханын эсэргүүцлийн момент	Тулгуурын нөхцөл	Ханын бус хавтгай гулбайх		Шалгах нөхцөл	Шахах хүчдэл (3.2a)	Өөрийн бус хавтгай шахаланд тэсвэртэй эсэх	Сунгалтын хүчдэл (3.2 б)	Өөрийн бус хавтгай сунгаланд тэсвэртэй эсэх
														R (N/mm ²)	R (N/mm ²)					
1	SW58	580	1770	9160	186.2	1.00	2.2	0.22	0.157	161.2	1,026,600	99,238,000	Нугасан	106.60	2	1.23	Тийм	0.92	Үгүй	
2	SW58	580	1770	9160	186.2	1.33	2.2	0.22	0.083	85.2	1,026,600	99,238,000	Нугасан	142.13	2	1.52	Тийм	1.35	Үгүй	
1	SW58	580	1250	9160	131.5	1.00	2.2	0.22	0.157	113.8	725,000	70,083,333	Нугасан	75.28	2	1.23	Тийм	0.92	Үгүй	
2	SW58	580	1250	9160	131.5	1.33	2.2	0.22	0.083	60.2	725,000	70,083,333	Нугасан	100.37	2	1.52	Тийм	1.35	Үгүй	
1	SW58	580	2650	9160	278.8	1.00	2.2	0.22	0.157	241.3	1,537,000	148,576,667	Нугасан	159.59	2	1.23	Тийм	0.92	Үгүй	
2	SW58	580	2650	9160	278.8	1.33	2.2	0.22	0.083	127.6	1,537,000	148,576,667	Нугасан	212.79	2	1.52	Тийм	1.35	Үгүй	
1	SW58	580	2500	9160	263.0	1.00	2.2	0.22	0.157	227.7	1,450,000	140,166,667	Нугасан	150.56	2	1.23	Тийм	0.92	Үгүй	
2	SW58	580	2500	9160	263.0	1.33	2.2	0.22	0.083	120.4	1,450,000	140,166,667	Нугасан	200.74	2	1.52	Тийм	1.35	Үгүй	

M100кг/см2=10МПа

Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн баллаас хамаарах илтгэлцүүр										Барилгын давхрын тоо		Ханын хувийн жин		Хүнлэгийн хавтгай сууцан хана						
Барилгын хувийн хэлбэрийн нэгдүгээр хэлбэрт										н		у		EW						
Барилгын хувийн хэлбэрийн нэгдүгээр хэлбэрт										2		1.8		SW						
Барилгын хувийн хэлбэрийн нэгдүгээр хэлбэрт										у		1.8								
Давхар	Ханын тэмдэглэгээ	Ханын зузаан	Ханын урт	Ханын өндөр	Ханын жин	(n+1)/(n+1)	Өргийн шахалтын бат бэх	Өргийн сунгалтын бат бэх	Үндсэн хослол өргийн босоо хүчдэл	Датуу хүч	Ханын хөндлөн огтлолын талбай	Ханын эсэргүүцлийн момент	Тулгуурын нөхцөл	Ханын бус хавтгай гулбайх		Шалгах нөхцөл	Шахах хүчдэл (3.2a)	Өөрийн бус хавтгай шахаланд тэсвэртэй эсэх	Сунгалтын хүчдэл (3.2 б)	Өөрийн бус хавтгай сунгаланд тэсвэртэй эсэх
														R (N/mm ²)	R (N/mm ²)					
1	SW58	580	1770	2000	40.7	1.00	2.2	0.22	0.157	161.2	1,026,600	99,238,000	Нугасан	5.08	1	0.21	Тийм	-	Тийм	
2	SW58	580	1770	3750	76.2	1.33	2.2	0.22	0.083	85.2	1,026,600	99,238,000	Нугасан	23.82	2	0.32	Тийм	0.16	Тийм	
1	SW58	580	1250	3750	53.8	1.00	2.2	0.22	0.157	113.8	725,000	70,083,333	Нугасан	12.62	2	0.34	Тийм	0.02	Тийм	
2	SW58	580	1250	3750	53.8	1.33	2.2	0.22	0.083	60.2	725,000	70,083,333	Нугасан	16.82	2	0.32	Тийм	0.16	Тийм	
1	SW58	580	2650	3750	114.1	1.00	2.2	0.22	0.157	241.3	1,537,000	148,576,667	Нугасан	26.75	2	0.34	Тийм	0.02	Тийм	
2	SW58	580	2650	3750	114.1	1.33	2.2	0.22	0.083	127.6	1,537,000	148,576,667	Нугасан	35.66	2	0.32	Тийм	0.16	Тийм	
1	SW58	580	2500	3750	107.7	1.00	2.2	0.22	0.157	227.7	1,450,000	140,166,667	Нугасан	25.23	2	0.34	Тийм	0.02	Тийм	
2	SW58	580	2500	3750	107.7	1.33	2.2	0.22	0.083	120.4	1,450,000	140,166,667	Нугасан	33.64	2	0.32	Тийм	0.16	Тийм	

M100кг/см2=10МПа

Дүгнэлт

1. Барилгын хувийн хэлбэлзлийн нэгдүгээр хэлбэрт харгалзах динамик илтгэлцүүр β_1 :

Барилга нь 2 давхар тоосгон барилга тул БНБД 22-01-01*/2006 “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”-ийн дагуу II зэргийн хөрсөнд харгалзах динамик илтгэлцүүр β_1 -ийн утга нь 2.5 болно.

2. Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн суурь индекс E_0

Барилгын гадна өргийг даацын хана байсныг өөрийн даацат хана болгосон тул ханын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг сайн.

Насжилтын индекс T :

Үнэлгээ хийж барилгад биет судалгаа насжилтын индексийг нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлоход хангалтгүй тул хялбарчилсан үнэлгээгээр 0.8-р авсан болно.

3. Хэлбэрийн индекс S_D :

Үнэлгээ хийж буй барилга байгуулалтын болон өндрийн дагуу зөв хэлбэртэй боловч зоорийн давхартай, Өндрийн дагуу шинээр төлөвлөсөн хэсэгтэй заадасгүй, хоорондоо бэхэлгээгүй тул $S_D = 1,0$ гарсан болно.

4. Ханын өөрийн хавтгайд газар хөдлөлт тэсвэрлэлт

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн индексийн утга нь дагуу чиглэлдээ 0.297-аас 0.405 -ын хооронд, хөндлөн чиглэлдээ 0.268-ээс 0.417-ын хооронд хана өөрийн хавтгайд $I_{so}=0.200\text{м/с}^2$ -с их тул газар хөдлөлт тэсвэрлэлт нь хангалттай байна.

5. Ханын өөрийн бус хавтгайд газар хөдлөлт тэсвэрлэлт

Барилгын гадна өрөгт ханыг хучилттай бэхэлсэн зураг байхгүй байгаа тул ханын өөрийн бус хавтгайд ажиллах өндрийг хаяавчний түвшингээс нийт өндрийн дагууд авч тооцвол ханын суналтын бат бэх хангалтгүй, өөрийн бус хавтгайд газар хөдлөлт тэсвэрлэхгүй байна. Иймд ханыг өндрийн дагууд хучилттай холбосон бэхэлгээ шаардлагатай.

6. Нэгдсэн дүгнэлт

Гадна даацын ханыг өөрийн даацат хана байхаар бүтээц төлөвлөлтийг өөрчилсөн тул өөрийн хавтгайд ханын газар хөдлөлт тэсвэрлэлт хангалттай. Дотор хучилтыг буулгаж, шинээр хийх хучилттай холбосон бүтээц төлөвлөөгүй тул ханын өөрийн бус хавтгайд газар хөдлөлт тэсвэрлэлт хангалтгүй гарсан тул хучилтын түвшинд хананд холбох шаардлагатай.

ТАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТЫГ БОЛОВСРУУЛАХ БА ЭРЭМБЭЛЭХ

Өнөөгийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эртний булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө дурсгал, хот суурины үлдэгдэл, архитектурын дурсгал, түүхэн барилга, тахил, тайлгын байгууламж зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал арвин их оршдог билээ. Тэдгээрийг шинжлэх ухааны үндэстэй судлах асуудал 1891 оны В.В.Радловын шинжилгээний ангийн судалгаагаар эхэлсэн бөгөөд 1921 онд Ардын Засгийн газраас Монголын анхны шинжлэх ухааны байгууллага Судар бичгийн хүрээлэнг байгуулснаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх, судлан шинжлэх ажлыг эхлүүлсэн байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэдэг нь архитектурын болон археологийн дурсгал, байгаль, түүх, соёлын дурсгалт газар буюу тухайн газартаа хүрээлэн байгаа орчны хамт хадгалан хамгаалж байж түүхэн үнэ цэнэ, ач холбогдол нь оршдог дурсгалуудыг хэлдэг.

1924 онд “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг баталсан бөгөөд Монгол Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 11 дүгээр сарын 13-ний хурлын 79 дүгээр тогтоолоор “Хуучны дурсгалт зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг шинэчлэн баталж, эртний хот балгас, хэрмийн үлдэгдэл зэрэг 15 дурсгалыг улсын нэгдүгээр зэргийг хамгаалалтад, бичигт хөшөө, сүм хийд зэрэг 16 дурсгалыг улсын хамгаалалтад бүртгэн эрэмбэлж анхны жагсаалтыг баталжээ.

1970 онд “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль” батлагдсан нь түүх, соёлын дурсгалт зүйлийг нэр төрлөөр нь ангилан тэдгээрийг хамгаалах, ашиглах, судлан шинжлэх, сурталчлах, өвлөн эзэмших, хууль зөрчигсдөд хариуцлага хүлээлгэх зэрэг тодорхой харилцааг зохицуулсан анхны бие даасан эрх зүйн баримт бичиг байв. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, судалж шинжлэх, сурталчлахаар зогсохгүй, тэдгээрийг засаж сэлбэх, сэргээн засварлах ажил төрийн бодлогын түвшинд тавигдах болсон нь энэ талаар гарсан чухал ололт байлаа. БНМАУ-ын СнЗ-ийн 1971 оны 420-р тогтоолоор “БНМАУ-ын хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын жагсаалтыг баталж улсын хамгаалалтад 21 дурсгал, орон нутгийн хамгаалалтад 106 дурсгалыг авсан байна.

Монгол Улс 1990 оноос хойш хүн төрөлхтний нийтлэг замд нэгдэж, дэлхий дахинд нээлттэй болж эхэлсэн нь соёлын өвийг хамгаалах талаар олон улсын чанартай гэрээ, конвенцид нэгдэн орж идэвхтэй ажиллах нөхцлийг

бүрдүүлсэн юм. Тухайлбал, 1990 онд ЮНЕСКО-гийн “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци”-д, 1991 онд “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенци”-д тус тус нэгдэж орсноор тэдгээрийн үзэл санаа, үндсэн зарчмууд болон шаардлагыг соёлын өвийг хамгаалах хууль тогтоомж, бусад баримт бичигт тусган хэрэгжүүлж эхэлжээ. Үүний өмнө Монгол Улс 1964 онд “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай” 1954 оны Гаагийн хэлэлцээрт нэгдэн орж түүний үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч, тууштай дэмжиж ирсэн юм. Ийнхүү олон улсын конвенциудад Монгол Улс нэгдэн орсон нь соёлын өвийг хамгаалах үйлс болон түүний эрх зүйн орчинг бэхжүүлэхэд үндсэн эргэлт болсон билээ. Түүнчлэн эдгээр конвенцид нэгдэн орсноор манай улс түүх, соёлын үнэт дурсгалаа “Дэлхийн өвийн жагсаалт”-ад бүртгүүлэх, тэдгээрийг хадгалж хамгаалах, сэргээн засварлахад мэргэжилтний болоод хөрөнгийн талаар олон улсын байгууллагын дэмжлэг тусалцааг авах таатай боломж нээгдсэн юм.

1994 онд “Монгол Улсын Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг шинэчлэн батлав. Энэ хууль түүх, соёлын дурсгалт зүйл гэдэг ухагдахууныг шинжлэх ухаан, урлаг, эрх зүйн үүднээс нарийвчлан тодорхойлж, түүх, соёлын дурсгалыг сурвалжлан олох, бүртгэх, зэрэглэл тогтоох, археологийн малтлага хийх, сурталчлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглах, хил гаргахтай холбогдсон бүхий л харилцааг шинээр зохицуулсан юм. Мөн ондоо “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг батлахдаа олон улсын жишгийн дагуу түүх, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзсанаас гадна түүхэн цаг хугацааг өөрийн орны онцлогт тохируулан 1924 оноос өмнө баригдсан уран барилга, түүхийн дурсгалт барилга байгууламжийг оруулахаар эрдэмтэн судлаач, мэргэжилтний зөвлөлөөр тогтсон билээ.


Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг баталж улсын хамгаалалтад 119, аймаг, нийслэлийн хамгаалалтад 233 дурсгалыг; Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор уг жагсаалтад нэмэлт оруулж улсын хамгаалалтад 177 (хоёр дурсгалыг дараа нь нэмсэн), аймаг, нийслэлийн хамгаалалтад 275 дурсгал байхаар тус тус хамгаалалтад авсан байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

2015-2016 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас орон даяар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг анх удаа зохион байгуулжээ. Энэхүү улсын тооллогоор Монгол Улсын 21 аймгийн 330 орчим сумын нутагт

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

орших 9537 дурсгалт газар, 86157 үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэжээ. Нийт бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас барилга, архитектурын дурсгал нь 2820 буюу гурван хувийг эзэлж байна (Зураг 1).



Зураг 1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогод хамрагдсан дурсгалын төрөл, тоо, эзлэх хувийг харуулсан байдал

Дээрх улсын тооллогын дүнгээс харахад түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг төрлөөр нь:

1. Чулуун зэвсгийн дурсгалт газар
2. Хадны зураг, бичгийн дурсгал
3. Булш оршуулгын дурсгал
4. Тахил тайлгын байгууламж
5. Барилга, архитектурын дурсгал
6. Хөшөө дурсгал
7. Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар хэмээн ангилжээ.

Үүнээс 5. Барилга, архитектурын дурсгалд:

1. суурьшлын үл мөр бүхий газар;
2. эртний хот (Хүннү, Түрэг, Уйгар, Кидан, Монгол, Манж, тодорхойгүй);
3. хэрмэн зам;
4. шуудуу;
5. сүм хийдийн туурь;
6. суварга;
7. түүхэн дурсгалт байшин;
8. агуй оромж, түр сууц;
9. архитектурын дурсгал гэж хамруулаад “Архитектурын дурсгал”

гэдэгт:

- 9.1. уран барилга;
- 9.2. уран барилгын цогцолбор;
- 9.3. сүм хийд;
- 9.4. уран баримал, хөшөө (1921-1990);
- 9.5. Сүрлэг чимэглэлийн дүрслэл зэргийг багтаасан байна.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Дээрх тооллогын дүнг үндэслэж Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.1 дэх заалтын дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалтын түвшингээр нь зэрэглэж, Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор улсын хамгаалалтад 185, БСШУС-ын сайдын 2020 оны А/161 тоот тушаалаар аймаг, нийслэлийн хамгаалалтад 607 үл хөдлөх дурсгал байхаар жагсаалтыг баталжээ.

Хүснэгт 1.

**Хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын
жагсаалтын товъёог**

Жагсаалт батлагдсан он Зэрэглэл	1941	1971	1994	1998	2008	2020
Улсын хамгаалалтад	29	21	93	119	177	185
Аймаг, нийслэлийн хамгаалалтад	-	106	287	233	275	607
Нийт тоо	29	127	380	352	452	792

Дээрх жагсаалтын улсын хамгаалалтад байх 185 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг судалж үзэхэд 54 дурсгал нь Барилга, архитектурын дурсгалын төрөлд хамаарч байгаа ба түүнээс 21 дурсгал нь эртний хотын туурь байна (Хүснэгт 2, Зураг 2).

Хүснэгт 2.


**Улсын хамгаалалтад байгаа барилга, архитектурын дурсгалын
жагсаалт**

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Дурсгалын нэр
1.	Архангай	Өгий нуур	Талын гурван хэрэм
2.		Хотонт	Дойтын толгойн туурь
3.		Хотонт	Хар балгас
4.		Эрдэнэмандал	Хархул хааны балгас
5.		Батцэнгэл	Луу гүний хүрээний Цогчэн дуган
6.		Эрдэнэбулган	Зая гэгээний хийдийн цогцолбор
7.	Баянхонгор	Галуут	Чин сүжигт номун хааны хийдийн цогцолбор
8.		Эрдэнэцогт	Хачин ламын сүм
9.	Булган	Дашинчилэн	Цогтын Цагаан байшин, гэрэлт хөшөө
10.		Дашинчилэн	Харбухын балгас
11.		Дашинчилэн	Чин толгойн балгас
12.		Хутаг-Өндөр	Бийбулагийн балгас
13.	Дорноговь	Иххэт	Олон байшинтын туурь

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

14.		Иххэт	Хэсэг байшинтын туурь
15.	Дорнод	Халхгол	Их бурхантын цогцолбор дурсгал
16.		Цагаан-Овоо	Хэрлэн барс хотын туурь, суварга
17.	Дундговь	Адаацаг	Сүм Хөхбүрдийн балгас
18.		Эрдэнэдалай	Сангийн далай хийдийн Цогчэн дуган
19.		Эрдэнэдалай	Үнстийн хийдийн Цогчэн дуган
20.	Өвөрхангай	Хайрхан дулаан	Хөгшин тээлийн балгас
21.		Хархорум	Мэлхий толгойн туурь мэлхий чулуу
22.		Хархорум	Хархорум хотын туурь, чулуун яст мэлхий
23.		Батөлзийт	Төвхөн хийд
24.		Хархорин	Шанхын хийдийн дуганууд
25.		Хархорин	Эрдэнэ Зуу хийдийн цогцолбор
26.		Хархорин	Ханджамцын суварга
27.	Өмнөговь	Ханбогд	Дэмчигийн хийд
28.		Ханбогд	Эрээтийн хийд,
29.		Ханбогд	Цогзолын хийдийн туурь
30.	Төв	Баянжаргалан	Гуа дов
31.		Бор нуур	Бороогийн суурин
32.		Мөнгөнморьт	Бүрхийн дөрвөлжин
33.		Мөнгөнморьт	Тэрэлжийн дөрвөлжин
34.		Зуумод	Манзуширын хийдийн туурь, бурхадын зураг
35.		Мөнгөнморьт	Сарьдагийн хийдийн туурь
36.		Эрдэнэ	Гүнжийн сүмийн үлдэгдэл
37.	Сэлэнгэ	Алтанбулаг	Ардын намын Төв хороо, Түр Засгийн газар байрлаж байсан байшин
38.		Баруунбүрэн	Амарбаясгалант хийдийн цогцолбор
39.	Хөвсгөл	Арбулаг	Эрчүү хотын туурь
40.	Хэнтий	Батширээт	Өглөгчийн хэрэм
41.		Дэлгэрхаан	Аваргын балгас
42.		Өмнөдэлгэр	Балдан Бэрээвэн хийдийн цогцолбор, бурхадын зураг, бичээс
43.		Хэрлэн	Цэцэн ханы ордны цогцолбор
44.	Улаанбаатар	Хан уул	Туулын Хар түнийн ордны туурь
45.		Баянгол	Гандантэгчэнлин хийдийн цогцолбор
46.		Баянзүрх	Ардын намын Төв хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан байшин
47.		Баянзүрх	Дарь-Эхийн сүмийн чулуун багана, Гол сүм
48.		Сүхбаатар	Дамбадаржаа хийдийн цогцолбор
49.		Сүхбаатар	Дашчойлин хийдийн гэр хэлбэрт модон дуганууд
50.		Сүхбаатар	Чин ван Ханддоржийн байшин
51.		Сүхбаатар	Чойжин ламын сүмийн цогцолбор
52.		Хан уул	Богд хааны Ногоон ордны цогцолбор
53.		Чингэлтэй	Анхны “Өндөр хоршоо”-ны 2 давхар байшин
54.		Чингэлтэй	Гэсэр сүмийн цогцолбор

**Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан**



Зураг 2. Улсын хамгаалалтад байгаа барилга, архитектурын дурсгалын тоо

Харин аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 607 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг судлахад 111 дурсгал нь Барилга, архитектурын дурсгалын төрөлд хамаарч байна (Хүснэгт 3, Зураг 3).

Хүснэгт 3.

**Аймаг, нийслэлийн хамгаалалтад байгаа барилга, архитектурын
дурсгалын жагсаалт**

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Дурсгалын нэр
1.	Архангай	Булган	Тамирын голын хэрэм
2.		Өгийнуур	Чилэн балгас
3.		Төвшрүүлэх	Хөх сүмийн туурь
4.		Өлзийт	Бишрэлт гүний хүрээний дуганууд
5.		Цэнхэр	Цагаан сүмийн балгас
6.	Баянхонгор	Өлзийт	Түйн голын (Бор) балгас
7.		Баян-Өндөр	Гялтгануурын суварга
8.		Баян-Өндөр	Амарбуяантын хийд
9.		Баянцагаан	Жаргалантын хийдийн туурь
10.		Заг	Алмаст хавцалын суварга
11.		Заг	Баянцагаан нурууны цонж
12.		Эрдэнэцогт	Ламын гэгээний хийдийн туурь
13.	Булган	Баяннуур	Майхан уулын Улаан хэрэм
14.		Бүрэгхангай	Эмгэнтийн хэрэм
15.		Бүрэгхангай	Шувуутын хэрэм
16.		Булган	Баруун замын байлдааны ангийн штабын байшин
17.		Булган	Диваажингийн сүм
18.		Булган	Майдарын голын Цагаан суварга
19.		Булган	Худалдааны пүүсийн байшин
20.	Рашаант	Булган	Хөгнө хан уулын Их, бага хийдийн туурь
21.	Говь-Алтай	Шарга	Халзан ширээгийн балгас
22.		Тайшир	Наробанчин хийдийн туурь
23.		Чандмань	Чандмань овоо
24.	Говьсүмбэр	Сүмбэр	Зүүн Чойрын хийдийн туурь

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*


25.	Дорноговь	Сайншанд	Хамрын хийдийн туурь
26.		Сайншанд	Сүлдэн хөх овоо
27.		Улаанбадрах	Баян модны шивээ
28.		Улаанбадрах	Хөтөөгийн шивээ
29.		Хөвсгөл	Цувираагийн хийдийн туурь
30.	Дорнод	Баяндун	Тогоонтөмөр хааны хэрэм (хорооны дов. Шалзат толгойн балгас)
31.		Баяндун	Чингисийн хэрмэн зам
32.		Баянуул	Чингисийн хэрмэн зам
33.		Булган	Тугийн сүмийн туурь
34.		Гурванзагал	Чингисийн хэрмэн зам
35.		Дашбалбар	Чингисийн хэрмэн зам
36.		Халхгол	Улаан гангын хэрэм
37.		Цагаан-Овоо	Зүүн дөрөө хэрэм
38.		Матад	Алтан Очиртын хийдийн туурь
39.		Сэргэлэн	Галын овооны дурсгал (Овоо)
40.		Халхгол	Утай уулын хийдийн туурь
41.		Халхгол	Халхын сүмийн туурь
42.		Чойбалсан	Ламын гэгээний хийдийн туурь
43.		Чулуунхороот	Монгол цагаан нуурын дурсгал
44.	Дундговь	Баянжаргалан	Эмээл толгойн хэрэм
45.		Сайхан-Овоо	Шаазан хотын туурь
46.		Цагаандэлгэр	Бат оригийн хэрэм
47.		Дэлгэрхангай	Хошуу хийдийн туурь
48.		Дэлгэрцогт	Хадан сүмийн туурь
49.		Өлзийт	Чулуун сүмийн туурь
50.	Завхан	Тэс	Сүмийн толгойн туурь
51.		Алдархаан	Яруугийн хүрээний туурь
52.		Улиастай	Сангийн хэрэм
53.	Өвөрхангай	Баруун Баян-Улаан	Шаазан толгойн туурь
54.		Богд	Илжгэн чихт хааны хэрэм
55.		Бүрд	Шарилангийн голын хэрэм
56.		Тарагт	Дөрвөлжингийн хэрэм
57.		Төгрөг	Зост хотын туурь
58.		Хархорум	Баянголын дурсгал
59.		Төгрөг	Мазар хотын туурь
60.		Нарийнтээл	Мандухайн шивээ
61.		Нарийнтээл	Ламын гэгээний суварга
62.		Нарийнтээл	Цэвэлваанчигдоржийн суварга
63.		Хархорин	Дагвадаржаа ламтны суварга
64.	Өмнөговь	Гурвантэс	Овоотын хийдийн туурь
65.		Номгон	Сангийн далай хийд
66.		Баян-Овоо	Сайрын балгас
67.		Номгон	Баянбулгийн туурь
68.		Ханбогд	“Мангасын хүрээ” хэмээх хэрэм
69.		Ханхонгор	Годил балгас
70.		Хүрмэн	Шивээ хатавч буюу Чингисийн далан
71.		Хүрмэн	Шивээ хатавчийн суурин

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

72.		Цогт-Овоо	Тогоонтөмөр хааны хэрэм
73.		Цогтцэций	Хээрийн булгийн хэрэм
74.	Сүхбаатар	Дарьганга	Сүмтийн хотын туурь
75.		Эрдэнэцагаан	Халтарын хийдийн туурь
76.	Сэлэнгэ	Алтанбулаг	Ардын хувьсгалын түүхэнд холбогдох барилга, байшин
77.		Баянгол	Загдалын голын хэрэм
78.		Мандал	Бороогийн дөрвөлжин
79.		Орхон	Цант хотын туурь
80.	Төв	Дэлгэрхаан	Мишиг гүний хүрээний туурь
81.		Баян	Сантын ширээний туурь
82.		Баяндэлгэр	Өндөр дов
83.		Баянжаргалан	Байшинтын дэрсийн хэрэм
84.		Заамар	Нумын толгойн хэрэм
85.		Заамар	Хэрмэн дэнжийн балгас
86.		Мөнгөнморьт	Өндөр довын хэрэм
87.	Увс	Улаангом	Харлаг бэйсийн сүм
88.	Ховд	Жаргалант	Сангийн хэрэм
89.		Үенч	Харуул овоо
90.	Хөвсгөл	Бүрэнтогтох	Загзуугийн хэрэм
91.		Галт	Хужиртийн хүрээний чулуун суварга
92.		Жаргалант	Гэлэнхүүгийн суварга
93.		Жаргалант	Жаргалантын дуган
94.		Жаргалант	Тойн эрдэнэ Тээлийн амны арын хүрээний 108 гишгүүр бүхий хийдийн туурь
95.		Цагаан-Үүр	Даян дээрхийн дурсгал
96.	Хэнтий	Баянхутаг	Модонгийн хэрэм
97.		Баянхутаг	Ханзат хотын хэрэм
98.		Жаргалтхаан	Цэнхэрийн голын хэрэм
99.		Мөрөн	Баруун хэрэм
100.		Мөрөн	Зүүн хэрэм
101.	Улаанбаатар	Баянзүрх	Анхны европ хоёр давхар байшин
102.			Анхны холбооны байшин
103.			“Гоожингийн өндөр” хэмээх байшин
104.			Консулын дэнжийн нууц бүлгэм байрлаж байсан байшин
105.			Сүхбаатар жанжны анхны хөшөө
106.		Сүхбаатар	Дондогдулам хатны дурсгалын суварга
107.			Ерөнхий сайд П.Гэндэнгийн амьдарч байсан байшин
108.			Мал тариалангийн яам байрлаж байсан байшин
109.		Хан-Уул	Богд хааны Хүрэн ордны зарим байшин (Богдын зуны ордон, Богдын торгон цэргийн байр, Дондогдулам хатны сэрүүн лаврин)
110.		Чингэлтэй	Зүүн хүрээний нууц бүлэг байрлаж байсан байшин
111.			Ерөнхий сайд Д.Жигжиджавын амьдарч байсан байшин

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Дээрх жагсаалтаас үзэхэд 111 барилга, архитектурын дурсгалын 54 нь эртний хотын туурь байна.



Зураг 3. Аймаг, нийслэлийн хамгаалалтад байгаа барилга, архитектурын дурсгалын тоо

Улс болон аймаг, нийслэлийн хамгаалалтад байх барилга, архитектурын дурсгалыг нэгтгэн, байрлаж буй орон нутаг буюу аймаг, нийслэлээр нь нийт 165 дурсгалын жагсаалтыг гаргаснаар засаг захиргааны харьяаллыг нэг дороос харах боломжтой юм. (Зураг 4).



Зураг 4. Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байгаа барилга, архитектурын дурсгалын тоо

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтын дагуу Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах ёстой. Түүний дагуу сумын хамгаалалтад авах түүх, соёлын

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

үл хөдлөх дурсгалын мэдээллийг цэгцлэх, бүртгэх, жагсаалтыг батлах зэрэг ажил сүүлийн жилд эрчимтэй өрнөж байгаа билээ.

Судалгааны хүрээнд сум, дүүргээс нийт 3739 дурсгалын мэдээ, бүртгэл ирснээс, сум болон дүүргийн хамгаалалтад давхардсан байдлаар барилга, архитектурын 189 дурсгал хамрагдсан байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4.

**Сум, дүүргийн хамгаалалтад байгаа барилга, архитектурын
дурсгалын жагсаалт**

д/д	Аймаг, нийслэл	Сум	Дурсгалын нэр
1.	Архангай	Батцэнгэл	Зосын үзүүрийн хэрэм
2.		Батцэнгэл	Бунхантын хийдийн туурь
3.		Батцэнгэл	Хэрмийн хөндийн хэрэм
4.		Булган	Тусгалтын хийдийн туурь
5.		Жаргалант	Хоолтын хүрээний туурь
6.		Жаргалант	Эрдэнэ уулын хийдийн туурь
7.		Жаргалант	Асайтын хүрээний туурь
8.		Өлзийт	Олзот уулын туурь
9.		Тариат	Баянжаргалантын дуганы туурь
10.		Тариат	Тариатын хүрээний туурь
11.		Хайрхан	Жарантайн хүрээний туурь
12.		Хайрхан	Хануйн хүрээний туурь
13.		Хангай	Мөрөнгийн хүрээний туурь
14.		Хашаат	Хажуу худагын туурь
15.		Хашаат	Их номгоны хийдийн туурь
16.		Цэцэрлэг	Бухын хүрээний туурь
17.		Цэнхэр	Бүрдийн дуганы туурь
18.		Цэнхэр	Хөшөөтийн амны сүмийн туурь
19.		Чулуут	Бүрдийн дуганы туурь
20.		Чулуут	Шиваа ширээтийн хүрээний туурь
21.		Эрдэнэмандал	Домчын тохойн туурь
22.		Эрдэнэмандал	Цоргын шороон хэрэм
23.		Эрдэнэбулган	Заяын хүрээний төгс баясгалант буян дэлгэрүүлэгч хийд
24.		Эрдэнэбулган	Заяын хүрээний Цогчин дугана
25.	Баян-Өлгий	Алтай	Сүм хийд
26.		Алтанцөгц	Гэрийн буйр, тахилга, хиргисүүр
27.		Алтанцөгц	Гэрийн буйрт
28.	Баянхонгор	Эрдэнэцогт	Гачэн ламын сүм
29.		Түйн голын баруун дэнж	Түйн бор балгас
30.		Хийдийн гэзгийн өвөрт	Хийдийн гэзэг
31.		Баян-Өндөр	Амарбуянт хийд
32.		Баян-Өндөр	Гялтагануурын суварга
33.		Баянговь	Чандмана уулын хийдийн туурь

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

34.		Бөмбөгөр	Дашгалдан жасын хийдийн туурь
35.		Бөмбөгөр	Хотын булангийн хэрэмний туурь
36.		Бөмбөгөр	Бөмбөгөр аймаг байгуулагдсан туурь
37.		Бөмбөгөр	Байшингийн булангийн хийдийн туурь
38.		Баянбулаг	Хадатын хүрээний туурь
39.		Баянбулаг	Сангийн далайн хүрээний туурь
40.		Хатан суудал 5-р баг	Цонж туурь
41.	Булган	Хишиг-Өндөр	Баруун хүрээний туурь
42.		Хишиг-Өндөр	Эрдэнэ хамбын хүрээ
43.		Хишиг-Өндөр	Цогтын цэргийн хуарангийн туурь
44.		Хишиг-Өндөр	Цогтын цэргийн цамхаг
45.	Говьсүмбэр	Шивээговь	Эрээний туурь
46.	Дорноговь	Алтанширээ	Холбоогийн хийдийн туурь
47.		Айраг	Их жаргалан хийдийн туурь
48.		Айраг	Бага Нардын хийдийн туурь
49.		Айраг	Хайлынгийн хурлын туурь
50.		Айраг	Их усны хийдийн туурь
51.		Айраг	Бударын хийдийн туурь
52.		Айраг	Бухтын муу ус хуучин сумын туурь
53.		Мандах	Өлгий хийдийн орчим газар
54.		Хөвсгөл	Бөөрийн хийдийн туурь
55.		Хөвсгөл	Бумбатын хийдийн туурь
56.		Хөвсгөл	Саран хөөврийн хурлын туурь
57.		Хөвсгөл	Улаан толгойн хийдийн туурь
58.		Хөвсгөл	Дэрсэнэ усны хийдийн туурь
59.		Сайхандулаан	Олон Хүрээний хийдийн туурь
60.		Даланжаргалан	Их Нартын хийдийн туурь
61.		Дэлгэрэх	Найман маналын суварга
62.	Завхан	Баянхайрхан	Холбоо гурван суварга
63.		Баянхайрхан	Хуйн дуганы туурь
64.		Завханмандал	Хүүхдийн овооны суварга
65.		Их-Уул	Түрэг улсын Алаг байван хааны оршин байсан хотын суурь, мэлхий чулуун хөшөө
66.		Нөмрөг	Хийдийн хашаанд Бурхан багшийн их бодь суварга
67.		Нөмрөг	Их булаг хийдийн туурь
68.		Отгон	Хүрээний туурь
69.		Отгон	Гэндэнпилийн хийдийн туурь
70.		Тосонцэнгэл	Марзын рашаан, овоо, хүрд, бурхан, гэрийн буурь
71.		Тосонцэнгэл	Шумуултайн хүрээний туурь
72.		Тосонцэнгэл	Бирваа бэйс ноёны их, бага гэрийн бууц
73.		Тосонцэнгэл	Шумуултайн Очирвааны суварга
74.		Тосонцэнгэл	Байшинтын сүмийн туурь
75.		Тосонцэнгэл	Авдалайн сүмийн туурь
76.		Тосонцэнгэл	Дашпилжээлин хийдийн 108 суварга
77.		Тосонцэнгэл	Суваргат хайрханы 9-н цагаан суварга
78.		Түдэвтэй	Хутагтуудын суварга

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

79.		Тэс	Сүмийн туурь Барилга
80.		Тэс	Амбаны гэрийн буурь, барилга
81.		Цагаанхайрхан	Дуутын хүрээний туурь
82.		Цэцэн-Уйл	Галуутайн хүрээний туурь
83.		Шилүүстэй	Ном Буянт Цагаан суварга
84.		Шилүүстэй	Уулийн өврийн Цагаан суварга
85.	Өвөрхангай	Арвайхээр	Ганданпунцоглин хийдийн туурь
86.		Баянгол	Шар хоолойн суварга
87.		Баянгол	Цагаан булангийн туурь
88.		Баянгол	Харчин дуганы туурь
89.		Богд	Сайрын хашаатын хурлын туурь
90.		Богд	Ноён хутагтын хийдийн туурь
91.		Баян-Өндөр	Харзтайн дуганы туурь
92.		Баян-Өндөр	Цайдамын дуганы туурь
93.		Хархорин	Гацаагийн барилгын туурь
94.		Хархорин	Эрдэнэтолгойн суварга
95.		Хархорин	Зуугийн ламын сүмийн туурь
96.		Хархорин	Удганын сүмийн туурь
97.		Хархорин	Жаргалантын туурь
98.		Хархорин	Захын булгийн туурь
99.		Хужирт	Хөх эргийн туурь
100.		Хужирт	Сант хайрханы туурь
101.		Сант	Зээрэнгийн хийдийн туурь
102.		Тарагт	Зүүн хүрээний хийдийн туурь
103.		Тарагт	Баруун хүрээний туурь
104.		Тарагт	Хачин дуганы хийдийн туурь
105.		Төгрөг	Мазарын хотын чулуун суурь
106.		Төгрөг	Баянгийн жасын туурь
107.		Төгрөг	Уушгийн хийдийн туурь
108.		Төгрөг	Зост хотын туурь
109.		Өлзийт	Яргайтын баруун хийд
110.		Өлзийт	Илдэн бээлийн хүрээний туурь
111.		Уянга	Дочийн дуутын хийдийн туурь
112.		Уянга	Олон сүмийн хөлийн туурь
113.		Уянга	Өвгөн хийдийн туурь
114.		Зүүнбаян-Улаан	Эрээтийн хийдийн туурь
115.		Зүүнбаян-Улаан	Аглагийн хийдийн туурь
116.		Есөнзүйл	Далай гүний хүрээний туурь
117.	Сүхбаатар	Сүхбаатар	Дашгүндэдлин хийдийн туурь
118.		Сүхбаатар	Мандалын хийдийн туурь
119.		Сүхбаатар	Ламын хийдийн туурь
120.		Сүхбаатар	Яргайтын хийдийн туурь
121.		Сүхбаатар	Дэрсэн хашаатын хийдийн туурь
122.		Сүхбаатар	Арын нуурын дуганы туурь
123.		Сүхбаатар	Хавхаастай хийдийн туурь
124.		Сүхбаатар	Пунгийн сүмийн туурь
125.		Баруун-Урт	Суварга
126.		Онгон	Өвгөн хурлын туурь
127.		Онгон	Баян бүрдийн хурлын туурь

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

128.		Онгон	Дөрвөн худгийн сүмийн туурь
129.		Онгон	Дэрсэн худгийн сүмийн туурь
130.		Онгон	Их булгийн хийдийн туурь
131.		Онгон	Цагаан худгийн хийдийн туурь
132.		Онгон	Юншөөбү хүрээний туурь
133.		Түвшинширээ	Допанлин хийдийн туурь
134.		Түвшинширээ	Хүйтэнгийн хийдийн туурь
135.		Асгат	Авдрын голын хийдийн туурь
136.		Мөнххаан	Ганжуурын хийдийн туурь
137.		Мөнххаан	Цагаан чулуутын хурлын туурь 2 том барилга
138.		Мөнххаан	Далай вангийн хүрээний туурь
139.		Мөнххаан	Боонгийн хийдийн туурь
140.		Мөнххаан	Өндөр Майдарын хийдийн туурь
141.		Мөнххаан	Цагаан Номун хааны хийдийн туурь
142.		Мөнххаан	Цогтын буюу Хамжлагын хийдийн туурь
143.		Мөнххаан	Эрдэнэ уулын хийдийн туурь
144.		Мөнххаан	Хавхагтын хийдийн туурь
145.		Дарьганга	Бургасант дуганы туурь
146.		Дарьганга	Рашаантын хийдийн суурь
147.		Дарьганга	Овоотын хийдийн туурь
148.		Дарьганга	Сүмтийн буюу Гуулин хотын туурь
149.		Дарьганга	Ногоон дара эхийн суварга
150.		Халзан	Хатавчийн хийдийн туурин дээрх суварга
151.		Халзан	Хатавчийн хийдийн туурь
152.		Эрдэнэцагаан	Байшин
153.		Эрдэнэцагаан	Өндөр хамрын хийдийн туурь
154.		Эрдэнэцагаан	Хавхчин хийдийн хурлын туурь
155.		Эрдэнэцагаан	Егүзэр хутагтын хийдийн туурь
156.		Эрдэнэцагаан	Тохойн голын туурь
157.		Баяндэлгэр	Өгөөмөрийн хурлын туурь
158.		Баяндэлгэр	Ширээтийн хийдийн туурь
159.		Баяндэлгэр	Цагаан худгийн сүмийн туурь
160.	Төв аймаг	Баян	Эргэнэгийн булгийн жасын туурь
161.		Баян	Элгэн усны жасын туурь
162.		Баянцогт	Хуурай хийдийн туурь
163.		Баянцогт	Агьтын хийдийн туурь
164.		Борнуур	Бор толгой дахь Дашлин сүм суварга
165.		Бүрэн	Зүрхийн уул Чулуун суварга
166.		Жаргалант	Зөөхий хөндийн дуганы туурь
167.		Заамар	Хэрмэн дэнжийн шороон хэрэм
168.		Заамар	Нумын тохойн шороон хэрэм
169.		Заамар	Гоолой наймааны суурин
170.		Заамар	Доржзодовлин хийдийн дуганы туурь
171.		Лүн	Аймгийн анхны захиргааны байшин
172.		Өндөрширээт	Цахирын суварга
173.		Архуст	Байшинтын дэрс дэх эртний хотын туурь
174.		Алтанбулаг	Туулын гүний хүрээ /Навааннэрэнгийн хүрээ/-ний туурь
175.	Увс	Хяргас	Дэжээлин хийдийн туурь

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

176.	Ховд	Дөргөн сум	Баянхайрхан уулын орой дахь гэрийн буурь
177.		Дөргөн сум	Бодь суварга
178.		Жаргалант	Сангийн хэрэм
179.		Жаргалант	Шар сүмийн туурь
180.		Алтай	Суварга
181.		Үенч	Улиастайн морьт хорооны туурь
182.	Улаанбаатар	Хан-Уул	Тойрол хааны ордны туурь
183.		Хан-Уул	Богдын Хүрэн ордны цогцолбороос үлдсэн барилгууд
184.		Хан-Уул	Цогтбадамжавын байшин
185.		Баянзүрх	Гэр хэлбэрт модон дуган
186.		Сүхбаатар	Дамбадаржаалин хийд
187.		Сүхбаатар	П.Гэндэнгийн амьдарч байсан байшин
188.		Сүхбаатар	Бэтүб хийд
189.		Сүхбаатар	Түвдэнпэлжээлин хийд

Сум болон дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад бүртгэгдсэн 189 дурсгалаас 171 дурсгал нь барилга, архитектурын дурсгал, 18 дурсгал нь эртний хотын туурь байна (Зураг 5).



Зураг 5. Сум, дүүргийн хамгаалалтад байгаа барилга, архитектурын дурсгалын тоо

Дээрх судалгаанаас үзэхэд улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтын жагсаалтад орсон барилга, архитектурын дурсгалаас улс хамгаалалтад 54, аймаг, нийслэлийн хамгаалалтад 111, сум, дүүргийн хамгаалалтад орсон 189 дурсгал хамгаалалтын зэрэглэлд багтсан буюу нийт 354 барилга, архитектурын дурсгалын тоон дүн гарч байна.

Гэхдээ Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор улсын хамгаалалтад 185, БСШУС-ын сайдын 2020 оны А/161 тоот тушаалаар аймаг, нийслэлийн хамгаалалтад 607 үл хөдлөх дурсгал байх жагсаалтыг баталсан боловч өнөөдрийн байдлаар сумын болон дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт бүгд албажин батлагдаагүй байна.

Дээрх шийдвэрээр нийслэлийн буюу Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр байгаа түүх, соёлын дурсгалт барилгаас 10 дурсгалт барилга улсын хамгаалалтад авсны 8 нь архитектурын дурсгал, 2 нь түүхэн дурсгалт барилга байгаа бөгөөд 9 түүхэн дурсгалт барилгыг нийслэлийн хамгаалалтад авсны 3 нь нураачихсан барилга оржээ. Энэхүү улсын болон нийслэлийн хамгаалалтад авсан дурсгалт барилгын жагсаалтад түүхийн болон архитектурын үнэ цэнэтэй, барилга, архитектурын хөгжлийг төлөөлөл болсон дурсгалт барилгууд ороогүй орхигдсон байдаг.

Иймээс төслийн хүрээнд нийслэлийн болон зарим аймгийн нутаг дэвсгэр дээр оршиж буй түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн судалгааг хийж “Шинээр хамгаалалтад авах түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн жагсаалт”-ын төслийг боловсруулсан болно. Энэхүү жагсаалтыг газар дээр нь хийсэн судалгаа, түүхийн болон баримтат судалгаа, Үндэсний архивын Зураг төслийн баримтын архивт хадгалагдаж буй барилгын ажлын зураг, аман судалгаа зэргийг харьцуулан судалсны үндсэн дээр монголын архитектурын түүх, улиран өнгөрүүлсэн он цаг, дахин давтагдашгүй урлаг, уран сайхны үнэ цэнэ, ач холбогдол зэрэг шалгуур үзүүлэлтээр тодорхойлон 43 дурсгалт барилга байгууламжийг сонгон “Дурсгалт барилгын нэр; гэрэл зураг; ашиглалтад орсон он; зохиогч архитектор; архитектур, бүтээц; тайлбар.” гэсэн асуулгаар хүснэгтлэн, хамгаалалтад авах зэрэглэл болон ашиглалтад орсон оноор эрэмбэлэн жагсаалтыг боловсрууллаа (Хүснэгт 5).

Хүснэгт 5.


Шинээр хамгаалалтад авах түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн жагсаалт

д/ д	Дурсгалт барилга байгууламжийн нэрс	Ашиглал тад орсон он	Зохиогч архитектор	Архитектур ба бүтээц	Тайлбар
1	2	3	4	5	6
Улсын хамгаалалтад авах					
1	Гадаад хэргийн яам 	1946	Оросын архитектор Н.Щепетильн иков	Классицизм, Мод, тоосго	ЗХУ-ын Гавьяат архитектор Н.Щепетильн иков (1914- 1994) 1941 оноос Монголд 6 жил ажилласан, монголын шинэ үеийн уран барилгыг хөгжүүлэхэд

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

					үнэтэй хувь нэмэр оруулсан хүн.
2	Намын дээд сургууль байсан байшин (Удирдлагын академи) 	1946	-	Классицизм, Мод, тоосго	Оросын архитекторы н зураг байж магадгүй.
3	Х.Чойбалсангийн өвлийн ордон байсан барилга (Маршалын өргөө) 	1947	Зөвлөлт Оросын архитектор Н.Щепетильн иков	Сонгодог архитектур (классицизм) Мод, Тоосго	Х.Чойбалсан гийн эдэлж хэрэглэж байсан тавилга, эд өлгийн зүйлс, цэцэрлэг дэх уран баримлууд, сүүдрэвч хашаа хаалга зэрэг нь “түүх, соёлын цогцолбор өв” болно.
4	МУИС-ийн Хичээлийн 1- р байр 	1947	Зөвлөлт Оросын архитектор Н.Щепетильн иков	Сонгодог архитектур, Мод, тоосго	
5	Төв поликлиник байсан барилга 	1947	-	Сонгодог архитектур, мод, тоосго	Оросын архитекторы н зураг байж магадгүй.
6	Дуурь бүжгийн эрдмийн театр 	1949	Германы архитектор Герхард Козель	Сонгодог архитектур, Мод, тоосго	Козель.Г.Г (1909-2003) Германы архитектор, Томск хотод ажиллаж байхдаа 1942 онд МУ- ын ДБТ-ын зураг төслийг хийсэн.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

					Архитектор Б.Чимэд оролцсон.
7	Үндэсний номын сан 	1951	Оросын архитектор Н.Щепетильн иков	Сонгодог архитектур, Мод тоосго	Архитектор Б.Чимэд оролцсон.
8	Улсын Драмын Эрдмийн театр 	1960	Архитектор Б.Чимэд	Сонгодог архитектур, Мод тоосго	Б.Чимэд (1918-1980) нь 1948 онд Москвагийн Архитектуры н Дээд сургууль төгссөн монголын анхны архитектор.
Бүгд 8					
Аймгийн хамгаалалтад авах					
9	Дорнод аймаг. Чойбалсан сум.Аймгийн захиргааны байсан барилга (Аймгийн музей) 	1948	-	Зөвлөлт Оросын сонгодог архитектур, Мод, тоосго	Барилгын нүүр талд 1946-1948 он гэж бичсэн байдаг.
10	Өвөрхангай. Хужирт сум. Рашаан сувиллын анхны барилга 	1959	Архитектор Б.Чимэд	Социализмын үеийн архитектур Мод, тоосго	
11	Ховд аймаг. Жаргалант сум. Хөгжимт драмын театр 	1962	Архитектор Б.Дамбийня м	Үндэсний архитектур, Мод, тоосго	Б.Дамбийня м (1924- 2001) нь 1956 онд Москвагийн Архитектуры н Дээд Сургуулийг төгссөн ба монголын хоёр дахь архитектор.
Бүгд 3					
Нийслэлийн хамгаалалтад авах					
12	1930-1951 онд Засгийн газар байсан барилга (Боловсролын Их	1930	-	Конструктивиз м, Мод, тоосго	1943 онд 3 давхар болгож, 1957 онд


*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

	Сургууль) 				баруун талыг хойш нь нэмж өргөтгөжээ. 1951 оноос Багшийн Дээд сургууль болсон.
13	Цэргийн төв клуб байсан байшин (Кино урлагийн дээд сургууль) 	1930 оны эхэн үе	Зөвлөлт Оросын архитектор Гусив	Конструктивизм, Мод, тоосго	
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдэрийн яам 	1934	-	Сонгодог архитектур, Мод, тоосго	1934-1949 онд Цэргийн явдлын яам, 1949-1952 онд Улсын батлан хамгаалах яам, 1934 оноос Мал, тариалангийн яам тус тус байжээ.
15	Монгол банкны барилга 	1936	-	Конструктивизм, Мод, тоосго	Нэмэлт зургийг архитектор Б.Дамбийням
16	Арван жилийн 1-р сургууль 	1940	Оросын архитекторын зураг байж магадгүй.	Социализмын үеийн архитектур. Мод, тоосго	Монголын анхны 4 давхар барилга. Уг барилгын нүүрэн талд Урлагийн гавьяат зүтгэлтэн, уран барималч С.Чоймболын урласан

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

					“БНМАУ-ын сүлд түүний хоёр талд В.И.Ленин-И.В.Сталин болон Д.Сүхбаатар-Х.Чойбалсан нарын ингэмэл” байжээ.
17	Офицеруудын ордон 	1940	-	Зөвлөлт Оросын архитектур, Мод, тоосго	
18	“Алтай” зочид буудал байсан байшин (НЗД-ын Тамгын гаар) 	1947	Оросын архитектор Нэр нь тодорхойгүй	Классик архитектур, Мод, тоосго	1961 оноос Улаанбаатар хотын захиргаа байрлах болсон.
19	Элдэв-Очирын нэрэмжит кино театр байсан байшин (Хөрөнгийн бирж) 	1947	Зөвлөлт Оросын архитектор М.С.Яншин	Сонгодог архитектур, Мод, тоосго	Зөвлөлт Оросын Башкирын Уфа хотын “Ялалт” кино театрын зургаар барьсан.
20	ЗГ-ын газрын ажилчдын 32 айлын сууц 	1947	Оросын архитектор К.П.Логинов	Сонгодог архитектур, Мод, тоосго	
21	“Туул” зоогийн газар 	1948	-	Модерн архитектур, Мод, тоосго	XIX зууны сүүл XX эхэн үед европт хөгжиж байсан.
22	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	1955	-	Зөвлөлт оросын үеийн Мод, тоосго	

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

					
23	Үйлдвэрчний Төв Зөвлөлийн ордон (МҮЭХолбоо) 	1956	Архитектор Б.Чимэд	Конструктивизм Мод, тоосго	
24	Хүүхдийн урлаг бүтээх төв 	1958	Оросын архитектор И.П.Антипов	Неоклассизм Мод, тоосго	ЗХУ-ын Рязань хотын Пионерийн ордны зургаар барьсан.
25	Үндэсний Архивын байсан барилга 	1958?	Архитектор Б.Дамбийня м	Социализмын. үеийн архитектур, Мод, тоосго	
26	Санхүү, эдийн засгийн дээд сургууль 	1958	Архитектор Б.Чимэд	Социализмын. үеийн архитектур, тоосго	
27	Энх тайвны гүүр 	1958	-	Дорнын архитектур Төмөр бетон, чулуу,	Хятадын архитекторы н зургаар барьсан. Урт нь 400м, өргөн нь 12м
28	Одон орон судлалын төв	1959	Архитектор А.Хишигт	Модерн архитектур, Мод, тоосго	А.Хишигт (1932-2014) 1957 онд Ленинградын Барилга инженерийн


*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

					дээд сургууль төгссөн, монголын гурав дахь архитектор.
29	Спортын төв ордон 	1959	-	Азийн социализмын архитектур. Мод, тоосго	
30	“Улаанбаатар” зочид буудал 	1961	Архитектор Б.Чимэд	Сонгодог архитектур. Мод, тоосго	
31	Багшийн сургууль  	1962	Инженер Заячаров	Сонгодог архитектур, Мод, тоосго	
32	Сонгины амралтын барилга 	1964	Архитектор Б.Дамбийням	Сонгодог архитектур, Мод тоосго	
Бүгд 21					
Дүүргийн хамгаалалтад ааах					
33	“Монгол’Ор”-ын контор байсан барилга 	1905	-	Модерн архитектур. Тоосго, чулуу,	
34	Н.К.Рерихийн амьдарч байсан байшин	1905	-	Оросын архитектур, мод	

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

					
35	Анхны их дэлгүүр, анхны “Ард” кино театр байрлаж байсан байшин(ИХУТөв) 	1910 -аад оны сүүл	-	Модерн архитектур, Мод, тоосго	
36	Улаанхуарангийн хоёр давхар барилга (Батлан хамгаалах их сургууль) 	1920-оод оны эхэн үе	-	Зөвлөлт Оросын архитектур Мод, тоосго	
37	МУИС-ийн анхны барилга (Зориг сан) 	1926	-	Конструктивизм, Мод,тоосго	Гол хаалганы хэсгийг өөрчилсөн.
38	“Шар дэлгүүр” байсан байшин 	1936	Н.Климов	Конструктивизм, Мод,тоосго	
39	Олон улсын нисэх буудлын анхны байшин (Нисэхийн музей) 	1936	-	Социализмын үеийн Архитектур, Мод, тоосго-	

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан

40	“Буян-Ухаа” нисэх онгоцны буудал байрлаж байсан байшин 	1955	-	Сонгодог архитектур Мод, тоосго	
41	Төмөр замын соёлын ордон 	1958	-	Зөвлөлт оросын архитектур Мод, тоосго	
42	Анхны орон сууцны хороолол: 1-р 40 мянгат. 40,42,44,60,62-р байр 	1958-1960	-	Зөвлөлт оросын архитектур. Мод, тоосго	УИД-ийн урд, Ерөнхий сайд Цэрэндоржийн гудамжны 2 талд тэгш хэмийн байрлалтай арктай “Г” хэлбэрийн 2 барилга
43	Төр хурахын амны хуучин Айргийн амралтын байсан 2 байшин 	1963	-	Зөвлөлт оросын архитектур Мод, тоосго	
Бүгд 11					
НИЙТ 43					

Дээрх жагсаалтад багтсан түүх, соёлын дурсгалт 43 барилгын гурав нь Өвөрхангай, Ховд, Дорнод аймагт оршдог тул тухайн аймаг нь хамгаалалтад авахаар, нийслэлд орших 40 дурсгалт барилга байгууламжийн 8-ыг нь улсын, 21-ийг нийслэлийн, 11-ийг дүүргийн зэрэглэлээр хамгаалалтад тус тус авахаар эрэмбэлж төсөлд тусгав. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтад заасны дагуу нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар дээрх 40 барилгыг эхлээд дүүргийн хамгаалалтад авч баталгаажуулан,

дараа улс, хотын хамгаалалтад, аймгийн хамгаалалтад авах гурван дурсгалт барилгыг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулж хамгаалалтад тус тус авч, цаашид хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Төслийн хүрээнд улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад байх барилга, архитектурын нийт 354 дурсгал, хамгаалалтын зэрэглэлд ороогүй, хамгаалалтад авах шаардлагатай 43 дурсгалыг нэмж оруулаад бүгд 397 барилга архитектурын дурсгалын Урьдчилсан жагсаалтыг гаргасан болно.

Энэхүү Урьдчилсан жагсаалтад хамрагдсан дурсгалыг төрөл зүйлээр нь Эртний хотын туурь; Түүхэн байшин; Суварга овоо; Сүм хийдийн туурь, үлдэгдэл; Сүм хийдийн архитектурын дурсгал гэж 5 төрөлд хувааж тоон үзүүлэлтийг гаргав (Зураг 6).



Зураг 6. Урьдчилсан жагсаалтын 397 дурсгалын төрөл зүйлийн ангилал

Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад орсон болон хамгаалалтад авах шаардлагатай нэмэлтээр оруулсан нийт 397 барилга архитектурын дурсгалыг холбогдох он цаг болон түүхэн үеэр нь Хүннү, Уйгур, Хятан, Манж, XIII-XIV зуун, XV-XVI зуун, XVI-XVII зуун, XVII-XVIII зуун, XIX зуун, 1900 оноос хойш, тодорхойгүй гэж хуваан тус бүрчлэн тоон дүнг нэгтгэв (Зураг 7).



Зураг 7. Урьдчилсан жагсаалтын 397 дурсгалыг он цагаар нь ангилсан байдал

ХҮЧИТГЭХ ШААРДЛАГАТАЙ ДУРСГАЛТ БАРИЛГА БАГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу түүхэн тодорхой орон зай, цаг хугацааг төлөөлж чадах, түүх, соёл, шинжлэх ухаан, урлаг, соёлын үнэ цэнэ, ач холбогдолтой улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад бүртгэгдэж, эрх зүйн хувьд батлагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт болон соёлын өвийн болон архитектурын судлаачийн судалгаанд тулгуурлан санал болгосон дурсгалт барилга, байгууламжийн жагсаалтаас хүчитгэх шаардлагатай түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийн сонгон жагсаалтын төслийг боловсрууллаа.

Урьдчилсан жагсаалтаас хүчитгэх шаардлагатай түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийг дараах үзүүлэлтээр сонгов. Үүнд:

1. Байгалийн гамшигт (газар хөдлөлт, үер, хүчтэй шуурга, гал түймэр гм) үзэгдлийн мужлал, бүсэд байрладаг эсэх;
2. Нурах, эвдрэх аюул, эрсдэл үүссэн эсэх;
3. Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэл үүссэн эсэх;
4. Аялал жуулчлал, эдийн засгийн ач холбогдолтой байдал;
5. Ашиглалтын шаардлага хангахгүй байдал.

Улс, аймаг, нийслэл, сум дүүргийн хамгаалалтад хамрагдсан 354, шийнээр хамгаалалтад авах 43, нийт 397 барилга, архитектурын урьдчилсан жагсаалтаас хүчитгэх шаардлага үүссэн 69 дурсгалыг сонгон авсан билээ (Хүснэгт 6).

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Хүснэгт 6.

Хүчитгэх шаардлагатай барилга, архитектурын дурсгалын жагсаалт

д/д	Хамгаалалтын зэрэглэл	Тус бүрийн тоо	Аймаг	Сум	Дурсгалын нэр
1.	Улсын хамгаалалтад	1	Архангай	Хотонт	Хар балгас
2.		2	Архангай	Эрдэнэмандал	Хархул хааны балгас
3.		3	Архангай	Батцэнгэл	Луу гүний хүрээний Цогчэн дуган
4.		4	Архангай	Эрдэнэбулган	Зая гэгээний хийдийн цогцолбор
5.		5	Баянхонгор	Галуут	Чин сүжигт номун хааны хийдийн цогцолбор,
6.		6	Баянхонгор	Эрдэнэцогт	Хачин ламын сүм
7.		7	Булган	Дашинчилэн	Цогтын Цагаан байшин, гэрэлт хөшөө
8.		8	Булган	Дашинчилэн	Харбухын балгас
9.		9	Булган	Хутаг-Өндөр	Бийбулагийн балгас
10.		10	Дорнод	Халхгол	Их бурхантын цогцолбор дурсгал
11.		11	Дорнод	Цагаан-Овоо	Хэрлэн барс хотын туурь, суварга
12.		12	Дундговь	Адаацаг	Сүм Хөхбүрдийн балгас
13.		13	Дундговь	Эрдэнэдалай	Сангийн далай хийдийн Цогчин дуган
14.		14	Дундговь	Эрдэнэдалай	Үнстийн хийдийн Цогчин дуган
15.		15	Өвөрхангай	Батөлзийт	Төвхөн хийд
16.		16	Өвөрхангай	Хархорум	Шанхын хийдийн дуганууд
17.		17	Өвөрхангай	Хархорум	Эрдэнэ зуу хийдийн цогцолбор
18.		18	Өвөрхангай	Хархорум	Ханджамцын суварга
19.		19	Өмнөговь	Ханбогд	Дэмчигийн хийд
20.		20	Төв	Зуумод	Манзуширын хийдийн туурь, бурхадын зураг
21.		21	Төв	Мөнгөнморьт	Сарьдагийн хийдийн туурь
22.		22	Төв	Эрдэнэ	Гүнжийн сүмийн үлдэгдэл
23.		23	Сэлэнгэ	Алтанбулаг	Ардын намын Төв хороо, Түр Засгийн газар байрлаж байсан байшин
24.		24	Сэлэнгэ	Баруунбүрэн	Амарбаясгалант хийдийн цогцолбор
25.		25	Хэнтий	Батширээт	Өглөгчийн хэрэм
26.		26	Хэнтий	Өмнөдэлгэр	Балдан Бэрээвэн хийдийн цогцолбор, бурхадын зураг, бичээс
27.		27	Хэнтий	Хэрлэн	Цэцэн ханы ордны цогцолбор
28.		28	Улаанбаатар	Баянгол	Гандантэгчэнлин хийдийн цогцолбор
29.		29	Улаанбаатар	Баянзүрх	Ардын намын Төв хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан байшин


*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

30.		30	Улаанбаатар	Баянзүрх	Дарь-Эхийн сүмийн чулуун багана, гол сүм
31.		31	Улаанбаатар	Сүхбаатар	Дамбадаржаа хийдийн цогцолбор
32.		32	Улаанбаатар	Сүхбаатар	Дашчойлин хийдийн гэр хэлбэрт модон дуганууд
33.		33	Улаанбаатар	Сүхбаатар	Чин ван Ханддоржийн байшин
34.		34	Улаанбаатар	Сүхбаатар	Чойжин ламын сүмийн цогцолбор
35.		35	Улаанбаатар	Хан уул	Богд хааны ногоон ордны цогцолбор
36.		36	Улаанбаатар	Чингэлтэй	Анхны “Өндөр хоршоо”-ны 2 давхар байшин
37.		37	Улаанбаатар	Чингэлтэй	Гэсэр сүмийн цогцолбор
38.	Аймаг, нийслэлийн хамгаалалтад	1	Архангай	Өлзийт	Бишрэлт гүний хүрээний дуганууд
39.		2	Баянхонгор	Өлзийт	Түйн голын (Бор) балгас
40.		3	Баянхонгор	Заг	Алмаст хавцалын суварга
41.		4	Баянхонгор	Заг	Баянцагаан нурууны цонж
42.					
43.		5	Булган	Булган	Баруун замын байлдааны ангийн штабын байшин
44.		6	Булган	Булган	Диваажингийн сүм
45.		7	Булган	Булган	Майдарын голын Цагаан суварга
46.		8	Булган	Булган	Худалдааны пүүсийн байшин
47.		9	Рашаант	Булган	Хөгнө хан уулын Их, бага хийдийн туурь
48.		10	Говь-Алтай	Тайшир	Наробанчин хийдийн туурь
49.		11	Дундговь	Дэлгэрхангай	Хошуу хийдийн туурь
50.		12	Өвөрхангай	Нарийнтээл	Ламын гэгээний суварга
51.		13	Өвөрхангай	Нарийнтээл	Цэвэлваанчигдоржийн суварга
52.		14	Өвөрхангай	Хархорин	Дагвадаржаа ламтны суварга
53.		15	Өмнөговь	Номгон	Сангийн далай хийд
54.		16	Сэлэнгэ	Алтанбулаг	Ардын хувьсгалын түүхэнд холбогдох барилга, байшин
55.		17	Төв	Дэлгэрхаан	Мишиг гүний хүрээний туурь
56.		18	Увс	Улаангом	Харлаг бэйсийн сүм
57.		19	Ховд	Жаргалант	Сангийн хэрэм
58.		20	Ховд	Үенч	Харуул овоо
59.		21	Хөвсгөл	Галт	Хужиртийн хүрээний чулуун суварга
60.		22	Хөвсгөл	Жаргалант	Гэлэнхүүгийн суварга
61.		23	Хөвсгөл	Жаргалант	Жаргалантын дуган
62.		24	Улаанбаатар	Баянзүрх	Анхны холбооны байшин
62		25	Улаанбаатар	Баянзүрх	“Гоожингийн өндөр” хэмээх байшин
63		26	Улаанбаатар	Баянзүрх	Консулын дэнжийн нууц нууц бүлгэм байрлаж байсан байшин
64		27	Улаанбаатар	Сүхбаатар	Дондогдулам хатны дурсгалын суварга

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

65		28	Улаанбаатар	Сүхбаатар	Ерөнхий сайд П.Гэндэгийн амьдарч байсан байшин
66		29	Улаанбаатар	Сүхбаатар	Мал тариалангийн яам байрлаж байсан байшин
67		30	Улаанбаатар	Хан-Уул	Богд хааны Хүрэн ордны зарим байшин /Богдын зуны ордон, Богдын торгон цэргийн байр, Дондогдулам хатны сэрүүн лаврин/
68		31	Улаанбаатар	Чингэлтэй	Ерөнхий сайд Д.Жигжиджавын амьдарч байсан байшин
69	Шинээр хамгаалалтад авах барилга	1	Улаанбаатар	Сүхбаатар	Хүүхдийн урлан бүтээх төв (Пионерийн ордон)

Хүчитгэх шаардлагатай түүх, соёлын дурсгалт 69 барилга, байгууламжийг хамгаалалтын зэрэглэлээр нь ангилан үзвэл, улсын хамгаалалтын зэрэглэлд 37, аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд 31 тус тус байгаа бөгөөд шинээр хамгаалалтад авах 1 барилга хамрагджээ (Зураг 10)



Зураг 10. Хамгаалалтын зэрэглэлээр ангилсан байдал

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*



Зураг 11. Хүчитгэх шаардлагатай дурсгалыг төрлөөр нь ангилсан байдал



Зураг 12. Хадгалалтын байдлаар нь ангилсан байдал



Зураг 13. Барилгын бүтээцээр нь ангилсан байдал

Дээрх график зургаас харахад, хүчитгэх шаардлагатай 69 барилга, архитектурын дурсгалыг төрөл зүйлээр нь ангилбал, эртний хотын туурь 8, суварга овоо шивээ 11, сүм хийдийн үлдэгдэл 13, бүрэн бүтэн сүм хийд барилга 23, түүхэн барилга 14 байна (Зураг 11). Түүнчлэн хүчитгэх шаардлагатай 69 барилга, архитектурын дурсгалын хадгалалтын байдлаас үзвэл, туурь 5, хэсэг хана нь үлдсэн 14, бүрэн бүтэн (100% бүтэн ашиглагдаж байгаа дурсгалт барилга) 19, тодорхойгүй 22, бүтэн (80-90% нь бүтэн үлдсэн) 9 дурсгал байгаа бөгөөд хийц бүтээцээр нь авч үзвэл, чулуу 1, түүхий тоосго 2, тодорхойгүй 5, чулуу, тоосго холимог 24, мод, тоосго холимог 37 дурсгал байна (Зураг 12,13).

Дүгнэлт

Монгол Улсын нутаг дэвсгэр орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг зэрэглэл тогтоож хамгаалалтад авсан жагсаалтыг 1941, 1971, 1994, 1998, 2008, 2020 онд баталсан байна. Үүнээс 2015-2016 онд зохион байгуулсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого”-ыг үндэслэн Засгийн газрын 2020 оны 13-р тогтоол болон БСШУС-ын сайдын 2020 оны А/161 тоот тушаалаар баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг төслийн хүрээнд судлан үзэж, шинээр нэмж хамгаалалтад авах шаардлагатай түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг жагсаалтыг боловсруулсан болно.

Дээрх улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад хамрагдсан барилга, архитектурын дурсгалыг тоо, эзлэх хувь, төрлөөр судалсан юм. *Барилга, архитектурын дурсгалд*: суурьшлын ул мөр бүхий газар; эртний хот (Хүннү, Түрэг, Уйгар, Кидан, Монгол, Манж, тодорхойгүй); хэрмэн зам; шуудуу; сүм хийдийн туурь; суварга; түүхэн дурсгалт байшин; агуй оромж, түр сууц; архитектурын дурсгал гэж 9 төрлийг хамруулаад “*Архитектурын дурсгал*” гэдэгт: уран барилга; уран барилгын цогцолбор; сүм хийд; уран баримал, хөшөө (1921-1990); Сүрлэг чимэглэлийн дүрслэл зэргийг багтаасан байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогоор 86157 үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэсний 2820 нь барилга, архитектурын дурсгал байсан бөгөөд нийт дурсгалын гурван хувийг эзэлж байна. Улсын хамгаалалтад байгаа 185 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг судалж үзэхэд 54 дурсгал нь, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 607 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 111 дурсгал нь Барилга, архитектурын дурсгал байна. Судалгааны хүрээнд сум, дүүргээс нийт 3739 дурсгалын мэдээ, бүртгэл ирснээс, сум болон дүүргийн хамгаалалтад давхардсан байдлаар барилга, архитектурын 189 дурсгал хамрагдсан байна. Нийт дүнгээр улсын хэмжээнд 354 барилга, архитектурын дурсгал улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад байх жагсаалтад

орсон байна. Дээрх улс, аймаг, нийслэл, сум дүүргийн хамгаалалтад хамрагдсан барилга, архитектурын 354 дурсгал, шинээр нэмж хамгаалалтад авах түүх, соёлын дурсгалт барилга 43 дурсгал нийт 397 барилга, архитектурын дурсгалын Урьдчилсан жагсаалт боловсруулсан ба түүнээс хүчитгэх шаардлага үүссэн 69 дурсгалыг сонгон жагсаалтыг гаргалаа.

Төслийн хүрээнд нийслэлийн болон зарим аймгийн нутаг дэвсгэр дээр оршиж буй түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн судалгааг хийж “Шинээр хамгаалалтад авах 43 түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн жагсаалт”-ыг “Дурсгалт барилгын нэр; гэрэл зураг; ашиглалтад орсон он; зохиогч архитектор; архитектур, бүтээц; тайлбар” гэсэн асуулгаар хүснэгтлэн эцэслэн боловсруулсан юм.

Цаашид Дурсгалт барилгыг Архитектурын дурсгал, Түүхэн барилга гэж хоёр ангилж хууль эрх зүйн баримт бичигт тусгаж архитектурын дурсгалд юу юуг хамруулахыг шинжлэх ухааны үндэслэлтэй томьёолох хэрэгтэй байна. Тухайлбал, дээрх жагсаалтаас харахад “барилга, архитектурын дурсгал”-д хэрмэн зам, шуудуу зэргийг оруулсныг хянаж үзэх хэрэгтэй. Түүхэн барилга гэдэгт Монгол улсын түүх, түүхэн хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой байшин барилга, гудамж талбай зэрэг дурсгалт барилгууд орно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ҮНЭЛЭХ

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох “архитектурын болон археологийн дурсгал, байгаль, түүх, соёлын дурсгалт газар”-ыг тухайн нутаг, эх газарт нь хүрээлэн байгаа орчных нь хамт хадгалан хамгаалж байж түүний түүхэн ач холбогдол, үнэ цэнэ оршдог. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж хамгаалах ажлын эхний шат бол *бүртгэн баримтжуулах* явдал юм.

1996 онд хуралдсан Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах Олон улсын Зөвлөл (ICOMOS)-өөс баталсан "Хөшөө дурсгал, бүлэг барилга, дурсгалт газрыг бүртгэх ИКОМОС-ийн зарчим" -ыг баталж олон улсын хэмжээнд мөрдөж байгаа билээ. Энэхүү зарчимд "Бүртгэл гэдэг нь хөшөө дурсгал, барилга болон дурсгалт газруудын биет хэлбэр дүрс, нөхцөл байдал, ашиглалтын талаарх мэдээллийг цуглуулахыг хэлэх бөгөөд бүртгэлийн ажил нь хадгалалт хамгаалалтын нэгэн чухал хэсэг юм." гэж тодорхойлсон байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх талаар 1986 онд ЮНЕСКО-гоос хэвлэн гаргасан дурсгалт зүйлийн бүртгэлийн тухай лавлах бичигт өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн дурсгалт барилга байгууламжийн жагсаалтыг боловсруулахдаа уг дурсгалын агуулгыг илэрхийлж чадахуйц орон зайд авч үзэх нь чухал гэдгийг онцолжээ. Дурсгалт барилга байгууламжийг тодорхойлон бүртгэх нь улс бүхэнд харилцан адилгүй байдаг байна. Тухайлбал, Францад сүүлийн үеийн зарим барилга болон 1845 оноос хойших, Мексикт 1522-1900 оны бүх барилга, Польшид 1939 оноос өмнөх, Англид 1700 оноос өмнөх бүх барилга, 1700-1870 оны дурсгалт барилга, 1870-1914 оны нэрт архитекторуудын уран бүтээлийг тус тус хамгаалалтад авсан байх жишээтэй. Үүнээс үзэхэд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хамгаалалтад авах үндсэн шалгуур нь улиран өнгөрсөн цаг хугацаа юм.

Барилга байгууламжийг түүх, соёлын дурсгал гэж тодорхойлохдоо түүхийн болон соёлын үзүүлэлтийг гол үндэслэл болгодог байв. *Түүхийн* томъёоллыг цаг хугацааны, түүх дурсгалын, шинжлэх ухааны гэсэн гурван үндсэн үзүүлэлтээр авч үздэг бол *Соёлын* гэсэн томъёололд дахин давтагдашгүй, урлаг уран сайхны үзүүлэлт багтана. Энэ томъёоллын хоёуланд нь уг дурсгал хамрагдаж байвал дээд зэрэглэлд багтана гэсэн шалгуураар түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийг бүртгэж хамгаалалтад авсаар ирлээ.

Аливаа барилга байгууламжийг “архитектурын дурсгал, түүхэн дурсгалт барилга” хэмээн тодорхойлохдоо Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу *“түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол*

бүхий өвийг” тогтоох ёстой учраас түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсын жишгийн дагуу улам боловсронгуй болгох, тэдгээрийг тодорхойлох шалгуур, үзүүлэлтийг нарийн тодорхой болгож, гарах үр дүнг үнэн зөв, бодит болгох шаардлага гарч байна.

Өнөөдрийг хүртэл түүх, соёлын дурсгалт барилгыг тодорхойлох батлагдсан шалгуур, үзүүлэлт, үнэлэх журам байхгүй учраас эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн түүх, соёлын дурсгалт барилгыг тодорхойлон хамгаалалтад авч, жагсаалтыг баталгаажуулсаар ирсэн.

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн МУ-ын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ын хамтарсан “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл”-ийн баг ЮНЕСКО-гийн “Соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци”, түүний Дэлхий өвийг тодорхойлох удирдамж, шалгуур, бусад улс орны архитектурын өвөө тодорхойлох шалгуур үзүүлэлт, “Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т тусгагдсан түүхэн дурсгалт газар, барилга байгууламжийг тодорхойлох шалгуур үзүүлэлт зэргийг судалж “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар”-ын төслийг боловсруулсан болно (Хавсралт 1).

“Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар” нь Нийтлэг үндэслэл; Нэр томъёоны тайлбар; Тодорхойлох шалгуур; Шалгуур, үзүүлэлт ба оноо; Шалгуур, үзүүлэлтийг үнэлэх, баталгаажуулах гэсэн таван зүйл, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний хуудас” буюу А Хавсралт; “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувийн хэрэг” буюу В Хавсралт; “Түүх, соёлын дурсгал байрилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний жишээ” буюу С Хавсралтаас бүрдэнэ.

Зааварт тухайн барилга байгууламжийг түүх, соёлын дурсгалд хамааруулах эсэхийг тодорхойлохдоо үндсэн 7 шалгуурыг сонгож, ач холбогдлоор нь дараалуулсан ба шалгуурын нийт 24 үзүүлэлт бүрт оноо өгч үнэлэх бөгөөд онооны нийлбэр 10 - 100 хүртэл нь байхаар боловсруулж Хүснэгт 1-т үзүүлэв. Шалгуур, үзүүлэлтийг тодруулж ойлгомжтой болгох зорилгоор шалгуур бүрт тайлбар хийлээ. Шалгуур, үзүүлэлтийг үнэлсэн үнэлгээний нийлбэр оноо нь тухайн түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хамгаалалтын зэрэглэлийг тодорхойлох юм. Тухайлбал, 70-100 оноо нь улсын, 40-69 оноо нь аймаг, нийслэлийн, 10-39 оноо нь сүм дүүргийн хамгаалалтад тус тус хамрагдана. Нийт оноо 10-аас бага үнэлгээтэй барилгыг түүх, соёлын дурсгалт барилга байгууламжид хамааруулахгүй болно.

Энэхүү шалгуур, үзүүлэлтийг оноогоор буюу тоон үзүүлэлтээр үнэлэх зааварыг төслийн багийн гишүүн А.Ариунболд, З.Оюунбилэг, С.Пүрэвдорж, Б.Ганбаяр, Г.Энхбат нар дурсгалт барилга болох Чойжин ламын сүм музей, Улаанбаатар хотын музей, “Гоожингийн өндөр”, Дуурь бүжгийн эрдмийн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга дээр очиж үзэн үнэлж туршсан бөгөөд гишүүдийн онооны нийлбэрийг нэгтгэн дундаж оноог гаргасан юм. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлж үнэлсэн жишээг хавсаргав (Хүснэгт 1).

Манай улс Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд тусгай маягтын дагуу бүртгэдэг боловч түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувьд архитектурын хэв маяг, архитектор, барилгын материал, сэргээн засварласан түүх, хэмжилтийн болон ажлын зураг, гэрэл зураг зэрэг мэдээллээс бүрдсэн Хувийн хэрэг хөтөлдөг олон улсын туршлагыг судалсны үндсэн дээр энэхүү Зааварт байх нь зүйтэй гэж үзэж “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийг боловсруулж хавсаргасан болно.

Түүнчлэн дурсгалт барилгыг тодорхойлох ажлын үе шат, түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн Урьдчилсан жагсаалт гаргах, тэрхүү жагсаалтад орсон барилгыг дээрх Зааврын дагуу үнэлж дурсгалт барилгыг тодорхойлох үнэлгээний баг, түүний бүрэлдэхүүн зэрэг асуудлыг зохицуулах тусгай журам байх хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл дээрх зааврыг хэрэгжүүлэхийн тулд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааг соёлын болон хот байгуулалт, барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан журмаар зохицуулах шаардлагатай учраас “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулсан юм.

“Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам” нь Нийтлэг үндэслэл; Үйл ажиллагаа; Үнэлгээний багийн бүрэлдэхүүн ба үүрэг; Үйл ажиллагааг тайлагнах гэсэн дөрвөн зүйлээс бүрдэнэ. Энэхүү журмын салшгүй нэг хэсэг бол “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар” болно.

Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох, хамгаалалтын түвшингээр зэрэглэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд энэхүү журмыг мөрдөх ёстой.

Дүгнэлт

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлохын тулд олон улсын жишгээр тусгай батлагдсан журам, зааврын дагуу шалгуур үзүүлэлт байх ёстой учраас төслийн хүрээнд 7 шалгуур, 24 үзүүлэлт бүхий “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар”, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам”-ын төслийн тус тус боловсруулан хавсаргасан бөгөөд цаашид үнэлгээний баг зохион байгуулж түүх, соёлын дурсгалт барилгыг тодорхойлоход мөрдөх эрх зүйн баримт бичиг болж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд бодиттой үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Өнөөдөр зэрэглэлийн түвшнээр улсын хамгаалалтад байгаа архитектурын дурсгал болох Чойжин ламын сүм музей, түүхэн барилга болох Ардын Намын төв хороо, Ардын засгийн газрын түр байрлаж байсан байшин буюу Улаанбаатар хотын музей, нийслэлийн хамгаалалтад байгаа түүхэн барилга болох “Гоожингийн өндөр” хэмээх байшин, хамгаалалтын жагсаалтад ороогүй архитектурын дурсгал болох Дуурь бүжгийн эрдмийн театрын барилга болон Хүүхдийн урлан бүтээх төвийн барилгыг төслийн гишүүд газар дээр нь үзэж дээрх зааврын дагуу шалгуур, үзүүлэлтээр нь үнэлж зэрэглэлийг тогтоож туршиж үзсэн билээ. Туршилтын үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэхдээ таван гишүүний үнэлгээний дундаж оноо, зэрэглэл болон хамгаалалтын саналын тусгасан ба одоогийн хамгаалалтын түвшинтэй дүйцэж байна.

Хүснэгт 1.

Түүх, соёлын дурсгалт барилгыг тодорхойлох туршилтын үнэлгээ дүн

Дд	Үнэлгээ хийсэн дурсгалт барилгын нэр	Үнэлсэн дундаж оноо	Зэрэглэл	Хамгаалалтын түвшин
1.	Чойжин ламын сүм музей	99	I	Улсын хамгаалалтад авна.
2.	Улаанбаатар хотын музей	60,5	II	Нийслэлийн хамгаалалтад авна.
3.	Гоожингийн өндөр	37	III	Дүүргийн хамгаалалтад авна.
4.	Дуурь бүжгийн эрдмийн театр	98	I	Улсын хамгаалалтад авна
5.	Хүүхдийн урлан бүтээх төв	50	II	Нийслэлийн хамгаалалтад авна.

Төсөл

**ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
ТОДОРХОЙЛОХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Дурсгалт барилга гэдэг нь бидэнд гайхшруулах мэдрэмжийг төрүүлж, түүнийг бүтээсэн хүмүүс болон соёлын талаар илүү ихийг мэдэх боломжийг олгодог бөгөөд тэр нь архитектур, гоо зүй, түүх, археологи, нийгэм, эдийн засаг, улс төр, баримтат болон бэлгэдлийн үнэ цэнийг өөртөө агуулсан байдаг. Дурсгалт барилгыг Архитектурын дурсгал, Түүхэн дурсгалт барилга гэж үндсэнд нь ангилна.

Түүхэн тодорхой цаг хугацааг төлөөлж буй 1586 оны хойш баригдсан, баригдаад 50-аас дээш жил болсон, Урьдчилсан жагсаалтад хамрагдсан дурсгалт барилга байгууламжийг шалгуур үзүүлэлтийн дагуу тоон утгаар үнэлж, түүх, соёлын дурсгалт барилга байгууламж хэмээн тодорхойлоход "Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар (цаашид "Заавар" гэнэ)- ыг хэрэглэнэ.

Түүнчлэн өмчийн хэлбэр болон ямар зориулалтаар ашиглагдаж байгааг үл хамааран түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг энэхүү Зааврын дагуу үнэлж тодорхойлно.

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, олон улсын конвенци, дүрэм, зарчимд нийцүүлэн боловсруулсан болно.

Хоёр. Тодорхойлох шалгуур

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламж хэмээн тодорхойлоход дараах шалгуурыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Түүхийн үнэ цэнэ;
2. Соёлын үнэ цэнэ;
3. Архитектурын үнэ цэнэ;
4. Эх байдлын үнэ цэнэ;
5. Бүрэн бүтэн байдлын үнэ цэнэ;
6. Барилгын техник, технологийн үнэ цэнэ;
7. Нийгэм, эдийн засгийн үнэ цэнэ.

Гурав. Шалгуур, үзүүлэлт ба оноо

Аливаа барилга байгууламжийг түүх, соёлын дурсгалд хамаарах эсэхийг тогтоохдоо шалгуур, үзүүлэлт бүрт оноо өгч үнэлнэ. Тухайн үнэлж буй барилга

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

байгууламжийн үзүүлэлт тус бүрт өгөгдөх онооны нийлбэр нь 10 - 100 хүртэл байна.

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хоёр дахь зүйлд заасан шалгуураар тодорхойлохдоо дараах үзүүлэлтийг харгалзан үзнэ. Үзүүлэлтийг түүхэн эх сурвалж, баримт, мэдээлэл, судалгаанд үндэслэнэ (1-р хүснэгт).

**1-р хүснэгт. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг
тодорхойлох шалгуур, үзүүлэлт**

Шалгуур	Үзүүлэлт	Оноо	Тайлбар
Шалгуур 1. Түүхийн үнэ цэнэ.	1.1. Түүхийн тодорхой үе, цаг хугацаа, орон зайг төлөөлж чадах.	0 - 8	- 1586 оноос хойш баригдсан, баригдаад 50-аас дээш жил болсон; - Баригдсан болон бүтээн байгуулсан хугацаа, он цаг тодорхой байх; - Түүхэн ач холбогдолтой байх; - Ховор, цөөн тоотой байх; - Судлагдсан байдал зэргийг харгалзан үзэх.
	1.2. Монгол Улсын түүх, нийгэм, улс төр, түүхэн үйл явдалтай холбогдох байдал.	0 - 8	
	1.3. Түүхэн хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбогдох байдал.	0 - 8	
Шалгуур 2. Соёлын үнэ цэнэ.	2.1. Дахин давтагдашгүй байдал.	0 - 6	- Дэлхийн архитектурын урсгалын төлөөлөл болох; - Монголын үндэсний хэв маяг, өв уламжлал болон уран бүтээлчийн дахин давтагдашгүй байдал; - Ижил төстэй бүтээл нь устаж үгүй болж цорын ганц үлдсэн ховор байдал; - Тухайн үеийн соёл, гоо сайхны үнэлэмжийг илэрхийлсэн байдал зэргийг харгалзан үзэх.
	2.2. Урлаг, уран сайхан, гоо зүйн үнэ цэнэ, ховор байдал.	0 - 6	
	2.3. Хүн ба байгалийн өвөрмөц хосолмол шинжийг агуулсан байх.	0 - 6	
	2.4. Дүрслэх урлагийн бусад төрөл зүйлтэй хослон нийлмэл урлаг болох.	0 - 6	
Шалгуур 3. Архитектурын үнэ цэнэ.	3.1. Анхны дүр төрх, хэв маяг, зохиомж, төлөвлөлт, зориулалтаа хадгалж байгаа эсэх.	0 - 6	- Анхны зориулалт нь хэвээр, хэв маяг нь өөрчлөгдөөгүй байх; - Эртний улс, гүрний үеийн барилгын ур хийц, онцлогийг илэрхийлсэн байх; - Монголын орчин үеийн ууган архитекторуудын бүтээл эсэх; - Судлагдсан байдал зэргийг харгалзан үзэх.
	3.2. Дэлхийн архитектурын аль нэг сонгодог урсгал болон үндэсний хэв маяг, уламжлалыг төлөөлж буй байдал.	0 - 5	
	3.3. Барилга болон архитектурын хөгжилд шинэчлэл хийсэн, ур хийц, хэлбэр загвар нь өвөрмөц онцгой байдал.	0 - 4	

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Шалгуур 4. Эх байдлын үнэ цэнэ.	4.1. Анхны дүр төрх, хэв маяг, хэлбэр ба загварыг хадгалсан байх.	0 - 4	- Барилгын ашиглалт, зориулалтыг өөрчилж, түүнээс хамаарч төлөвлөлт, дотоод чимэглэл (интерьер) нь өөрчлөгдсөн ч архитектурын хэв маяг, анхны дүр төрх хэвээрээ бол; - Эртний буюу анхны шинж байдлыг илэрхийлэх зэргийг харгалзан үзэх.
	4.2. Гаднах дүр төрхөөс гадна түүний бүтэц, элемент, бүрэлдэхүүн хэсгийн эх төрхийг хадгалсан байдал.	0 - 4	
	4.3. Эртний шинж байдлыг илэрхийлэх хийцийн үлдцийн байдал.	0 - 3	
	4.4. Хүрээлэн буй орчны эх болон эртний байдал.	0 - 3	
Шалгуур 5. Бүрэн бүтэн байдлын үнэ цэнэ	5.1. Архитектурын хийц, зохиомжийн бүрэн байдал.	0 - 3	- Хийц бүтээц, төлөвлөлт, архитектурын чимэглэл зэргийг өөрчлөөгүй бүрэн байх; - Авран хамгаалах зорилгоор зөөж шилжүүлээгүй зэргийг харгалзан үзэх.
	5.2. барилга байгууламжийн нэгдлүүдийн бүрэн байдал.	0 - 3	
	5.3. Нэгдмэл байдал буюу дурсгалт барилга нь бусад түүх, соёлын дурсгалтай нийлж нэгдмэл байдлыг үүсгэж байгаа эсэх.	0 - 3	
Шалгуур 6. Барилгын техник, технологи, материалын үнэ цэнэ	6.1. Эрдэнийн чулуу, үнэт металл, үнэ цэнтэй ховор түүхий эд болон барилгын материал ашигласан байдал.	0 - 2	- Үндэсний уламжлалт арга барил, технологи болон ардын мэдлэг ухааны илэрхийлэл болох; - Орон нутгийн гаралтай ховор түүхий эд ашигласан байх; - Хот төлөвлөлтийн уламжлалт зарчим, орон нутгийн төлөвлөлтийн онцлогийг хадгалсан байх зэргийг харгалзан үзэх.
	6.2. Барилгын болон хот байгуулалтын хөгжлийн түүх, тухайн цаг үеийнхээ барилга барих арга ухаан, соёлын тусгасан байдал.	0 - 2	
	6.3. Барилгын техник, хийц бүтээц, уламжлалт технологийг хадгалсан байдал.	0 - 2	
	6.4. Байгалийн өвөрмөц тогтоцод тулгуурлан барьсан барилга байгууламж.	0 - 2	
Шалгуур 7. Нийгэм, эдийн засгийн үнэ цэнэ	7.1. Хот, суурины орон зайн төлөвлөлт, зохион байгуулалт, хүрээлэн буй орчин, эргэн тойрны ландшафт, харагдах байдал нь хадгалагдан үлдсэн байх.	0 - 2	- Төрөл зүйлийн хувьд ховор, цөөн тоотой тохиолддог байдал; - “Соёлын өвийн дурсгалт газар”-тай холбож болох; - Цогц байдал ба хамгаалалтын бүсийг тогтоосон байх; - Соёлын уламжлалт зан үйл, арга хэмжээ зохион байгуулдаг байх зэргийг харгалзан үзэх.
	7.2. Аялал жуулчлалын бүс, чиглэлд хамрагдсан байдал.	0 - 2	
	7.3. Улс, бүс нутгийн хөгжилд нөлөөлөх эдийн засгийн ач холбогдол.	0 - 2	

Дөрөв. Шалгуур, үзүүлэлтийг үнэлэх, баталгаажуулах

Шалгуур, үзүүлэлтийг үнэлсэн үнэлгээний нийлбэр оноо нь тухайн түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хамгаалалтын зэрэглэлийг тодорхойлно. Хамгаалалтын зэрэглэл нь тухайн түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад авах үндэслэл болно (2-р хүснэгт).

**2-р хүснэгт. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн
хамгаалалтын зэрэглэл**

Зэрэглэл	Шалгуур, үзүүлэлтийн үнэлгээний нийт оноо	Хамгаалалтын түвшин
I	70-100	Улсын хамгаалалтад
II	40-69	Аймаг, нийслэлийн хамгаалалтад
III	10-39	Сум, дүүргийн хамгаалалтад

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох багийн гишүүн тус бүрийн үнэлсэн онооны дунджаар үнэлгээний нийт оноог гаргаж, хамгаалалтын түвшний зэрэглэлийг тогтооно (А Хавсралт). Нийт оноо 10-аас бага үнэлгээтэй барилгыг түүх, соёлын дурсгалт барилга байгууламжид хамааруулахгүй болно.

Хамгаалалтын зэрэглэл тогтоосон Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжид хувийн хэрэг хөтлөнө (В Хавсралт).

Энэхүү заавраар түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох ажлыг соёлын болон хот байгуулалт, барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан журмын дагуу зохион байгуулна.

--- о О о ---

ХАВСРАЛТ (зөвлөмжийн)

А.1-р хүснэгт. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний хуудас (Загвар)

Шалгуур	Үзүүлэлт	Дүгнэх оноо	Дүгнэсэн оноо	Тэмдэглэл
Шалгуур 1. Түүхийн үнэ цэнэ.	1.2. Түүхийн тодорхой үе, цаг хугацаа, орон зайг төлөөлж чадах.	0-8		
	1.2. Монгол Улсын түүх, нийгэм, улс төр, түүхэн үйл явдалтай холбогдох байдал.	0-8		
	1.3. Түүхэн хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбогдох байдал.	0-8		
Шалгуур 2. Соёлын үнэ цэнэ.	2.1. Дахин давтагдашгүй байдал.	0-6		
	2.2. Урлаг, уран сайхан, гоо зүйн үнэ цэнэ, ховор байдал.	0-6		
	2.3. Хүн ба байгалийн өвөрмөц хосолмол шинжийг агуулсан байх.	0-6		
	2.4. Дүрслэх урлагийн бусад төрөл зүйлтэй хослон нийлмэл урлаг болох.	0-6		
Шалгуур 3. Архитектурын үнэ цэнэ.	3.1. Анхны дүр төрх, хэв маяг, зохиомж, төлөвлөлт, зориулалтаа хадгалж байгаа эсэх.	0-6		
	3.2. Дэлхийн архитектурын аль нэг сонгодог урсгал болон үндэсний хэв маяг, уламжлалыг төлөөлж буй байдал.	0-5		
	3.3. Барилга болон архитектурын хөгжилд шинэчлэл хийсэн, ур хийц, хэлбэр загвар нь өвөрмөц онцгой байдал.	0-4		
Шалгуур 4. Эх байдлын үнэ цэнэ.	4.1. Анхны дүр төрх, хэв маяг, хэлбэр ба загварыг хадгалсан байх.	0-4		
	4.2. Гаднах дүр төрхөөс гадна түүний бүтэц, элемент, бүрэлдэхүүн хэсгийн эх төрхийг хадгалсан байдал.	0-4		
	4.3. Эртний шинж байдлыг илэрхийлэх хийцийн үлдцийн байдал.	0-3		
	4.4. Хүрээлэн буй орчны эх болон эртний байдал.	0-3		
Шалгуур 5. Бүрэн бүтэн байдлын үнэ цэнэ	5.1. Архитектурын хийц, зохиомжийн бүрэн байдал.	0-3		
	5.2. барилга байгууламжийн нэгдлүүдийн бүрэн байдал.	0-3		

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

	5.3. Нэгдмэл байдал буюу дурсгалт барилга нь бусад түүх, соёлын дурсгалтай нийлж нэгдмэл байдлыг үүсгэж байгаа эсэх.	0-3		
Шалгуур 6. Барилгын техник, технологи, материалын үнэ цэнэ	6.1. Эрдэнийн чулуу, үнэт металл, үнэ цэнтэй ховор түүхий эд болон барилгын материал ашигласан байдал.	0-2		
	6.2. Барилгын болон хот байгуулалтын хөгжлийн түүх, тухайн цаг үеийнхээ барилга барих арга ухаан, соёлын тусгасан байдал.	0-2		
	6.3. Барилгын техник, хийц бүтээц, уламжлалт технологийг хадгалсан байдал.	0-2		
	6.4. Байгалийн өвөрмөц тогтцод тулгуурлан барьсан барилга байгууламж.	0-2		
Шалгуур 7. Нийгэм, эдийн засгийн үнэ цэнэ.	7.1. Хот, суурины орон зайн төлөвлөлт, зохион байгуулалт, хүрээлэн буй орчин, эргэн тойрны ландшафт, харагдах байдал нь хадгалагдан үлдсэн байх.	0-2		
	7.2. Аялал жуулчлалын бүс, чиглэлд хамрагдсан байдал.	0-2		
	7.3. Улс, бүс нутгийн хөгжилд нөлөөлөх эдийн засгийн ач холбогдол.	0-2		
Тухайн барилга байгууламжийн авсан нийт оноо			...	

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

В ХАВСРАЛТ (мэдээллийн)

**В.1-р хүснэгт. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн
хувийн хэрэг**

1. Улс (Харьяалагдах улс, хот, сум, дүүргийн нэр)	2. Аймаг	3. Сум, дүүрэг
4. Дурсгалт барилгын түүхэн нэр (Дурсгалт барилгын анхны нэр, хамгаалалтад авсан нэр)		5. Бүртгэлийн дугаар (БМСангийн болон үл хөдлөх)
6. Бусад нэр, нэршил (Дурсгалт барилгын түүхэн нэр, тогтсон нэр)		
7. Хаяг (Бүтэн хаяг)		
8. Баригдсан он (Эх сурвалжийг бичнэ)	9. Архитектор (Эх сурвалжийг бичнэ)	
10.Ач холбогдол (Архитектурын болон түүхэн, анх ашиглаж байсан)		
11.Хэв маяг		
12.Барилгын материал (Бүтээцийг бичнэ: суурь, араг яс, хана, дээвэр)		
13.Хэлбэр, хэмжээ		
14.Гадна талын онцлог шинж чанар		
15.Дотор талын онцлог шинж чанар (Зураг нь байхгүй бол давхар бүрийн байгуулалтыг зурна)		
16.Томоохон өөрчлөлт болон нэмэлт хийсэн байдал (гадна ба дотор тал, хэзээ, ямар зориулалтаар өөрчилсөн)		
17.Одоогийн нөхцөл байдал, ашиглалт (Ямар зориулалтаар ашиглаж байгаа, хадгалалт хамгаалалт г.м)		
18.Сэргээн засварласан тухай мэдээлэл /эх сурвалж (Хэзээ, хэн, ямар байгууллага, ямар өртгөөр, юу юуг сэргээн засварласан тухай бичнэ.)		
19.Холбогдох баримт бичиг, материал/эх сурвалж (Хэмжилтийн зураг, ажлын зураг, гэрэл зураг, товч түүх байгаа эсэх, хаана хадгалагдаж байгааг бичих)		
20.Шаардлагатай бусад мэдээлэл (Онцгой мэдээллийг бичих, хамгаалалтын зэрэглэл г.м)		
21.Мэдээллийн эх сурвалж (Мэдээллийг хаанаас цуглуулсан)		
22.Бүртгэсэн (Овог нэр)	23. Огноо	
24.Гэрэл зурагчны нэр, он , гэрэл зургийн дугаар, юуг аль зүгээс авсан/зургийн тайлбар (Гэрэл зургийг авахдаа болон хавсаргахдаа дараах мэдээллийг заавал бичнэ.)		

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

С ХАВСРАЛТ (барилга үнэлсэн жишээ)

**С.1-р хүснэгт. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг
үнэлсэн жишээ**

Шалгуур	Үзүүлэлт	Дүгнэх оноо	Дүгнэсэн оноо				
			Чойжин ламын сүм музей	УБ хотын музей	Гоожингийн өндөр	Дуурь бүжгийн эрдмийн театр	Хүүхдийн урлан бүтээх төв
Шалгуур 1. Түүхийн үнэ цэнэ.	1.1.Түүхийн тодорхой үе, цаг хугацаа, орон зайг төлөөлж чадах.	0-8	8	8	8	8	3
	1.2. Монгол улсын түүх; нийгэм, улс төрийн түүх болон түүхэн үйл явдалтай холбогдох байдал	0-8	8	8	8	8	3
	1.3. Түүхэн хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбогдох байдал.	0-8	8	8	5	8	1
Шалгуур 2. Соёлын үнэ цэнэ.	2.1. Дахин давтагдашгүй байдал;	0-6	6	2	2	6	4
	2.2. Урлаг, уран сайхан, гоо зүйн үнэ цэнэ, ховор байдал;	0-6	6	1	1	6	6
	2.3. Хүн ба байгалийн өвөрмөц хосолмол шинжийг агуулсан байх;	0-6	6	0	0	6	0
	2.4. Дүрслэх урлагийн бусад төрөл зүйлтэй хослон синтез урлаг болох.	0-6	6	1	1	6	6
Шалгуур 3. Архитектурын үнэ цэнэ.	3.1. Анхны дүр төрх, хэв маяг, зохиомж, төлөвлөлт, зориулалтаа хадгалж байгаа эсэх;	0-6	6	6	2	6	6
	3.2. Дэлхийн архитектурын аль нэг сонгодог урсгал болон үндэсний хэв маяг, уламжлалыг төлөөлж буй байдал;	0-5	5	0	0	5	2
	3.3. Барилга болон архитектурын хөгжилд шинэчлэл хийсэн, ур хийц, хэлбэр загвар нь өвөрмөц онцгой байдал.	0-4	4	0	0	4	4
Шалгуур 4. Эх байдлын үнэ цэнэ.	4.1. Анхны дүр төрх, хэв маяг, хэлбэр ба загварыг хадгалсан байх;	0-4	4	4	2	4	4
	4.2. Гаднах дүр төрхөөс гадна түүний бүтэц, элемент, бүрэлдэхүүн хэсгийн эх төрхийг хадгалсан байдал;	0-4	4	4	2	4	3
	4.3. Эртний шинж байдлыг илэрхийлэх хийцийн үлдцийн байдал;	0-3	3	1.5	1	3	1
	4.4. Хүрээлэн буй орчны эх болон эртний байдал.	0-3	3	2	0	3	0
Шалгуур 5. Бүрэн бүтэн байдлын үнэ цэнэ	5.1. Архитектурын хийц, зохиомжийн бүрэн байдал;	0-3	3	3	3	3	2
	5.2. Барилга, байгууламжийн нэгдлүүдийн бүрэн байдал;	0-3	3	3	1	3	2
	5.3. Нэгдмэл байдал буюу дурсгалт барилга нь бусад түүх, соёлын дурсгалтай нийлж нэгдмэл байдлыг үүсгэж байгаа эсэх.	0-3	3	3	0	3	0
Шалгуур 6. Барилгын техник, технологи, материалын үнэ цэнэ	6.1. Эрдэнийн чулуу, үнэт металл, үнэ цэнтэй ховор түүхий эд болон барилгын материал ашигласан байдал;	0-2	2	0	0	1	0
	6.2. Барилгын болон хот байгуулалтын хөгжлийн түүх, тухайн цаг үеийнхээ барилга барих арга ухаан, соёлын тусгасан байдал;	0-2	2	1	1	2	2
	6.3. Барилгын техник, хийц бүтэц, технологийн хөгжлийг төлөөлж чадах эсэх;	0-2	1	0	0	2	0
	6.4. Байгалийн өвөрмөц тогтоцод тулгуурлан барьсан барилга, байгууламж.	0-2	2	0	0	1	0
Шалгуур 7. Нийгэм, эдийн засгийн үнэ цэнэ.	7.1. Хот, суурины орон зайн төлөвлөлт, зохион байгуулалт, хүрээлэн буй орчин, эргэн тойрны ландшафт, харагдах байдал нь хадгалагдан үлдсэн байх;	0-2	2	2	0	2	1
	7.2. Аялал жуулчлалын бүс, чиглэлд хамрагдсан байдал;	0-2	2	2	0	2	0
	7.3. Улс, бүс нутгийн хөгжилд нөлөөлөх эдийн засгийн ач холбогдол.	0-2	2	1	0	2	0
Тухайн барилга байгууламжийн авсан нийт оноо			99	60.5	37	98	50

**С.2-р хүснэгт. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжид
зэрэглэл тогтоосон жишээ**

№	Үнэлгээ хийсэн барилга	Тогтоосон зэрэглэл	Хамгаалалтын түвшин
1	Чойжин ламын сүм музейн барилга	I	Улсын хамгаалалтад авна.
2	УБ хотын музейн барилга	II	Нийслэлийн хамгаалалтад авна.
3	"Гоожингийн өндөр" хэмээх барилга	III	Дүүргийн хамгаалалтад авна.
4	Дуурь бүжгийн эрдмийн театрын барилга	I	Улсын хамгаалалтад авна.
5	Хүүхдийн урлан бүтээх төв	II	Нийслэлийн хамгаалалтад авна.

Төсөл

**ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөлд хамаарах түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламж гэдэгт салангид болон нэгдмэл архитектурын дурсгал болон түүхэн дурсгалт барилга байгууламж нь хамрагдана.

1.3. Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох, хамгаалалтын түвшингээр зэрэглэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Үйл ажиллагаа

2.1. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох, батлах, бүртгэх үйл ажиллагаа нь дараах дараалалтай байна.

2.1.1. Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн нутаг дэсгэр дээр орших түүх, соёлын дурсгалт барилга байгууламжид хамаарах барилга байгууламжийн “Урьдчилсан жагсаалт”-ыг гаргах;

2.1.2. Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний баг”-ийг баталж, томилон ажиллуулах;

2.1.3. Үнэлгээний баг нь “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар” (цаашид “Заавар” гэнэ)-ын дагуу түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлон, хамгаалалтын зэрэглэлийг тогтоож харьяалах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хүргүүлэх;

2.1.4. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг улс, аймаг, нийслэл, сум дүүргийн хамгаалалтад байх Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад оруулж батлах;

2.1.5. Батлагдсан түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу шат шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ. Бүртгэлд Зааврын В Хавсралт буюу “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийг бөглөж хавсаргах.

Гурав. Үнэлгээний багийн бүрэлдэхүүн ба үүрэг

3.1. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний багийн бүрэлдэхүүнд дараах байгууллагын мэргэжилтэн, судлаач нар байж болно. Үүнд:

3.1.1. Шинжлэх Ухааны Академийн харьяа холбогдох эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаач;

3.1.2. Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн судлаач;

3.1.3. Барилгын болон соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

3.1.4. Улс, аймгийн музей, соёлын төвийн төлөөлөл;

3.1.5. Газар зохион байгуулалт, барилга, хот төлөвлөлтийн чиглэлийн төлөөлөл;

3.1.6. Барилга, архитектурын чиглэлийн мэргэжлийн эвлэл, холбоо, судлаачийн төлөөлөл.

3.2. Үнэлгээний баг нь ахлагч, нарийн бичгийн даргатай байх ба үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч багийн бүрэлдэхүүний гишүүний тоог тогтооно.

3.3. Үнэлгээний баг нь түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлохдоо түүх, архивын баримт, эх сурвалж, барилга байгууламжийн судлагдсан байдал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр зэрэг судалгаанд тулгуурлана.

3.4. Үнэлгээний багийн гишүүн бүр Урьдчилсан жагсаалтад хамрагдсан барилга байгууламжийг газар дээр нь нягтлан үзэж, барилга байгууламж тус бүрт Зааврын А Хавсралт буюу “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний хуудас”-ын дагуу оноогоор үнэлнэ.

3.5. Үнэлгээний баг нь түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн холбогдох гэрэл зургийг авч баримтжуулна.

Дөрөв. Үйл ажиллагааг тайлагнах

4.1. Үнэлгээний баг нь Зааврын дагуу соёлын өвд хамаарах түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тогтоон, хамгаалалтын түвшингээр нь зэрэглэн үнэлж, журмын 2.1.3 дахь хэсгийн дагуу батлуулахаар харьяалах төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагад танилцуулга, үнэлгээний ажлын тайлан болон дурсгалын жагсаалтыг хүргүүлнэ.

4.2. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, гэрэл зураг зэрэг хэрэглэгдэхүүнийг холбогдох Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулна.

--- о О о ---

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

МУ-ын Засгийн газар, Японы Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ын хамтарсан “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл”-ийн баг 2020 оны 12 дугаар сарын 25-наас 50 хоногийн хугацаанд ажиллаж дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн болно.

Нэг. Төслийн хүрээнд хүрээнд хууль эрх зүйн орчны судалгааг хийхэд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх, бэхжүүлэх тухай ойлголт хууль тогтоомжийн хүрээнд хангалттай, бүрэн дүүрэн зохицуулагдаагүй байна. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хадгалах, хамгаалах, сэргээн завсарлах, хүчитгэх, бэхжүүлэх зэрэг асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж нь хоорондоо харилцан уялдаагүй хийдэлтэй байгааг барилгын болон соёлын асуудал хариуцсан салбарын яамдын бүтцийн оновчгүй, байнга өөрчлөлтөд өртөж байсан явдалтай шууд холбоотой гэж үзэж байна. Тиймээс холбогдох хууль тогтоомжийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хууль эрх зүйн орчныг сайжруулах саналын төслийг боловсрууллаа.

Хоёр. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Барилгын тухай хууль”, “Хот байгуулалтын тухай хууль”, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль”, “Орон сууцны тухай хууль” болон бусад холбогдох хууль, журам, норм, нормативыг судалж, олон улсын конвенци, дүрэм, зарчимд нийцүүлэн дараах эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулсан болно. Үүнд:

1. “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журам”;
2. “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар”;
 (“Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийн үнэлгээний хуудас”, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувийн хэрэг” гэсэн хоёр хавсралттай)
3. “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам”

Гурав. Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор баталсан Улсын хамгаалалтад байх 185, БСШУС-ын сайдын 2020 оны А/161 тоот тушаалаар баталсан Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 607, судалгаагаар авсан Сум, дүүргийн хамгаалалтад байх 3739 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад дүн шинжилгээ хийхэд тэдгээрээс нийт 354 дурсгал нь барилга, архитектурын дурсгал байна. Дээрх жагсаалтад ороогүй 43 дурсгалт барилгыг сонгон “Шинээр хамгаалалтад авах түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн жагсаалт”-ыг дурсгалын нэр; гэрэл зураг; ашиглалтад орсон он; зохиогч архитектор;

архитектурын хэв загвар, бүтээц; тайлбар гэсэн асуулгаар хүснэгтлэн, хамгаалалтад авах зэрэглэл болон ашиглалтад орсон оноор эрэмбэлэн жагсаалтыг боловсрууллаа.

Дөрөв. Улс, аймаг, нийслэл, сум дүүргийн хамгаалалтад хамрагдсан 354 барилга, архитектурын дурсгал, нэмэлт шинээр судалж гаргасан 43 дурсгалт барилга нийт 397 барилга, архитектурын дурсгалын Урьдчилсан жагсаалтыг гаргаж, түүнээс Байгалийн гамшигт (газар хөдлөлт, үер, хүчтэй шуурга, гал түймэр г.м) үзэгдлийн мужлал, бүсэд байрладаг эсэх; Нурах, эвдрэх аюул, эрсдэл үүссэн эсэх; Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэл үүссэн эсэх; Аялал жуулчлал, эдийн засгийн ач холбогдолтой байдал; Ашиглалтын шаардлага хангахгүй байдал гэсэн үзүүлэлтээр хүчитгэх шаардлага үүссэн 69 дурсгалыг сонгон жагсаалтыг гаргалаа.

Тав. Төслийн хүрээнд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэр дээр орших улсын хамгаалалтад байдаг Чойжин ламын сүм музейн барилга (1904-1908), Баянзүрх дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэр дээр орших “Монголор” (1903-1905) хэмээх түүхэн барилга буюу “Монг-Эм” ХХК-ийн эмнэлэгийн барилга дээр “Тоосгон барилгын газар хөдлөлт тэсвэрлэлт”-ийн тооцооны схем ашиглан газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээг хийж, дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1. Чойжин ламын сүмийн барилгын өрөгт ханын бат бэх бага тул хана өөрийн болон өөрийн бус хавтгайд газар хөдлөлт тэсвэрлэлт хангахгүй байна. Иймд ханын даах чадварыг сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай.
2. “Монголор” түүхэн барилгын гадна даацын ханыг өөрийн даацат хана байхаар бүтээц төлөвлөлтийг өөрчилсөн тул өөрийн хавтгайд ханын газар хөдлөлт тэсвэрлэлт хангалттай. Дотор хучилтыг буулгаж, шинээр хийх хучилттай холбосон бүтээц төлөвлөөгүй тул ханын өөрийн бус хавтгайд газар хөдлөлт тэсвэрлэлт хангалтгүй гарсан тул хучилтын түвшинд хананд холбох шаардлагатай.

Зургаа. “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар”-ын төслийн Хавсралт дахь “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үнэлгээний хуудас”-ын дагуу Чойжин ламын сүм музей, Улаанбаатар хотын музей, “Гоожингийн өндөр” хэмээх барилга, Дуурь бүжгийн эрдмийн театр, Хүүхдийн урлан бүтээр төв гэсэн таван дурсгалт барилгыг сонгож, газар дээр нь очиж үзэн нөхцөл байдлын судалгааг хийж түүх, соёлын дурсгалт барилга байгууламжаар тодорхойлох 7 шалгуур, 24 үзүүлэлтээр оноогоор үнэлж туршилт хийлээ.

*Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх
замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл
Төгсгөлийн тайлан*

Долоо. Төслийн хүрээнд боловсруулсан дээрх журам, заавар, жагсаалтыг Барилга, хот байгуулалтын яам, Соёлын яам хянан үзэж холбогдох хуулиудад өөрчлөлт хийх, хамтран баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.

--- о О о ---